

Улсын бүртгэлийн
дугаар:

Нууцын зэрэглэл: А

Аравтын бүрэн
ангиллын код:

Төсөл хэрэгжүүлэх гэрээний
дугаар: ШуУз-2018/16

“ЭС АЙ СИ ЭЙ” ХХК

**“ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН
САЛБАРЫН СТАТИСТИКИЙН
ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙГ ОЛОН УЛСЫН
СТАНДАРТАД НИЙЦҮҮЛЭХ НЬ”**

Шинжлэх ухаан технологийн төслийн тайлан

2018-2020

Боть (1)

Төслийн удирдагч:

П.ЦЭРЭНБАЗАР-доктор (Ph.D),
“Эс Ай Си Эй” ХХК-ийн Хөгжлийн
төслийн газрын захирал

Санхүүжүүлэгч байгууллага:

Шинжлэх ухаан технологийн сан

Захиалагч байгууллага:

Боловсрол, шинжлэх ухааны яам

Тайлан өмчлөгч:

“ЭС АЙ СИ ЭЙ” ХХК

Улсын бүртгэлийн
дугаар:

Нууцын зэрэглэл: А

Аравтын бүрэн
ангиллын код:

Төсөл хэрэгжүүлэх гэрээний
дугаар: ШуУз-2018/16

“ЭС АЙ СИ ЭЙ” ХХК

**“ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН
САЛБАРЫН СТАТИСТИКИЙН
ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙГ ОЛОН УЛСЫН
СТАНДАРТАД НИЙЦҮҮЛЭХ НЬ”**

Шинжлэх ухаан технологийн төслийн тайлан

2018-2020

Боть (1)

Төслийн удирдагч:

П.ЦЭРЭНБАЗАР-доктор (Ph.D),
“Эс Ай Си Эй” ХХК-ийн Хөгжлийн
төслийн газрын захирал

Санхүүжүүлэгч байгууллага:

Шинжлэх ухаан технологийн сан

Захиалагч байгууллага:

Боловсрол, шинжлэх ухааны яам

Тайлан өмчлөгч:

“ЭС АЙ СИ ЭЙ” ХХК, Монгол улс,
Улаанбаатар хот, Сүхбаатар
дүүрэг, 8-р хороо, Бага тойруу,
Ж.Самбуугийн гудамж, БлюМон
төвийн 7 давхар,

Утас: 7012-6009

information@sica.mn

Улаанбаатар хот, 2020он

АГУУЛГА

АГУУЛГА	1
ХҮСНЭГТ, ЗУРГИЙН ЖАГСААЛТ	3
ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР	7
ӨМНӨТГӨЛ	8
НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ	9
1.1 ШУТ-ийн статистикийг хөгжүүлэх хэрэгцээ, шаардлага, үндэслэл.....	9
1.1.1 Хэрэгцээ, шаардлага	9
1.1.2 Үндэслэл.....	10
1.2 Хууль, эрх зүйн орчин.....	10
1.3 Судалгааны ажлын зорилго, зорилт	12
1.4 ШУТ-ийн статистикийг хөгжүүлэх үйл ажиллагааны зарчим	13
ХОЁР. ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН СТАТИСТИКИЙН ОДООГИЙН МӨРДӨЖ БҮЙ МАЯГТУУДАД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ	14
2.1 ШУТ-ийн статистикийн өнөөгийн байдал.....	14
2.2 ШУТ-ийн статистикийн маягтуудад хийсэн шинжилгээ, харьцуулалт.....	18
2.2.1 Олон улсын маягтын шинжилгээ	18
2.2.2 Маягтуудын харьцуулалтын шинжилгээ.....	22
ГУРАВ. ШУТ-ИЙН САЛБАРТ ХАМААРАХ ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЗОРИЛГЫН ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙГ ТООЦОХ НЬ	30
ДӨРӨВ. ШУТ-ИЙН МЭДЭЭЛЛИЙН УРСГАЛ, ТУРШИЛТ СУДАЛГАА, МАЯГТ, ЗААВАР БОЛОН СТАТИСТИКИЙН МЭДЭЭЛЛИЙН АРГА ЗҮЙ, АРГАЧЛАЛЫН ЗӨВЛӨМЖ	34
4.1 ШУТ-ийн статистикийн мэдээллийн урсгал.....	34
4.2 Туршилт судалгааны тухай	36
4.3 ШУТ-ийн статистикийн маягтад өөрчлөлт оруулах санал.....	39
4.4 Шинжлэх ухаан технологи, статистикийн үндсэн үзүүлэлтүүдийг тооцох аргачлал..	60
4.4.1 Нийтлэг үндэслэл.....	60
4.4.2 Ойлголт тодорхойлолт	61
4.4.3 Хамрах хүрээ, мэдээллийн эх үүсвэр.....	71
4.4.4 Үндсэн үзүүлэлтийг тооцох арга зүй.....	72
4.4.5 Үр дүнг ашиглах.....	84
4.4.6 ШУТ-ийн үндсэн үзүүлэлтийг тооцох аргачлалын хүрээ.....	85
ТАВ. ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН САЛБАРЫН СТАТИСТИК МЭДЭЭЛЛИЙГ ТАРХААХ НЬ	96
ЗУРГАА. СУДАЛГАА ХӨГЖҮҮЛЭЛТИЙН АЖЛЫН ФРАСКАТИЙН ГАРЫН АВЛАГЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗӨВЛӨМЖ	99
6.1 Фраскатийн гарын авлагын тухай.....	99
6.2 Фраскатийн гарын авлагыг хэрэгжүүлэхэд анхаарах асуудал.....	100
6.3 Судалгаа хөгжлийн ажлын Фраскатийн гарын авлагыг хэрэгжүүлэх зөвлөмж	101
ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ	117
АШИГЛАСАН МАТЕРИАЛ	120

ХАВСРАЛТ.....	120
Хавсралт 1. Шинээр мөрдөхөөр санал болгож буй ШУТ маягт.....	120
Хавсралт 2. Одоогийн мөрдөгдөж буй ШУТ маягт.....	136
Хавсралт 3. Маягт нөхөх заавар.....	143
Хавсралт 4. ШУТ-ийн статистикийн мэдээллийн хүрээ.....	188
Хавсралт 5. Саналын протокол.....	241
Хавсралт 6. ШУТ-ийн статистикийн мэдээллийг тархаах нь.....	257
Хавсралт 7. СХА явуулдаг байгууллагуудын жагсаалт.....	309
Хавсралт 8. ЮНЕСКО-ийн ШУТ-ийн маягт.....	311
Хавсралт 9. Финлянд Улсын ШУТ-ийн маягт.....	323
Хавсралт 10. Мальт Улсын ШУТ-ийн маягт.....	329
Хавсралт 11. Туршилт судалгааны материалууд.....	337

ХҮСНЭГТ, ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Шинжлэх ухааны салбарын үндсэн үзүүлэлт	14
Хүснэгт 2. Үйл ажиллагаа явуулж буй ШУТ-ийн салбарт хамаарах ААНБ-ийн мэдээлэл	16
Хүснэгт 3. Финлянд Улсын ШУТ-ийн маягтууд.....	18
Хүснэгт 4. Мальт Улсын ШУТ-ийн маягтууд.....	18
Хүснэгт 5. ЮНЕСКО болон Монгол Улсын ШУТ маягтын харьцуулалтын нэгтгэл хүснэгт	20
Хүснэгт 6. ШУТ Маягт 1.1. Эрхэлж буй ЭШТЗБА-ын төрөл	22
Хүснэгт 7. ШУТ Маягт 1.2. ЭШБ, шинжлэх ухааны салбар	22
Хүснэгт 8. ШУТ Маягт 1.3. ЭШБ-ын төрөл.....	22
Хүснэгт 9. ШУТ Маягт 2.1. СХА-ын ажиллагчид.....	22
Хүснэгт 10. ШУТ Маягт 2.2. СХА-ын ажиллагчид, албан тушаалаар	23
Хүснэгт 11.ШУТ Маягт 3.1. Эрдмийн зэрэг цолтой үндсэн ажиллагчид	23
Хүснэгт 12.ШУТ Маягт 3.2. Эрдмийн зэрэг цолтой үндсэн ажиллагчид, насны ангиллаар	24
Хүснэгт 13.ШУТ Маягт 4. Эрдмийн зэрэгтэй үндсэн ажиллагчид, ШУ-ны салбараар	24
Хүснэгт 14. Судлаачид, ШУ-ны салбараар.....	25
Хүснэгт 15.ШУТ Маягт 5.1. ЭШТЗБА-ын зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрээр	25
Хүснэгт 16.ШУТ Маягт 5.2. Нийт зардал.....	25
Хүснэгт 17.ШУТ Маягт 5.3. Хөрөнгө оруулалт.....	26
Хүснэгт 18. ШУТ Маягт 5.4. ЭШТЗБА-ын хөрөнгийн дүн.....	26
Хүснэгт 19. ШУТ Маягт 6. ЭШТЗБА-ын үр дүн	27
Хүснэгт 20.ШУТ Маягт 7. ЭШТЗБА-ын тоо, зардал (захиалагчийн ангиллаар)	27
Хүснэгт 21.ШУТ Маягт 8. Материаллаг бааз.....	27
Хүснэгт 22.ЭШТЗБА-ын зардал, СХА-ын төрлөөр.....	28
Хүснэгт 23. ЭШТЗБА-ын зардал, Нийгэм, эдийн засгийн салбараар (Мальт)	28
Хүснэгт 24. Хөрөнгө оруулалтын эх үүсвэр, гадаад орны Санхүүгийн байгууллагын төрлөөр (Мальт)	28
Хүснэгт 25. СХА-ын судлаачид, иргэншлээр.....	28
Хүснэгт 26. ТХЗ-ийг тооцох арга зам	30
Хүснэгт 27. ДНБ-д судалгаа, хөгжлийн салбарын зардлын эзлэх хувь	32
Хүснэгт 28. ДДӨТАҮ-д хамаарах боловсруулах салбарын үйлдвэрлэл ISIC 4.0.....	32
Хүснэгт 29. ШУТ-ийн статистикийн маягтууд, БСШУ-ы сайдын 2003 оны 221-р тушаал.....	34
Хүснэгт 30. Судалгаа хөгжүүлэлтийн ажил эрхэлдэг байгууллагуудын жагсаалт	36
Хүснэгт 31. Санал болгож буй маягт ШУТ-1 маягт II.Хүний нөөцийн мэдээлэл, боловсролын зэргээр, ажил мэргэжлийн ангиллаар, шинжлэх ухааны салбараар, насаар	40
Хүснэгт 32. Санал болгож буй маягт ШУТ-1 маягт III.Хүний нөөцийн мэдээлэл, хүйсээр, боловсролын зэргээр, насаар, шинжлэх ухааны салбараар, ажил мэргэжлийн ангиллаар	41
Хүснэгт 33. Санал болгож буй маягт ШУТ-2 маягт I.СХА-ын зардал.....	46
Хүснэгт 34. Санал болгож буй маягт ШУТ-3 маягт, II.СХА-ын санхүүжилт, эх үүсвэрээр, СХА-ын төрлөөр.....	50
Хүснэгт 35. Санал болгож буй маягт ШУТ-3 маягт, III.СХА-ын санхүүжилт, шинжлэх ухааны салбараар.....	52
Хүснэгт 36. Санал болгож буй маягт ШУТ-4 Судалгаа хөгжүүлэлтийн ажлын үр дүн.....	55
Хүснэгт 37. Санал болгож буй маягт ШУТ-5 СХА-ын хөрөнгийн бүртгэл, тоо хэмжээ, хүчин чадлаар	57
Хүснэгт 38. ШУТ-ийн үндсэн үзүүлэлтийг тооцох аргачлалын хүрээ.....	85
Хүснэгт 39. Эрдэм шинжилгээ, судалгааны байгууллагын тоо (одоогийн мөрдөгдөж буй).....	257
Хүснэгт 40. Эрдэм шинжилгээний байгууллагын тоо, өмчийн хэлбэрээр, салбараар, (санал болгож буй).....	257
Хүснэгт 41. Эрдэм шинжилгээний байгууллагын тоо, хариуцлагын хэлбэрээр (санал болгож буй).....	258
Хүснэгт 42. Эрдэм шинжилгээний байгууллагын тоо, байгууллагын ангиллаар (санал болгож буй)	258
Хүснэгт 43. Шинжлэх ухааны салбарын статистикийн мэдээнд хамрагдсан байгууллагын тоо, сүүлийн 4 жилээр, (одоогийн мөрдөгдөж буй)	258
Хүснэгт 44. Шинжлэх ухааны салбарын статистикийн мэдээнд хамрагдсан байгууллагын тоо, сүүлийн 4 жилээр, өмчийн хэлбэрээр, салбараар (санал болгож буй).....	258

Хүснэгт 45. Шинжлэх ухааны салбарын статистикийн мэдээнд хамрагдсан байгууллагын тоо, сүүлийн 4 жилээр, хариуцлагын хэлбэрээр (санал болгож буй).....	259
Хүснэгт 46. Шинжлэх ухааны салбарын статистикийн мэдээнд хамрагдсан байгууллагын тоо, сүүлийн 4 жилээр, байгууллагын ангиллаар (санал болгож буй).....	259
Хүснэгт 47. Ажиллагчдын тоо, (одоогийн мөрдөгдөж буй).....	259
Хүснэгт 48. Шинжлэх ухаан, технологийн ажиллагчид, (санал болгож буй).....	260
Хүснэгт 49. Шинжлэх ухааны салбарын ажиллагчдын тоо, сүүлийн 4 жилээр, (одоогийн мөрдөгдөж буй)	260
Хүснэгт 50. Шинжлэх ухаан, технологийн ажиллагчид, ажил мэргэжлийн ангиллаар, хүйсээр, сүүлийн 4 жилээр, (санал болгож буй)	260
Хүснэгт 51. Санхүүжилт (тэрбум төгрөг), (одоогийн мөрдөгдөж буй).....	260
Хүснэгт 52. Санхүүжилт, мянган төгрөгөөр, (санал болгож буй).....	261
Хүснэгт 53. Шинжлэх ухааны салбарын санхүүжилтийн хэмжээ (сүүлийн 4 жилээр), (одоогийн мөрдөгдөж буй).....	261
Хүснэгт 54. Шинжлэх ухааны салбарын санхүүжилтийн хэмжээ, мянган төгрөгөөр, сүүлийн 4 жилээр, (санал болгож буй).....	262
Хүснэгт 55. Судалгааны ажлын тоо, үр дүн, (одоогийн мөрдөгдөж буй).....	262
Хүснэгт 56. Судалгааны ажлын тоо, үр дүн, (санал болгож буй).....	263
Хүснэгт 57. Судалгааны ажлын үр дүн, үр ашиг/үнэлгээ, мянган төгрөгөөр, (санал болгож буй)	263
Хүснэгт 58. Шинжлэх ухааны салбарын судалгааны ажлын тоо (сүүлийн 4 жилээр), (одоогийн мөрдөгдөж буй)	264
Хүснэгт 59. 4.1. Шинжлэх ухааны салбарын нэгдсэн үзүүлэлт, (одоогийн мөрдөгдөж буй)	264
Хүснэгт 60. 4.1. Шинжлэх ухааны салбарын нэгдсэн үзүүлэлт, (санал болгож буй).....	265
Хүснэгт 61. 4.2. Эрдэм шинжилгээ, судалгааны байгууллагууд (нэр, төрөл, үйл ажиллагааны чиглэл, шинжлэх ухааны салбараар), (одоогийн мөрдөгдөж буй).....	266
Хүснэгт 62. 4.2. Эрдэм шинжилгээ, судалгааны байгууллагууд (нэр, төрөл, үйл ажиллагааны чиглэл, шинжлэх ухааны салбараар), (санал болгож буй).....	266
Хүснэгт 63. 4.2. Эрдэм шинжилгээ, судалгааны байгууллагууд (нэр, төрөл, үйл ажиллагааны чиглэл, хариуцлагын хэлбэрээр), (санал болгож буй).....	267
Хүснэгт 64. 4.2. Эрдэм шинжилгээ, судалгааны байгууллагууд (нэр, төрөл, үйл ажиллагааны чиглэл, өмчийн хэлбэрээр), (санал болгож буй).....	268
Хүснэгт 65. 4.3. Эрдэм шинжилгээ, судалгааны байгууллагын тоо (үйл ажиллагааны чиглэл, шинжлэх ухааны салбар, байгууллагын төрлөөр), (одоогийн мөрдөгдөж буй).....	268
Хүснэгт 66. 4.4. Ажиллагчид (албан тушаал, эрдмийн зэрэг, цол, хүйс, насны ангиллаар), (одоогийн мөрдөгдөж буй).....	269
Хүснэгт 67. 4.4. Ажиллагчид (албан тушаал, эрдмийн зэрэг, цол, хүйс, насны ангиллаар), (санал болгож буй).....	270
Хүснэгт 68. 4.5. Ажиллагчид (албан тушаал, эрдмийн зэрэг, цол, шинжлэх ухааны салбараар), (одоогийн мөрдөгдөж буй)	271
Хүснэгт 69. 4.5. Ажиллагчид (албан тушаал, эрдмийн зэрэг, цол, шинжлэх ухааны салбараар), (санал болгож буй)	273
Хүснэгт 70. 4.6. Ажиллагчид (албан тушаал, эрдмийн зэрэг, цол, шинжлэх ухааны салбар, насны ангиллаар), (одоогийн мөрдөгдөж буй).....	275
Хүснэгт 71. 4.6. Ажиллагчид (албан тушаал, эрдмийн зэрэг, цол, шинжлэх ухааны салбар, насны ангиллаар), (санал болгож буй)	276
Хүснэгт 72. 4.7. Эрдмийн зэрэг, цолтой үндсэн ажиллагчид (хүйс, насны ангиллаар), (одоогийн мөрдөгдөж буй)	279
Хүснэгт 73. 4.7. Үндсэн ажиллагчид, боловсролын зэргээр, хүйс, насны ангиллаар, (санал болгож буй)	279
Хүснэгт 74. 4.8. Ажиллагчид (албан тушаал, эрдмийн зэрэг, цол, шинжлэх ухааны салбар, насны ангиллаар), (одоогийн мөрдөгдөж буй)	280

Хүснэгт 75. 4.8. Ажиллагчид (боловсролын зэрэг, шинжлэх ухааны салбар, насны ангиллаар), (санал болгож буй)	281
Хүснэгт 76. 4.9. Эрдмийн зэрэгтэй үндсэн ажиллагчид (хүйс, шинжлэх ухааны салбараар), (одоогийн мөрдөгдөж буй)	283
Хүснэгт 77. 4.10. Эрдэм шинжилгээ, туршилт, зохион бүтээх ажлын тоо, зардал (захиалгын ангиллаар), (одоогийн мөрдөгдөж буй)	283
Хүснэгт 78. 4.10. СХА-ын тоо, зардал, мянган төгрөгөөр (захиалагчийн ангиллаар), (санал болгож буй)	283
Хүснэгт 79. 4.11. Эрдэм шинжилгээ, туршилт, зохион бүтээх ажлын тоо (шинжлэх ухааны салбар, байгууллага, захиалгын ангиллаар), (одоогийн мөрдөгдөж буй).....	285
Хүснэгт 80. 4.11. СХА-ын тоо (шинжлэх ухааны салбар, байгууллага, захиалгын ангиллаар), (санал болгож буй)	286
Хүснэгт 81. 4.12. Эрдэм шинжилгээ, туршилт, зохион бүтээх ажлын зардал (шинжлэх ухааны салбар, байгууллага, захиалгын ангиллаар), (одоогийн мөрдөгдөж буй).....	287
Хүснэгт 82. 4.12. СХА-ын зардал (шинжлэх ухааны салбар, байгууллага, захиалгын ангиллаар), (санал болгож буй)	288
Хүснэгт 83. 4.13. Эрдэм шинжилгээ, туршилт, зохион бүтээх ажлын үр дүн (нэр төрөл, тоогоор), (одоогийн мөрдөгдөж буй)	289
Хүснэгт 84. СХА-ын ажлын үр дүн, үр ашиг/үнэлгээ, мянган төгрөгөөр, (санал болгож буй)	289
Хүснэгт 85. 4.14. Эрдэм шинжилгээ, туршилт, зохион бүтээх ажлын үр дүн (шинжлэх ухааны салбар, нэр төрөл, тоогоор), (одоогийн мөрдөгдөж буй)	291
Хүснэгт 86. 4.14. СХА-ын үр дүн, шинжлэх ухааны салбараар, үр ашиг/үнэлгээ, мянган төгрөгөөр, (санал болгож буй)	293
Хүснэгт 87. 4.15. Төсвийн зардлын гүйцэтгэл (...санхүүгийн жил, зардлын нэр төрлөөр), (одоогийн мөрдөгдөж буй)	295
Хүснэгт 88. 4.15. Төсвийн зардлын гүйцэтгэл, мянган төгрөгөөр (...санхүүгийн жил, зардлын нэр төрлөөр), (санал болгож буй)	296
Хүснэгт 89. 4.16. Төсвийн зардлын гүйцэтгэл (...санхүүгийн жил, зардлын нэр төрөл, шинжлэх ухааны салбараар), (одоогийн мөрдөгдөж буй).....	297
Хүснэгт 90. 4.16. Төсвийн зардлын гүйцэтгэл (...санхүүгийн жил, зардлын нэр төрөл, шинжлэх ухааны салбараар) (үргэлжлэл), (одоогийн мөрдөгдөж буй).....	298
Хүснэгт 91. 4.16. Төсвийн зардлын гүйцэтгэл (...санхүүгийн жил, зардлын нэр төрөл, шинжлэх ухааны салбараар)(үргэлжлэл), (одоогийн мөрдөгдөж буй).....	299
Хүснэгт 92. 4.16. Төсвийн зардлын гүйцэтгэл (...санхүүгийн жил, зардлын нэр төрөл, шинжлэх ухааны салбараар)(үргэлжлэл), (одоогийн мөрдөгдөж буй).....	300
Хүснэгт 93. 4.16. Төсвийн зардлын гүйцэтгэл, мянган төгрөгөөр, санхүүгийн жил, зардлын нэр төрөл, шинжлэх ухааны салбараар, (санал болгож буй).....	301
Хүснэгт 94. Судалгаа хөгжүүлэлтийн ажлын хөрөнгө, гүйцэтгэлээр.....	302
Хүснэгт 95. Судалгаа хөгжүүлэлтийн ажлын хөрөнгө, байгууллагын ангиллаар.....	304
Хүснэгт 96. Эрдэм шинжилгээний байгууллага, өмчийн хэлбэрээр.....	306
Хүснэгт 97. Шинжлэх ухааны салбарын бүтэн цагийн ажиллагчид, боловсролын зэргээр.....	306
Хүснэгт 98. Шинжлэх ухааны салбарын бүтэн цагийн ажиллагчид, шинжлэх ухааны салбараар.....	306
Хүснэгт 99. Шинжлэх ухааны салбарын үндсэн ажиллагчид, шинжлэх ухааны салбараар, насны бүлгээр.....	306
Хүснэгт 100. СХА-ын үр дүн, төрлөөр.....	307
Хүснэгт 101. Шинжлэх ухааны салбарын санхүүжилтийн эх үүсвэр.....	307
Хүснэгт 102. Улсын төсвөөс санхүүжүүлсэн төсөв шинжлэх ухаан, технологийн зардал, СХА-ын төрлөөр.....	308
Хүснэгт 103. Улсын төсвөөс санхүүжүүлсэн төсөв шинжлэх ухаан, технологийн зардал, шинжлэх ухааны салбараар.....	308

Зураг 1. ШУТ-ийн салбарын үндсэн үзүүлэлтийн харьцуулалт.....	15
Зураг 2. ШУТ салбарын статистикийн мэдээллийн урсгал	34
Зураг 3. Санал болгож буй маягт ШУТ-2 маягт III.СХА-ын тоо, зардал, шинжлэх ухааны салбараар, СХА-ын төрлөөр.....	47
Зураг 4.Боловсрол, шинжлэх ухаан, соёл, урлагийн статистикийн мэдээллийн урсгал	96
Зураг 5. ШУТ-ийн статистикийн мэдээллийн урсгал	97

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

БОУСА	Боловсролын олон улсын стандартын ангилал
БЦАХТШУ	Бүтэн цагаар ажилласан хүний тоонд шилжүүлсэн утга
БШУЯ	Боловсрол, шинжлэх ухааны яам
ДББЗХ	Дээд боловсролын байгууллагын зардлын хэмжээ
ДНЗХ	Дотоодын нийт зардлын хэмжээ
ДНЗСХСЗЭХ	Дотоодын нийт зардалд суурь, хэрэглээний судалгааны зардлын эзлэх хувь
ДӨТАУ	Дундаж болон өндөр технологийн аж үйлдвэр
ДСХАНЗТСЭХ	Дотоодын судалгаа хөгжүүлэлтийн ажлын нийт зардалд төсвийн санхүүжилтийн эзлэх хувь
ИДС	Их, дээд сургууль
ЗГСХ	Засгийн газрын санхүүжилтийн хэмжээ
НАНЗ	Нэг ажилтанд ногдох зардал
ҮСХ	Үндэсний статистикийн хороо
СБХСЗХ	Суурь болон хавсарга судалгааны зардлын хэмжээний нийлбэр
СХА	Судалгаа хөгжүүлэлтийн ажил
ТБЭҮХ	Төсвийн бус эх үүсвэрийн хэмжээ
ТСШУЗЭХ	Тухайн салбар шинжлэх ухааны зардлын эзлэх хувь
ТХЗ	Тогтвортой хөгжлийн зорилт
ШУТА	Шинжлэх ухаан, технологийн ангилал
ШУТИ	Шинжлэх ухаан, технологи, инновац
ШУТҮА	Шинжлэх ухаан, технологийн үйл ажиллагаа
ШУТБС	Шинжлэх ухаан, технологийн боловсрол сургалт
ШУТҮ	Шинжлэх ухаан, технологийн үйлчилгээ
ШУЗЭХ	Шинжлэх ухааны зардалд эзлэх хувь
ЭЗХАХБ	Эдийн засгийн хамтын ажиллагааны хөгжлийн байгууллага
ЭШТЗБА	Эрдэм шинжилгээ, туршилт, зохион бүтээх ажил
ЭЗҮАСОУСА	Эдийн засгийн үйл ажиллагааны салбарын олон улсын стандарт ангилал

ӨМНӨТГӨЛ

Энэхүү зөвлөх үйлчилгээний ажлыг “Эс Ай Си Эй” ХХК-ийн судалгааны баг хийж гүйцэтгэв. Ажлыг гүйцэтгэхэд арга зүйн болон санхүүгийн дэмжлэг үзүүлсэн БШУЯ, ШУТСанд талархал илэрхийлье. Мөн мэдээлэл цуглуулах үйл ажиллагаанд хамтран ажилласан бидний судалгаанд үнэт мэдээлэл өгсөн Шинжлэх ухааны академи, их дээд сургууль болон тэдгээрийн харьяа эрдэм шинжилгээний байгууллагын ажилтнуудад талархлаа илэрхийлье.

ХЭРЭГЖҮҮЛСЭН БАЙГУУЛЛАГА:

Судалгаа, шинжилгээний “Эс Ай Си Эй” (SICA) ХХК

ЗАХИАЛАГЧ:

Боловсрол, шинжлэх ухааны яам

САНХҮҮЖҮҮЛЭГЧ:

ШУТ Сан

СУДАЛГААНЫ БАГ:

Багийн ахлагч:

П.Цэрэнбазар, Социологич, МУИС-ийн ШУС-ийн багш, доктор

Зөвлөх:

А.Дэмбэрэл, Эдийн засагч-Статистикч, ҮСХ-ны ҮТШСГ-ын дарга, доктор, профессор

Судлаачид:

Б.Лхагважаргал, Эдийн засагч-Статистикч, “Эс Ай Си Эй” ХХК-ийн Ерөнхий захирал, магистр

Г.Эрдэнэ, Эдийн засагч-Статистикч, “Эс Ай Си Эй” ХХК-ийн Судалгааны газрын захирал, магистр

Б.Батсүрэн, Статистикч, “Эс Ай Си Эй” ХХК-ийн Судалгааны газрын ахлах менежер

Т.Пүрэвхүү, Менежмент, “Эс Ай Си Эй” ХХК-ийн Үйл ажиллагааны газрын захирал, магистр

НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

1.1 ШУТ-ИЙН СТАТИСТИКИЙГ ХӨГЖҮҮЛЭХ ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГА, ҮНДЭСЛЭЛ

1.1.1 Хэрэгцээ, шаардлага

Салбарын түүхэн хөгжлийг дэлхийн дахинд авч үзвэл, 1950-иад оны үеэс хөгжиж эхэлсэн бөгөөд түүнээс өмнөх үйлдвэржилтийн эрин үед шинжлэх ухаан, технологийн салбар тийм ч танил салбар биш байлаа. Харин 1963 онд Эдийн засгийн хамтын ажиллагааны хөгжлийн байгууллага (ЭЗХАХБ)-аас уулзалт зохион байгуулж уг уулзалтын үр дүнд Судалгаа хөгжүүлэлтийн ажлын статистикийн асуулгад баримтлах жишиг стандартын албан ёсны эхний хувилбарыг гаргажээ¹. 1981 оноос салбарын мэдээллийг жил бүрээр бүртгэж эхэлсэн бөгөөд цаг хугацаа өнгөрч шинжлэх ухаан, технологийн салбар хөгжихийн хэрээр энэхүү салбарт найдвартай харьцуулалт, хяналт шинжилгээ, үнэлгээ хийх статистикийн илтгэлцүүр улам чухал болсоор байна.

Монгол Улсын хувьд УИХ-аар 1998 онд батлагдсан "Шинжлэх ухаан, технологийн талаар төрөөс баримтлах бодлого"-ын зорилго, зорилтыг хангаж ажилласны үр дүнд тус салбарын үйл ажиллагааны эрх зүйн орчин бүрдэж, оюуны болон материаллаг нөөцийн хувьд тодорхой түвшинд бэхжиж, салбарын бүтэц, зохион байгуулалт, үйл ажиллагаа нь зах зээлийн харилцаанд шилжсэн бөгөөд Монгол Улсын нийгэм, эдийн засгийн хөгжлийг тодорхойлогч тулгуур хүчин зүйлсийн нэг нь шинжлэх ухаан, технологи мөн болохыг нийтээр хүлээн зөвшөөрөх болсон.

ШУТ-ийн статистикийг ЮНЕСКО нь дэлхийн улс орнуудаас хүлээн авч байгаа бөгөөд өдгөө 162 орон тус статистик мэдээллийг бүртгэн хүргүүлж байна. Манай улс ШУТ-ийн хэвлүүлсэн нийтлэлийн тоогоор 121 дүгээрт, ШУТ-ийн зардлын ДНБ-д эзэлж буй хувиар мэдээллээ ирүүлсэн 70 орноос 65 дугаарт тус тус жагсаж байна².

Манай Улсын шинжлэх ухаан, технологийн тоо бүртгэлийн хувьд дараах асуудал тулгарч байна:

- Шинжлэх ухаан, технологийн салбарын статистик, мэдээлэл, шалгуур үзүүлэлтүүд хангалтгүй, хэт ерөнхий;
- Төсвийн бус хөрөнгөөр бий болж байгаа эрдэм шинжилгээ, туршилт зохион бүтээх ажлын талаарх мэдээлэл хангалтгүй
- ЮНЕСКО болон олон улсын байгууллагаас гаргадаг “Шинжлэх ухааны оны эмхэтгэл”-д манай улсын шинжлэх ухаан, технологийн талаар зарим мэдээлэл

¹ 1963 оны 6 дугаар сард ЭЗХАХБ Судалгаа, туршилт хөгжлийн ажлын статистикийн үндэсний мэргэжилтнүүдтэй Италийн Фраскати хотын Vill Falcineri-д уулзалт зохион байгуулсан бөгөөд уг уулзалтын үр дүнд “Судалгаа туршилт, хөгжлийн асуулгад баримтлах жишиг стандарт”-ын албан ёсны эхний хувилбарыг гаргасан байна.

² Дэлхийн дата атлас, Судалгаа хөгжүүлэлтийн статистик, 2018 он, <https://knoema.com/atlas/topics/Research-and-Development/RandD-Expenditure/Scientific-and-technical-journal-articles?baseRegion=MN>

тусгагдаагүй. Манай улсын шинжлэх ухаан, технологийн мэдээлэл олон улсын хэмжээнд бүрэн хэмжээнд мэдээлэгдэхгүй

- Төсвийн хөрөнгөөр гүйцэтгэсэн судалгааны ажлын нэгдсэн мэдээллийн сан бүрэн бус;
- Аж үйлдвэрийн салбарын болон бусад хэрэглэгчдэд шинжлэх ухаан, технологийн үйл ажиллагаа, судалгааны ажлын үр дүнгийн талаарх мэдээлэл хангалттай хүрэхгүй байгаа.

Дээрх асуудал нь ШУТ-ийн салбарын статистик мэдээлэл, шалгуур үзүүлэлтүүд хангалтгүй, хэт ерөнхий байгаатай шууд холбоотой. Үүнээс улбаалж Монгол улсын шинжлэх ухаан, технологийн чадавх, түүний хөгжлийн түвшин, ахицыг дүгнэх боломж хязгаарлагдмал байна.

Шинжлэх ухаан, технологийн статистикийг сайжруулснаар шинжлэх ухаан, технологийн бодлого боловсруулах, шийдвэр гаргах, тэргүүлэх чиглэлийг тодорхойлох, төлөвлөлт хийхэд шаардлагатай мэдээлэл, тоо баримтыг нэгдсэн эх үүсвэрээс хангах боломж бүрдэнэ.

1.1.2 Үндэслэл

Шинжлэх ухаан, технологийн статистикийг хөгжүүлэх нь Монгол Улсад шинжлэх ухаан, технологийн хөгжлийг хангах бодлого, үйл ажиллагааг дэмжих хэрэгсэл болно. Шинжлэх ухаан, технологийн чадавхыг тогтмол, зөв дүгнэж байх нь шинжлэх ухаан, технологийг хөгжүүлэх бодлого, стратегийг оновчтой тодорхойлох улмаар үндэсний эдийн засаг, нийгмийн зорилтуудтай түүнийг уялдуулан хөгжүүлэх, салбарын үйл ажиллагааны үр ашгийг дээшлүүлэхэд чухал ач холбогдолтой.

Олон улсын туршлагаас харахад тухайн орны Шинжлэх ухаан, технологийн чадавхыг тогтмол, зөв дүгнэж байх нь ШУТ-ийг хөгжүүлэх бодлого, стратегийг оновчтой тодорхойлох, арга хэмжээг хэрэгжүүлэх, бүх түвшний хяналт шинжилгээ, үнэлгээ хийхэд зайлшгүй шаардлагатай чухал үйл ажиллагаа, салбарын хөгжлийн бодлогын салшгүй бүрэлдэхүүн хэсэг болдог байна. Дээрх хэрэгцээ, шаардлагаас гадна салбарын үйл ажиллагааны талаар олон нийтэд тогтмол мэдээлэл хүргэж байх, шинжлэх ухаан, технологийн салбарын тухай тэдгээрийн санал, ойлголтыг судлан хөгжлийн бодлого боловсруулахад ашиглах шаардлага зайлшгүй гарч байдаг.

Монгол Улсын хувьд шинжлэх ухаан, технологийн статистикийн үзүүлэлтүүдийг олон улсын нийтлэг жишигт ойртуулах, нэгдсэн ойлголт, арга зүйтэй болох бодит хэрэгцээ шаардлага байна. Мөн түүнчлэн салбарын өсөлт хөгжилтийг бодитой хэмжихүйц статистикийн мэдээллийг цуглуулах, эмхэтгэх ажлыг хийж хэвших, үзүүлэлтүүдийг олон улсын стандартад нийцүүлэх, нөхцөл байдлыг тодорхойлоход бүрэн ойлгомжтой, статистикийн мэдээлэл зайлшгүй хэрэгцээтэй болж байна.

1.2 ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧИН

Монгол Улсын Их Хурал, Монгол Улсын Засгийн Газраас Монгол улсын Шинжлэх ухаан, технологийн хөгжилд чиглэсэн дараах шийдвэрүүдийг гаргасан байдаг. Үүнд:

- Монгол Улсын Их Хурлын 1998 оны 55 дугаар тогтоолын хавсралт, “Шинжлэх ухаан, технологийн талаар төрөөс баримтлах бодлого”
- Монгол Улсын Засгийн Газрын 2017 оны 295 дугаар тогтоолын хавсралт, “Төрөөс шинжлэх ухаан, технологийн талаар баримтлах бодлого”
- Монгол Улсын Их Хурлын 2006 оны 1 дүгээр сарын 19-ний, “Патентийн тухай хууль” шинэчилсэн найруулга.
- Монгол Улсын Их Хурлын 2006 оны 12 дугаар сарын 28-ны өдөр батлагдсан “Шинжлэх ухаан, технологийн тухай хууль” шинэчилсэн найруулга
- Монгол Улсын Их Хурлын 2016 оны 19 дүгээр тогтоол, “Монгол улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”; (2020 оны 5 дугаар сарын 13-нд цуцлагдсан.)
- Монгол Улсын Их Хурлын 2020 оны 01 сарын 23-ны “Оюуны өмчийн тухай хууль”, (Энэ хуулийг 2020 оны 12 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Манай улсад шинжлэх ухаан, технологийг хөгжүүлэх талаар бодлого хөтөлбөрүүдэд дараах зорилтуудыг дэвшүүлсэн байна.

“Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”, 3.2.1 “Эдийн засгийн олон тулгуурт бүтэц” хэсгийн

- 3.2.1.7-д “Шинжлэх ухааны шинжилгээ, судалгаа, инновацыг стратегийн ач холбогдолтой салбаруудад төвлөрүүлж, эдийн засгийн бүтээмж, өрсөлдөх чадавхыг нэмэгдүүлнэ”,
- 3.2.1.8-д “Өндөр технологийн хөгжлийг дэмжиж, нанотехнологи, биотехнологи, мэдээлэл, харилцаа холбооны технологийн салбарт олон улсын тавцанд өрсөлдөх чадавхыг хөгжүүлнэ” гэж тус тус заасан.

Тогтвортой хөгжлийн зорилт-2030,

- Зорилт 9.5 Бүх улс орнууд, ялангуяа хөгжиж буй орнуудын технологийн чадавхыг дээшлүүлэх, шинжлэх ухааны судалгаа шинжилгээний ажлыг сайжруулах, түүний дотор 2030 он гэхэд инновацыг дэмжих, 1 сая хүн ногдох судалгаа-хөгжлийн ажилтны тоог [х] хувиар нэмэгдүүлэх, судалгаа-хөгжилд зарцуулах төр, хувийн хэвшлийн зардлыг өсгөхөөр тусгасан.

Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030,

2.2.3 “Мэдлэгт суурилсан нийгэм ба ур чадвар бүхий Монгол хүн”-ий

Зорилт 5.Шинжлэх ухаан, үйлдвэрлэлийн харилцан уялдааг хангаж, мэдлэгт суурилсан нийгмийг хөгжүүлнэ.

- **I үе шат (2016-2020):** Инновацыг дэмжиж үйлдвэрлэлд нэвтрүүлэхэд шинжлэх ухааны байгууллага, аж үйлдвэрийн хамтын ажиллагааг өргөжүүлэн, шинжлэх ухаан, технологийн судалгаа, туршин нэвтрүүлэх санхүүжилтийг дотоодын нийт бүтээгдэхүүний 2 хувь хүртэлх түвшинд хүргэх.

- **II үе шат (2021-2025):** Технологи, инновацыг хөгжүүлж, шинжлэх ухаан, технологийн судалгаа, туршин нэвтрүүлэх санхүүжилтийг дотоодын нийт бүтээгдэхүүний 2.5 хувь хүртэлх түвшинд хүргэх.
- **III үе шат (2026-2030):** Технологи, инновацыг хөгжүүлж, шинжлэх ухаан, технологийн судалгаа, туршин нэвтрүүлэх санхүүжилтийг дотоодын нийт бүтээгдэхүүний 3 хувь хүртэлх түвшинд хүргэх.

гэж тусгасан байна.

Шинжлэх ухаан, технологийг 2007-2020 онд хөгжүүлэх мастер төлөвлөгөө (Засгийн газрын 2017 оны 295 дугаар тогтоолын хавсралт)-г батлан хэрэгжүүлж байна.

- Бодлогын зорилго нь шинжлэх ухаан, технологийг Монгол Улсын тогтвортой хөгжлийг хангах, амьдралын чанар, үндэсний чадамж, өрсөлдөх чадварыг дээшлүүлэх үндсэн хүчин зүйл болгон хөгжүүлэхэд оршино.

Монгол Улсын Статистикийн салбарыг 2017-2020 онд хөгжүүлэх үндэсний хөтөлбөрийн

- 2.6.1.5-д “...Шинжлэх ухааны салбарын статистикийн үзүүлэлтийн хүрээ, маягт, зааврыг тогтвортой хөгжлийн үзүүлэлттэй уялдуулан шинэчлэх”,
- 2.6.1.12-д “Шинжлэх ухааны статистикийн үзүүлэлт тооцох аргачлалыг шинээр боловсруулах, батлах, мөрдөх” гэж тус тус заасан.

1.3 СУДАЛГААНЫ АЖЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ

Монгол Улсын Шинжлэх ухаан, технологийн салбарын статистик мэдээллийн урсгалын өнөөгийн байдлыг судлан, дүн шинжилгээ хийж, олон улсын стандарттай харьцуулан үнэлгээ дүгнэлт өгч, цаашид энэ салбарт дагаж мөрдөх статистикийн маягтыг шинэчлэх санал, заавар боловсруулах зарим үзүүлэлтүүдийг шинэчлэн тооцоолох, статистикийн мэдээллийн арга зүй, аргачлалыг батлуулах зөвлөмж боловсруулахад энэхүү төслийн судалгааны зорилго болно.

Төслийн хүрээнд дараах зорилтуудыг дэвшүүлсэн. Үүнд:

1. Шинжлэх ухаан, технологийн статистикийн одоогийн мөрдөгдөж буй маягтуудад дүн шинжилгээ хийх
2. Шинжлэх ухаан, технологийн салбарын статистик үзүүлэлтүүдийг олон улсын стандартад нийцүүлэн тодорхойлох
3. Шинжлэх ухаан, технологийн статистикийн мэдээллийн урсгалыг тодорхойлох
4. Шинжлэх ухаан, технологийн салбарын статистик маягтыг шинэчлэх, санал заавар боловсруулах
5. Шинжлэх ухаан, технологийн статистикийн мэдээллийн арга зүй, аргачлалын зөвлөмж боловсруулах, мэдээллийг тархаах асуудлыг боловсронгуй болгох
6. Шинжлэх ухаан, технологийн статистикийн мэдээллийг тархаах асуудлыг боловсронгуй болгох

7. Эдийн засгийн хамтын ажиллагааны хөгжлийн байгууллагын Фраскатиин гарын авлагыг Монгол Улсад нутагшуулах зөвлөмж гаргах

1.4 ШУТ-ИЙН СТАТИСТИКИЙГ ХӨГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРЧИМ

ШУТ-ийн статистикийн үзүүлэлтүүдийг тооцох, аргачлал, мэдээлэл цуглуулах маягт, зааврыг олон улсын стандартад нийцүүлэн хөгжүүлэх үйл ажиллагаандаа Монгол Улсын Статистикийн тухай хууль, ШУТ-ийн салбарын тухай хууль, зорилт, хөтөлбөрүүд, ЮНЕСКО болон бусад (Финлянд, Мальт) орнуудын статистикийн маягт, асуулгыг суурь болгосон.

Эдгээр улс орнуудад хэрэглэж буй ШУТ-ийн салбарын салбарын статистикийн маягт асуулгыг дараах шалтгааны улмаас суурь болгосон болно. Үүнд:

1. Эдийн засгийн хамтын ажиллагааны байгууллага, ЮНЕСКО-гийн аргачлал, үзүүлэлтүүдтэй илүү тохиромжтой.
2. Маягт асуулгын хувьд хялбар, ойлгомжтой байх шаардлагыг илүү сайн хангасан. Туршилт судалгаанд хамрагдсан их дээд сургууль эрдэм шинжилгээний байгууллагын ажилтнуудын санал, шүүмж, мэдээллийг анхан шатанд бүртгэж бөглөдөг ажилтнуудын санал хүсэлт зэргээс үзэхэд анхан шатанд бөглөхөд ойлгомжтой тодорхой байх, санхүүгийн тайлантай уялддаг байх зэрэг саналууд голлон гарч байлаа.

Бид үйл ажиллагаандаа дараах зарчмыг баримтлан ажиллалаа. Үүнд:

- Шинжлэх ухааны үндэслэлтэй, нэгдсэн арга зүйг ашиглах,
- Бүх ойлголт, тодорхойлолтууд нь оролцогч талуудад /тухайлбал, асуулга боловсруулагчид, мэдээлэл цуглуулагчид болон мэдээлэлд дүн шинжилгээ хийх ажилтнууд/ ойлгомжтой, тодорхой байх,
- Судалгааны үр дүн, тайлан нь тодорхой, ойлгомжтой, бодлого боловсруулахад хэрэглэгдэхүйц байх зэрэг болно.

ХОЁР. ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН СТАТИСТИКИЙН ОДООГИЙН МӨРДӨЖ БУЙ МАЯГТУУДАД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ

2.1 ШУТ-ИЙН СТАТИСТИКИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

2013 онд, БСШУ-ы сайдын 2003 оны 221-р тушаалаар батлагдсан ШУТ-ийн статистикийн маягтуудыг өнөө хүртэл ашиглаж байгаа ба энэхүү маягыг жил бүрийн 2 дугаар сард холбогдох байгууллагууд БШУЯ-нд ирүүлж байна. Энэхүү маягыг манай улсад үйл ажиллагаа явуулж буй их дээд сургууль, ЭШБ болон тэдгээрийн харьяа хүрээлэнгүүд бөглөж ирүүлж байгаа ба хувийн хэвшлийн салбарын хувьд энэхүү мэдээлэлд хамрагддаггүй байна.

Хүснэгт 1. Шинжлэх ухааны салбарын үндсэн үзүүлэлт

Үзүүлэлт	2015	2016	2017	2018	2019
Байгууллагын тоо	59	61	60	59	62
Ажиллагчид	4 125	3 502	4 534	4 277	4 254
Эмэгтэй	2 007	1 701	2 430	2 240	2 126
Салбарын нийт зардал, сая төгрөг	33 276.6	42 173.4	47 554.5	49 393.6	39 415.3

Эх сурвалж. ҮСХ, www.1212.mn

2019 оны мэдээлэл нийт 62 байгууллага хамрагдсан байна. Үүний 5 байгууллага нь хувийн өмчийн эрдэм шинжилгээний байгууллага байгаа бол бусад нь төрийн өмчийн эрдэм шинжилгээний байгууллага байна. Төрийн өмчийн эрдэм шинжилгээний байгууллагуудыг Монгол Улсын шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн 11.2-т заасны дагуу хэлбэрээр нь авч үзвэл: 31 (86.1%) нь эрдэм шинжилгээний хүрээлэн, 5 (13.9%) нь эрдэм шинжилгээний төвийн ангилалд багтаж байна. 2019 оны жилийн эцсийн статистикийн мэдээллээр шинжлэх ухааны салбарт нийт 4254 хүн ажиллаж байгаагийн 2126 (50.0%) нь эмэгтэй ажиллагчид байгаа бол нийт ажиллагчдын 78.8% нь үндсэн, 21.2% нь эрдэм шинжилгээний гэрээт ажиллагчид байна. Үндсэн ажиллагчдын дотор боловсролын доктор 657, шинжлэх ухааны доктор 136, дэд профессор 166, профессор 136, академич 38 байна. Шинжлэх ухааны салбарын нийт санхүүжилт 2019 онд 39.4 тэрбум төгрөг байна. Шинжлэх ухааны салбарын зардлын ДНБ-д эзлэх хувь 2019 онд 0.1 хувь болж өмнөх оноос 0.1 пунктээр буурсан байна.³

Төсвийн бус хөрөнгөөр бий болж байгаа эрдэм шинжилгээ, туршилт зохион бүтээх ажлын талаар мэдээлэл ШУТ сан дээр нэгтгэгдэж байгаа боловч, яам, ШУТ сан, байгууллагуудын мэдээлэл өөр өөр байна. Түүнчлэн ЮНЕСКО болон олон улсын байгууллагаас гаргадаг “Шинжлэх ухааны оны эмхэтгэл”-д манай улсын шинжлэх ухаан, технологийн талаар зарим мэдээлэл тусгагдаагүй байна. Манай улсын шинжлэх ухаан, технологийн мэдээлэл олон улсын хэмжээнд бүрэн хэмжээнд мэдээлэгдэхгүй байна.

³ БШУЯ, Шинжлэх ухааны салбарын товч танилцуулга, 2019 он

БШУЯ нь жил бүр ЮНЕСКО-ийн Статистикийн хүрээлэнгийн асуулгыг бөглөн хүргүүлдэг. 1965 оноос эхлэн ЮНЕСКО нь Статистикийн хэлтсийг байгуулан ШУТИ-ийн өгөгдлийг системтэйгээр цуглуулан, анализ хийх, хэвлэн нийтлэх болсон. 1966 онд гишүүн улс орнуудад анхны туршилтын асуулгыг явуулж, 1969 оноос ШУТ-ийн хүний нөөц, СХА-ийн ажилтны тоо, зардлын талаарх тогтмол асуулга, судалгааг 100 гаруй гишүүн улс орнууд, бүс нутагт зохион байгуулж “ЮНЕСКО-ийн Статистикийн оны ном” (UNESCO Statistical Yearbook), 1999 оноос “ЮНЕСКО-ийн Дэлхийн шинжлэх ухааны тайлан (World Science Report) хэвлэн гаргаж байна. Манай улс ЮНЕСКО-ийн Статистикийн хүрээлэнгийн асуулгыг бүрэн бөглөж хүргүүлснээр дээрх тайлангуудад Монгол Улсын ШУТ-ийн мэдээлэл бүрэн нийтлэгдэх боломжтой болох юм.

Зураг 1. ШУТ-ийн салбарын үндсэн үзүүлэлтийн харьцуулалт



Өнөөдрийн байдлаар ЮНЕСКО-ийн Статистикийн хүрээлэнгийн асуулга нь 1579 үзүүлэлтээс бүрдэх бөгөөд одоо мөрдөгдөж буй ШУТ-ийн статистикийн мэдээллээр 901 үзүүлэлтийг бөглөх боломжтой байгаа бол 678 үзүүлэлтийг бөглөж чаддаггүй байна. Өнөөдөр мөрдөж буй ШУТ-ийн статистикийн маягтын хүрээнд бүтэн цагийн тэнцлээр (FTE) гардаг СХА-ын ажиллагчдын мэдээлэл гарах боломжгүй байгаа ба үүнээс шалтгаалж 678 үзүүлэлтийг бөглөх боломжгүй болгож байна. Мөн түүнчлэн насны ангилал нь ЮНЕСКО-ийн насны ангилалтай зөрдөг учраас тайлан гаргахад хүндрэлтэй байдлыг үүсгэж байгаа ба үүнээс шалтгаалан тодорхой засварлалт хийн бөглөх нөхцөлийг үүсгэж байна. Манай улсын СХА-ын төсвийн зардлын гүйцэтгэлийн маягт нь санхүүгийн тайлангийн маягтаар авдаг учраас шаардлагагүй мэдээлэл ихтэй ба ихэнх мэдээлэл нь огт ашиглагдахгүй байна. Үүнээс шалтгаалан ИДС, хувийн хэвшлийн байгууллагуудын СХА-ын мэдээллийг нэгтгэж чаддаггүй байдал ажиглагдсан. Энэ нь эдгээр байгууллагууд нь нэгдсэн нэг санхүүгийн тайлан гаргадаг ба СХА-ын ажлын санхүүгийн тайлан гэж гаргадаггүй тул анхан шатанд энэхүү үзүүлэлтийг бөглөхөд ихээхэн хүндрэл учирдаг байдал ажиглагдсан.

Манай улсад ШУТ-ийн үндсэн үзүүлэлтүүд зөвхөн дээр дурдсан байгууллагын хүрээнд гарч байна. ЮНЕСКО-д дэлхийн 162 улс орнуудаас судалгаа хүлээн авч байгаа бөгөөд манай улс ШУТ-ийн хэвлүүлсэн нийтлэлийн тоогоор 121 дүгээрт, ШУТ-ийн зардлын

ДНБ-д эзэлж буй хувиар мэдээллээ ирүүлсэн 70 орноос 65 дугаарт тус тус жагсаж байна⁴. Мөн түүнчлэн ТХЗ-ийн 9.5.1 ДНБ-д судалгаа, хөгжлийн салбарын зардлын эзлэх хувь 2018 оны байдлаар 0.41 хувь гарсан байна. ШУТ-ийн статистикийн мэдээллийн хамралтыг сайжруулснаар дээрх үзүүлэлтүүд эрс сайжрах боломжтой гэж үзэж байна. Нэн ялангуяа мэдээлэлд хамрагддаггүй хувийн хэвшлийн ААН-ийг хамруулах талд анхаарал хандуулж энэ чиглэлд тодорхой хэмжээний төсвийг батлуулан ажиллах нь зүйтэй.

ҮСХ-ны бизнес регистрийн сангийн мэдээллээр 2019 оны жилийн эцсийн байдлаар 1811 ААН мэргэжлийн шинжлэх ухаан, техникийн болон судалгааны чиглэлээр үйл ажиллагаа явуулж байна.

Хүснэгт 2. Үйл ажиллагаа явуулж буй ШУТ-ийн салбарт хамаарах ААНБ-ийн мэдээлэл

Эдийн засгийн үйл ажиллагааны салбар	2016-IV	2017-IV	2018-IV	2019-IV
Үйл ажиллагаа явуулж буй нийт	1443	1562	1707	1811
Шинжлэх ухааны эрдэм шинжилгээ, ололт, судалгааны ажил	292	324	355	372
Сурталчилгааны ажил, зах зээлийн судалгаа	345	377	414	457
Мэргэжлийн, шинжлэх ухаан, техникийн ажлын бусад үйл ажиллагаа	806	861	938	982

Эх сурвалж. ҮСХ, www.1212.mn

Эдгээрийн 372 нь шинжлэх ухааны эрдэм шинжилгээ, ололт, судалгааны ажил, 457 нь зах зээлийн судалгаа, шинжилгээ, 982 нь мэргэжлийн шинжлэх ухаан, техникийн бусад үйл ажиллагаа явуулж байна. Эдгээр ААН-үүд бүрэн үйл ажиллагаа хэвийн явуулдаг эсэх болон ШУТ-ийн салбарт хамаарах эсэх нь тодорхойгүй хэдий ч эдгээр ААН-үүдээс ШУТ-ийн салбарын статистик мэдээлэлд хамрагдах шаардлагатай ААН-ийг сонгон жил бүх мэдээнд хамруулах шаардлагатай. Мөн түүнчлэн томоохон ААН-үүд судалгаа, хөгжүүлэлтийн алба, хэлтэстэй байгаа ба эдгээр нь бүртгэгдэхгүй байна.

⁴ Дэлхийн дата атлас, Судалгаа хөгжүүлэлтийн статистик, 2018 он, <https://knoema.com/atlas/topics/Research-and-Development/RandD-Expenditure/Scientific-and-technical-journal-articles?baseRegion=MN>

**ШИНЖЛЭХ УХААН ТЕХНОЛОГИЙН
СТАТИСТИКИЙН ХҮРЭЭ**



2.2 ШУТ-ИЙН СТАТИСТИКИЙН МАЯГТУУДАД ХИЙСЭН ШИНЖИЛГЭЭ, ХАРЬЦУУЛАЛТ

2.2.1 Олон улсын маягтын шинжилгээ

Энэхүү бүлэгт Монгол Улсын одоо мөрдөгдөж буй ШУТ-ийн статистикийн маягтын үзүүлэлтүүдийг ЮНЕСКО болон бусад улс орны (Финлянд, Мальт) маягттай харьцуулан шинжилгээ хийлээ. Эдгээр улсын маягт нь ЭЗХАХБ-аас гаргадаг удирдамж, зааврыг хамгийн сайн хэрэгжүүлсэн, ашиглахад хялбар, энгийн бүтэцтэй байсан тул сонгон шинжлэв.

Финлянд Улс нь ШУТ-ийн статистикийг 10 хүснэгт бүхий 145 үзүүлэлтээр бүртгэдэг байна. Тус маягтад биотехнологийн салбарын СХА-ын зардал болон бизнесийн салбарын бүтээгдэхүүн үйлчилгээ дэх СХА-ын зардлын задаргааг тусад нь тоолдгоороо онцлогтой байна. Мөн 9-р маягтдаа дараа жилийн СХА-ын ажилд зарцуулахаар төлөвлөж буй зардлыг бүртгэдэг байна.

Хүснэгт 3. Финлянд Улсын ШУТ-ийн маягтууд

№	Маягт	Асуулгын маягт	Үзүүлэлт
СХА-ын ажиллагчид, судалгаа хөгжүүлэлтийн ажилд зарцуулсан цагаар		1	-
1	СХА-ын ажиллагчид, боловсролын зэргээр	1.1	18
2	СХА-ын ажиллагчид, ажил мэргэжлээр	1.2	9
3	СХА-ын дотоод зардал	2	5
4	Гадаад судалгаа хөгжүүлэлтийн ажлын зардал	3	8
5	СХА-ын ажиллагчид, хүн/жилээр, СХА-ын зардал байршлаар	4	3
6	СХА-ын зардал, судалгааны ажлын төрлөөр	5	4
7	Биотехнологийн СХА-ын зардал	6	2
8	СХА-ын зардал, санхүүжилтийн эх үүсвэрээр	7	16
9	СХА-ын зардлын задаргаа, бүтээгдэхүүний салбараар (бараа, үйлчилгээ)	8	78
10	Дараа жилийн СХА-ын төлөвлөгөө	9	2
Нийт			145

Мальт Улс нь ШУТ-ийн статистикийг 14 хүснэгт бүхий 215 үзүүлэлтээр бүртгэж байна. СХА-ын ажиллагчид, СХА-ын ажлын зардал, санхүүжилтийн эх үүсвэр гэсэн үндсэн 3 бүлэгт мэдээллийг бүртгэж байна.

Хүснэгт 4. Мальт Улсын ШУТ-ийн маягтууд

№	Маягт	Асуулгын маягт	Үзүүлэлт
СХА-ын ажиллагчид		1	-
1	СХА-ын ажиллагчдын тоо	1.1a	16
2	Хагас цагаар ажилладаг ажиллагчдын тоо, зардал	1.1b	2
3	СХА-ын ажиллагчдын тоо, боловсролын зэрэг болон хүйсээр	1.2	16
4	СХА-ын судлаачдын тоо, боловсролын зэрэг болон хүйсээр	1.3	16
5	СХА-ын судлаачдын тоо, харьяалал, нас болон хүйсээр	1.4	28
6	СХА-ын ажиллагчдын тоо, салбараар	1.5	84
Дотоод СХА-ын ажлын зардал		2	
7	Дотоод СХА-ын ажлын зардал	2.1a	7
8	СХА-ын улсаас гадуурх санхүүжилт	2.1b	2
9	СХА-ын ажлын зардал, салбараар	2.2	6
10	СХА-ын ажлын зардал, нийгэм-эдийн засгийн үзүүлэлтээр	2.3	13
11	СХА-ын ажлын зардал, СХА-ын төрлөөр	2.4	6

Шинжлэх ухаан, технологийн салбарын статистикийн үзүүлэлтүүдийг тооцоолох арга зүй, мэдээлэл цуглуулах маягт, зааврыг олон улсын стандартад нийцүүлэн боловсронгуй болгох нь

СХА санхүүжилтийн эх үүсвэр		3	
12	СХА-ын ажлын санхүүжилтийн эх үүсвэр	3.1	5
13	Санхүүгийн байгууллагуудаас авсан санхүүжилт	3.2	27
14	Тухайлсан СХА-ын зардал	4	3
	Нийт		215

ЮНЕСКО нь дэлхийн улс орнуудаас ШУТ-ийн статистикийн нэгтгэлийг 11 хүснэгт, 1579 үзүүлэлт бүхий асуулгаар бүртгэж байна. Доорх хүснэгтээс харвал манай улс өнөөгийн байдлаар ЮНЕСКО-ийн нийт үзүүлэлтийн 678 буюу 43 хувийг бөглөж байна. Үүнээс СХА-ын нийт зардлыг санхүүгийн тайлангийн маягтаар авдаг учраас шаардлагагүй мэдээлэл ихтэй, ИДС, хувийн хэвшлийн байгууллагуудын СХА-ын мэдээллийг нэгтгэж чаддаггүй учраас СХА-ын зардалтай холбоотой бүх үзүүлэлтүүд нэгтгэгддэггүй байна.

Хүснэгт 5. ЮНЕСКО болон Монгол Улсын ШУТ маягтын харьцуулалтын нэгтгэл хүснэгт

№	ШУТ-ийн үндсэн үзүүлэлтүүд	Асуулгын маягт	Үзүүлэлтийн тоо	ЮНЕСКО статистик мэдээллийн үзүүлэлт	Нийт үзүүлэлтийн тоо	Бөглөж чаддаггүй үзүүлэлтийн тоо	Тайлбар
1	ЭШБ-ын судалгаа (үйл ажиллагааны чиглэл, ШУ-ны салбар, ЭШБ-ын төрлөөр)	ШУТ-1	16	-	-	-	
2	Ажиллагчид (албан тушаал, эрдмийн зэрэг, насны ангилал)	ШУТ-2	52	R2: СХА-ын ажиллагчид /албан тушаал, хүйсээр/	60	30	ШУТ-ийн статистикийн маягтад Бүтэн цагийн тэнцлээр (FTE) гардаг СХА-ын ажиллагчдын мэдээлэл гарах боломжгүй байгаа. Насны ангилал нь ЮНЕСКО-ийн насны ангилалтай зөрдөг учраас тайлан гаргахад хүндрэлтэй
3	Эрдмийн зэрэгтэй үндсэн ажиллагчид (насны ангиллаар)	ШУТ-3	24	R3: СХА-ын ажиллагчид /албан тушаал, ажил эрхлэлт салбараар, хүйсээр/	180	90	
4	Үндсэн ажиллагчид (шинжлэх ухааны салбараар)	ШУТ-4	24	R4: Судлаачид /мэргэшил, ажил эрхлэлт салбараар, хүйсээр/	252	126	
				R5: Судлаачид / ажил эрхлэлт салбараар, СХА-ын салбар, хүйсээр/	360	180	
				R6: Судлаачид / ажил эрхлэлт салбараар, нас, хүйсээр/	288	144	
				R7: Судлаачид / ажил эрхлэлт салбараар, зэрэг дэв, хүйсээр/	216	108	
5	Төсвийн зардлын гүйцэтгэл (зардлын зүйл ангиар)	ШУТ-5	80	R8: СХА-ын нийт зардал /үндэсний мөнгөн тэмдэгтээр, сая ₮-өөр/	1	0	СХ-ийн төсвийн зардлын гүйцэтгэлийн маягт нь балансын маягтаар авдаг учраас шаардлагагүй
				R9: СХА-ын нийт зардал салбарын гүйцэтгэлээр /үндэсний мөнгөн тэмдэгтээр, сая ₮-өөр/	42	0	

				R10: СХА-ын нийт зардал салбарын гүйцэтгэлээр /СХ-ийн салбар, сая ₮-өөр/	60	0	мэдээлэл ихтэй. ИДС, хувийн хэвшлийн байгууллагуудын СХА-ын мэдээллийг нэгтгэж чаддаггүй
				R11: СХА-ын нийт зардал салбарын гүйцэтгэлээр /зардлын төрөл, сая ₮-өөр/	60	0	
				R12: СХА-ын нийт зардал салбарын гүйцэтгэлээр /СХ-ийн салбар, сая ₮-өөр/	60	0	
6	ЭШТЗБА-ын үр дүн (үр дүнгийн төрлөөр)	ШУТ-6	26		0	0	Үр дүнгийн талаарх мэдээлэл авдаггүй
7	ЭШТЗБА-ын тоо, зардал	ШУТ-7	8		0	0	
8	Материаллаг бааз	ШУТ-8	22		0	0	
	Нийт		246		1579	678	

2.2.2 Маягтуудын харьцуулалтын шинжилгээ

Дээр дурдсан 4 маягтын үзүүлэлтүүдийн дэлгэрэнгүй харьцуулалтыг энэ хэсэгт гүйцэтгэсэн бөгөөд үзүүлэлтийн ижил төстэй байдлыг шинжилсэн болохыг анхаарах хэрэгтэй.

Хүснэгт 6. ШУТ Маягт 1.1. Эрхэлж буй ЭШТЗБА-ын төрөл

Монгол	ЮНЕСКО	Финлянд	Мальт
<ul style="list-style-type: none"> • Суурь судалгаа • Хавсарга судалгаа • Туршилт-боловсруулалт, зохион бүтээх • Зураг төсөл • Мэдээлэл, зөвлөгөө, үйлчилгээ • Бусад 	-	-	-

Манай улсын хувьд Эрдэм шинжилгээ, туршилт, зохион бүтээх ажлыг төрлөөр нь 6 хэсэгт хуваан тоолж байна.

Хүснэгт 7. ШУТ Маягт 1.2. ЭШБ, шинжлэх ухааны салбар

Монгол	ЮНЕСКО	Финлянд	Мальт
<ul style="list-style-type: none"> • Байгалийн ухаан • Техник технологи • Хөдөө аж ахуй • Анагаах ухаан • Нийгмийн ухаан 	<ul style="list-style-type: none"> • Байгалийн ухаан • Инженер технологи • Анагаах ухаан • Хөдөө аж ахуй • Нийгмийн ухаан • Хүмүүнлэгийн ухаан 	<ul style="list-style-type: none"> • Байгалийн ухаан • Инженер технологи • Анагаах ухаан • Хөдөө аж ахуй • Нийгмийн ухаан • Хүмүүнлэгийн ухаан • Тодорхойгүй 	<ul style="list-style-type: none"> • Байгалийн ухаан • Инженер технологи • Анагаах ухаан • Хөдөө аж ахуй • Нийгмийн ухаан • Хүмүүнлэгийн ухаан

ЮНЕСКО болон бусад 2 улс шинжлэх ухааны салбарыг үндсэн 6 бүлэгт хувааж байгаа бөгөөд Финлянд Улсын хувьд “Тодорхойгүй” гэсэн ангиллыг оруулан мөрддөг байна. Манай улсын хувьд үндсэн 5 шинжлэх ухааны салбарын ангиллыг мөрдөж байна.

Хүснэгт 8. ШУТ Маягт 1.3. ЭШБ-ын төрөл

Монгол	ЮНЕСКО	Финлянд	Мальт
<ul style="list-style-type: none"> • Хүрээлэн • Төв лаборатори • Нэгдэл корпорац • Их, дээд сургуулийн харьяа ЭШБ, нэгж • Байгууллага, компанийн харьяа ЭШБ, нэгж 	-	-	-

Манай Улс ШУТ-1 маягтад Эрдэм шинжилгээний байгууллагыг үйл ажиллагааны төрөл, шинжлэх ухааны салбар, ЭШБ-ын төрлөөр бүртгэж байна. Харин олон улсад ийм ангилал байхгүй байна.

Хүснэгт 9. ШУТ Маягт 2.1. СХА-ын ажиллагчид

Монгол	ЮНЕСКО	Финлянд	Мальт
<ul style="list-style-type: none"> • Нийт ажиллагчид • Үндсэн ажиллагчид • А.Захиргаа, Аж ахуйн ажилтан 	<ul style="list-style-type: none"> • Нийт ажилтнууд • Үндсэн ажиллагчид • Судлаачид • Техникийн ажиллагчид болон 	<ul style="list-style-type: none"> • Профессор • Их сургуулийн лектор болон Зөвлөх • Докторын оюутнууд • Судлаачид 	<ul style="list-style-type: none"> • Үндсэн ажилтнууд: • Хагас цагийн ажилтнууд: • Судлаачид • Техникийн

• Б.Эрдэм шинжилгээний ажилтан • Эрдэм шинжилгээний гэрээт ажилтан	орлох ажилтнууд • Бусад туслах ажилтнууд • Тодорхойгүй	• Бусад СХА-ын ажилтнууд	ажиллагчид болон орлох ажилтнууд • Бусад туслах ажилтнууд
---	--	--------------------------	--

Манай улс дээрх байдлаар СХА-ын ажиллагчдыг ангилж байна. Харин харьцуулалт хийж буй бусад маягтуудыг харвал Мальт болон ЮНЕСКО-ийн маягтууд ерөнхийдөө ижил үзүүлэлтүүдээр эрдэм шинжилгээний ажиллагчдыг бүртгэсэн байна.

Хүснэгт 10. ШУТ Маягт 2.2. СХА-ын ажиллагчид, албан тушаалаар

Монгол	ЮНЕСКО	Финлянд	Мальт
А.Захиргаа, Аж ахуйн ажилтан: •Удирдах ажилтан, •Инженер техникийн ажилтан Б.Эрдэм шинжилгээний ажилтан: •Тэргүүлэх, •Ахлах, •Дэд, •Дадлагажигч, •Туслах Эрдэм шинжилгээний гэрээт ажилтан: •Бусад ЭШБ-аас, •Их дээд сургууль коллежоос, •ЭШ-ний бус байгууллагаас, •Хувь судлаач	• А ангилал • В ангилал • С ангилал • D ангилал • Тодорхойгүй	-	-

Харин ажиллагчдыг албан тушаалаар авч үзвэл манай улс үйл ажиллагааны төрөл тус бүр ялгаатай албан тушаалаар ангилж байгаа бол ЮНЕСКО-д албан тушаалыг дараах 5 ангиллаар бүртгэж байна. Үүнд:

А ангилал: Судалгааны ажлыг хамгийн өндөр түвшинд хийж гүйцэтгэдэг судлаачид. Жишээ нь: Судалгааны арга зүйч, профессор зэрэг.

В ангилал: Ахлах буюу А ангилалд хамаарагддаггүй ч шинээр мэргэшсэн докторын зэрэгтэй ажиллагчдаас дээд түвшний судлаачид.

С ангилал: Шинээр мэргэшсэн докторууд. Жишээ нь: "Судлаач", "Мөрдөгч", "Туслах профессор" эсвэл "Докторын дараах судлаач".

Д ангилал: ISCED 8 түвшинд судлаачаар суралцаж буй Докторын оюутнууд болон докторын зэрэг шаарддаггүй газар ажиллаж буй судлаачид багтаж байна. Жишээ нь: "Докторын оюутнууд", "Залуу судлаачид" (Докторын зэрэггүй). Мөн магистрын оюутнууд уг ангилалд хамаарагдана.

Хүснэгт 11. ШУТ Маягт 3.1. Эрдмийн зэрэг цолтой үндсэн ажиллагчид

Монгол	ЮНЕСКО	Финлянд	Мальт
•Эрдмийн зэрэг: Шинжлэх ухааны доктор Боловсролын доктор Магистр •Эрдмийн цол: Академич Профессор Дэд профессор	• Доктор буюу түүнтэй дүйцэхүйц (ISCED 8) • Мастер буюу түүнтэй дүйцэхүйц (ISCED 7) • Бакалавр буюу түүнтэй дүйцэхүйц (ISCED 6) • Short-cycle tertiary (ISCED 5) • All other qualifications (ISCED 4 and	• Доктор • Мастер • Бакалавр	• Доктор • Мастер • Дипломын боловсрол

	below) • Тодорхойгүй		
--	-------------------------	--	--

Манай Улсад Эрдэм шинжилгээний ажиллагчдыг эрдмийн зэрэг буюу шинжлэх ухааны доктор, боловсролын доктор, магистр, эрдмийн цол буюу академич, профессор, дэд профессор гэж ангилж байна. Харин олон улсад болон ЮНЕСКО-д зөвхөн боловсролын зэргээр ангилж байна.

Хүснэгт 12. ШУТ Маягт 3.2. Эрдмийн зэрэг цолтой үндсэн ажиллагчид, насны ангиллаар

Монгол	ЮНЕСКО	Финлянд	Мальт
30 хүртэл	25 хүртэл	25 хүртэл	25 хүртэл
31-40	25-34	25-34	25-34
41-50	35-44	35-44	35-44
51-60	45-54	45-54	45-54
60-аас дээш	55-64	55-64	55-64
	65-аас дээш	65-аас дээш	65-аас дээш
	Тодорхойгүй		

Эрдэм шинжилгээний ажиллагчдын насны ангиллыг олон улсад 25 наснаас эхлэн 6 бүлэгт хувааж байгаа бол манай улсад 30 наснаас эхлэн 5 бүлэгт хувааж байна.

Хүснэгт 13. ШУТ Маягт 4. Эрдмийн зэрэгтэй үндсэн ажиллагчид, ШУ-ны салбараар

Монгол	ЮНЕСКО	Финлянд	Мальт
Байгалийн ухаан	-	-	-
Математик, мэдээлэл зүй			
Физик			
Хими			
Геологи, газар зүй			
Биологи			
Экологи			
Бусад			
Техникийн ухаан			
Эрчим хүч			
Холбоо, электроник			
Уул уурхай			
Барилга, архитектур			
Хөнгөн, хүнс			
Металл боловсруулалт			
Машин төхөөрөмж, механик технологи			
Төмөр зам, усан зам, авто тээврийн технологи			
Ноос, ноолуур, арьс шир			
Бусад			
Хөдөө аж ахуйн ухаан			
Мал зүй			
Мал эмнэлэг			
Газар тариалан			
Бэлчээр, ой			
Бусад			
Анагаах ухаан			
Эмнэл зүй			
Эм зүй			
Уламжлалт анагаах ухаан			
Нийгмийн эрүүл мэнд			
Бусад			
Нийгмийн ухаан			
Эдийн засаг			

Философи, социологи Төр, эрх зүй Удирдлагын ухаан Боловсрол судлал Түүх, соёл судлал Хэл шинжлэл, утга зохиол, аман зохиол Бусад			
--	--	--	--

Манай улсад эрдмийн зэрэгтэй үндсэн ажиллагчдыг шинжлэх ухааны дэд салбаруудаар гаргаж байгаа бол олон улсад нийт судлаачдыг зөвхөн шинжлэх ухааны ерөнхий 6 салбараар ангилан бүртгэж байна (Хүснэгт 9).

Хүснэгт 14. Судлаачид, ШУ-ны салбараар

Монгол	ЮНЕСКО	Финлянд	Мальт
-	Байгалийн ухаан болон инженерчлэл Байгалийн ухаан Инженер технологи Анагаах ухаан Хөдөө аж ахуй Нийгэм хүмүүнлэгийн ухаан Нийгмийн ухаан Хүмүүнлэг, соёл урлаг	-	Байгалийн ухаан Инженер технологи Анагаах ухаан Хөдөө аж ахуй Нийгмийн ухаан Хүмүүнлэгийн ухаан

Дээр дурдсанчлан ЮНЕСКО болон Мальт Улсад СХА-ын судлаачдыг шинжлэх ухааны салбараар тоолж байгаа бөгөөд эрдмийн зэргээр гаргадаггүй байна.

Хүснэгт 15. ШУТ Маягт 5.1. ЭШТЗБА-ын зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрээр

Монгол	ЮНЕСКО	Финлянд	Мальт
НЭГ. 1. Төвлөрсөн төсвөөс (ШУТСангаас, Бусад яам, газраас) 2. Орон нутгийн төсвөөс 3. Төрийн өмч давамгайлсан үйлдвэр, ААН-ээс 4. Төрийн бус өмчийн ААН, байгууллагаас 5. Дээд боловсролын сургалтын байгууллагаас 6. Байгууллага, иргэдийн хандив, тусламж 7. Гадаадын сан, байгууллага, иргэдээс 8. Өөрийн үйл ажиллагааны орлогоос (Үндсэн ҮА-аас, Туслах үйл ажиллагаанаас) 9. Бусад эх үүсвэрээс	<ul style="list-style-type: none"> • Бизнесийн байгууллага • Засгийн газар • Дээд боловсрол • Ашгийн бус хувийн • Бусад гадаадын орны хөрөнгө оруулалт • Тодорхойгүй 	<ul style="list-style-type: none"> • Бизнесийн салбар • Засгийн газар • Ашгийн бус хувийн • Дээд боловсролын салбар • Гаднын санхүүжилт 	<ul style="list-style-type: none"> • Бизнесийн байгууллага • Засгийн газар • Дээд боловсрол олгох салбар • Ашгийн бус хувийн байгууллага • Гадаадын хөрөнгө оруулалт

ЭШТЗБА-ын зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрээр авч үзвэл, Монгол Улс зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 9 бүлэгт хуваан мөрдөж байгаа бол бусад 3 маягтын хувьд ерөнхий 5-аас 6 үйл ажиллагааны салбараар хуваасан байна.

Хүснэгт 16. ШУТ Маягт 5.2. Нийт зардал

Монгол	ЮНЕСКО	Финлянд	Мальт
ХОЁР. НИЙТ ЗАРДЛЫН ДҮН 1. Үндсэн ба нэмэгдэл цалин,	<ul style="list-style-type: none"> • Хөдөлмөрийн зардал 	-	Хөдөлмөрийн зардал: /цалин, хөлс,

<p>үүнээс: -Удирдах ажилтны -Эрдэм шинжилгээний үндсэн ажилтны -Инженер техникийн ажилтны -Бусад гүйцэтгэх ажилтны</p> <ol style="list-style-type: none"> 2. Нийгмийн даатгалын шимтгэл 3. Эрүүл мэндийн даатгалын хураамж 4. Гэрэл, цахилгаан 5. Түлш, халаалт 6. Тээвэр (шатахуун) 7. Цэвэр, бохир ус 8. Дотоод албан томилолт 9. Гадаад албан томилолт 10. Ном, хэвлэл 11. Эд хогшил 12. Нормын хувцас, зөөлөн эдлэл 13. Хоол, эм 14. Эрдэм шинжилгээний ажил 15. Урсгал засвар (засвар үйлчилгээ) 16. Байрны түрээс (Түрээсийн төрөл) 17. Төвлөрсөн арга хэмжээний зардал 18. Гаднын байгууллагаар үйлчлүүлсэн 19. Зарлал, сурталчилгаа 20. Хөрөнгийн даатгал 21. Зээлийн хүү 22. Бусад 	<ul style="list-style-type: none"> • Бусад зардал • Газар болон барилгын • Машин, тоног төхөөрөмжийн • Компьютер программ хангамжийн • Оюуны өмчийн бусад бүтээлүүд • Тодорхойгүй 		<p>хүнтэй холбоотой шууд зардал/ Бусад тухайн зардал: /Зөвлөхүүдийн зардал болон материал тоног төхөөрөмжийн зардал/ Капиталын зардал: Газар болон барилга Тоног төхөөрөмж болон хэрэглэгдэхүүн Компьютер программ хангамж Оюуны өмчийн бусад бүтээгдэхүүн</p>
--	---	--	---

СХА-ын нийт зардлыг манай улс нийт 22 бүлэгт буюу хэт нарийвчлан ангилж байна. Харин ЮНЕСКО-д хөдөлмөрийн зардал, капиталын зардал, тухайн зардлууд, машин тоног төхөөрөмжийн, оюуны өмчийн зэрэг тоолж бүртгэхэд ойлгомжтой, хялбар байдлаар ангилсан байна.

Хүснэгт 17. ШУТ Маягт 5.3. Хөрөнгө оруулалт

Монгол	ЮНЕСКО	Финлянд	Мальт
ГУРАВ. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ 1. Барилга, байгууламж 2. Тоног, төхөөрөмж 3. Их засвар 4. Бусад	-	-	-

Хүснэгт 18. ШУТ Маягт 5.4. ЭШТЗБА-ын хөрөнгийн дүн

Монгол	ЮНЕСКО	Финлянд	Мальт
ДӨРӨВ. ХӨРӨНГИЙН ДҮН 1. Үндсэн хөрөнгө 2. Эргэлтийн хөрөнгө	-	-	-

2. Машин, тоног төхөөрөмж	тоогоор	13							
Үүнээс: Тээврийн хэрэгсэл	тоогоор	14							
Компьютер	Тоогоор	15							
Бусад тоног төхөөрөмж	Тоогоор	16							
3. Лаборатори, туршилт үйлдвэрлэлийн цехийн тоног төхөөрөмж	сая төгрөгөөр	17							
4. Үндсэн хөрөнгийн бусад төрөл	сая төгрөгөөр	18							
Үүнээс: Ажлын ба ашиг шимийн мал амьтад	тоогоор	19							
Үндсэн эдэлбэр газар	га-аар	20							
Эдэлбэр газар, (туршилтын талбай, ногооны талбай, бэлчээр г.м) (зүлэгжсэн)	га-аар	21							
Бусад хөрөнгө (төслийн)	сая төгрөгөөр	22							

ШУТ-8. маягтад өөрчлөлт оруулах санал:

ШУТ-ийн материаллаг баазын тоо, хэмжээг бүртгэх тус маягыг логик алдаа болон зарим үзүүлэлтүүдийг засварлан дараах байдлаар шинэчиллээ.

Хүснэгт 37. Санал болгож буй маягт ШУТ-5 СХА-ын хөрөнгийн бүртгэл, тоо хэмжээ, хүчин чадлаар

№	Үндсэн хөрөнгө	Хэмжих нэгж	Мөрийн дугаар	Оны эхэнд	Тайлант хугацаанд		Оны эцэст
					Нэмэгдсэн	Хорогдсон	
	А	Б	В	1	2	3	4
1	Газар						
	Үүнээс:	Эдэлбэр газар	га-аар	1			
		Хөрөнгийн үнэлгээ	мян.төг	2			
		Үүнээс: Туршилтын талбай	га-аар	3			
	Хөрөнгийн үнэлгээ	мян.төг	4				
2	Барилга байгууламж						
	Үүнээс:	Орон сууцны байр	тоо, ш	5			
		Ашигтай талбай	кв.м	6			
		Хөрөнгийн үнэлгээ	мян.төг	7			
		Үндсэн байр	тоо, ш	8			
		Ашигтай талбай	кв.м	9			
		Хөрөнгийн үнэлгээ	мян.төг	10			
		Лаборатори	тоо, ш	11			
Ашигтай талбай		кв.м	12				

		Хөрөнгийн үнэлгээ	мян.төг	13			
		Туршилт үйлдвэрлэлийн цех	тоо, ш	14			
		Ашигтай талбай	кв.м	15			
		Хөрөнгийн үнэлгээ	мян.төг	16			
		Бусад барилга байгууламж	тоо, ш	17			
		Ашигтай талбай	кв.м	18			
		Хөрөнгийн үнэлгээ	мян.төг	19			
		Машин, тоног төхөөрөмж, эд хогшил					
3	Үүнээс:	Тээврийн хэрэгсэл	тоо, ш	20			
		Хөрөнгийн үнэлгээ	мян.төг	21			
		Компьютер	тоо, ш	22			
		Хөрөнгийн үнэлгээ	мян.төг	23			
		Тавилга, эд хогшил	тоо, ш	24			
		Хөрөнгийн үнэлгээ	мян.төг	25			
		Бусад машин, тоног төхөөрөмж	тоо, ш	26			
		Хөрөнгийн үнэлгээ	мян.төг	27			
		Лаборатори, туршилт үйлдвэрлэлийн цехийн тоног төхөөрөмж					
4	Үүнээс:	Лабораторийн тоног төхөөрөмж	тоо, ш	28			
		Хөрөнгийн үнэлгээ	мян.төг	29			
		Туршилт үйлдвэрлэлийн цехийн тоног төхөөрөмж	тоо, ш	30			
		Хөрөнгийн үнэлгээ	мян.төг	31			
		Бусад тоног төхөөрөмж	тоо, ш	32			
		Хөрөнгийн үнэлгээ	мян.төг	33			
		Оюуны өмчийн бүтээгдэхүүн					
5	Үүнээс:	Компьютерын программ хангамж	тоо, ш	34			
		Хөрөнгийн үнэлгээ	мян.төг	35			
		Мэдээллийн сан	мбайт	36			
		Хөрөнгийн үнэлгээ	мян.төг	37			
		Ном, сэтгүүлийн тоо	тоо, ш	38			
		Хөрөнгийн үнэлгээ	мян.төг	39			
		Бусад оюуны өмчийн бүтээгдэхүүн	тоо, ш	40			
		Хөрөнгийн үнэлгээ	мян.төг	41			
		Өсөж үрждэг хөрөнгө					
6	Үүнээс:	Мал амьтад	тоо, ш	42			
		Хөрөнгийн үнэлгээ	мян.төг	43			
		Олон наст ургамал	тоо, ш	44			
		Хөрөнгийн үнэлгээ	мян.төг	45			
		Бусад үндсэн хөрөнгө					
7	Үүнээс:	Үнэт зүйлс	тоо, ш	46			
		Хөрөнгийн үнэлгээ	мян.төг	47			
		Бусад хөрөнгө	га-аар	48			
		Хөрөнгийн үнэлгээ	мян.төг	49			

БАЛАНСЫН ШАЛГАЛТ: Багана1>Багана3; Мөр1>Мөр3; Мөр2>Мөр4;

Мэдээ гаргасан: _____, _____, _____ (албан тушаал, нэр, гарын үсэг)

Мэдээ хянасан: (албан тушаал, нэр, гарын үсэг, тэмдэг дарах)

20 ... оны ... сарын ... өдөр

4.4 ШИНЖЛЭХ УХААН ТЕХНОЛОГИ, СТАТИСТИКИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙГ ТООЦОХ АРГАЧЛАЛ

4.4.1 Нийтлэг үндэслэл

Монгол Улсын Шинжлэх ухаан, технологийн статистикийн үзүүлэлтүүдийг олон улсын нийтлэг арга зүйд нийцүүлэх, статистикийн мэдээлэл цуглуулах, нэгтгэн боловсруулах, үр дүнг ашигладаг бүх шатны байгууллага болон ажилтнууд, хэрэглэгчдийн нэгдсэн ойлголт, тодорхойлолт, арга зүй, аргачлалаар хангах, үйл ажиллагаанд нь нэвтрүүлэхэд нь уг аргачлалын зорилго оршино.

Монгол Улсын “Статистикийн тухай” хуулийн 2 дугаар бүлгийн 6 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт үйлдвэрлэл, шинжлэх ухаан, технологийн статистикийн үндсэн үзүүлэлтүүдийн хүрээг тодорхойлсон бөгөөд хуулийн дээрх хэсэгт л /мөрдөж байгаа патент, шинэ бүтээлийн тоо, г.м/ эрдэм шинжилгээ, туршилт, зохион бүтээх ажлын зардал гэсэн үзүүлэлтийг тусгаж өгсөн.

Монгол Улсын Статистикийн салбарыг 2017-2020 онд хөгжүүлэх үндэсний хөтөлбөрийн 2.6.1.5-д “...Шинжлэх ухааны салбарын статистикийн үзүүлэлтийн хүрээ, маягт, зааврыг тогтвортой хөгжлийн үзүүлэлттэй уялдуулан шинэчлэх”, 2.6.1.12-д “Шинжлэх ухааны статистикийн үзүүлэлт тооцох аргачлалыг шинээр боловсруулах, батлах, мөрдөх” гэж тус тус заасан.

Монгол Улсын Шинжлэх ухаан, технологийн статистикийн үндсэн үзүүлэлтүүд нь Монгол Улсын болон олон улсын түвшинд шинжлэх ухаан, технологийн хөгжлийн түвшин, нийгэмд эзлэх оролцоог тодорхойлж, дүн шинжилгээ хийх чухал хэрэгсэл болно.

Монгол Улсын Шинжлэх ухаан, технологийн уг төслийн хүрээнд үндэсний түвшний болон аж ахуй нэгж байгууллагын судалгаа хөгжүүлэлтийн ажил, түүнтэй холбогдох үзүүлэлтийг хэрхэн тооцохыг Фраскатиин гарын авлага дахь зөвлөмжийн дагуу тодорхойлсон. Шинжлэх ухаан, технологийн салбарын үзүүлэлтүүдийг тооцох аргачлалд тулгуурлан статистикийн 5 маягтыг шинээр боловсруулсан.

Энэхүү аргачлалыг үндэсний хэмжээнд шинжлэх ухаан, технологийн нэгдсэн үзүүлэлтийг тооцож, тархаахад ашиглана.

4.4.2 Ойлголт тодорхойлолт

1. Шинжлэх ухаан, технологийн үйл ажиллагаа (Scientific and technological activities-STA): Шинжлэх ухаан, технологийн үйл ажиллагаа (ШУТҮА) гэдэг нь СХА, шинжлэх ухаан, техникийн боловсрол, сургалт (ШУТБС), шинжлэх ухаан, технологийн үйлчилгээ (ШУТҮ) зэргийн цогц нэгдэл юм.

$$\text{ШУТҮА} = \text{СХА} + \text{ШУТБС} + \text{ШУТҮ}$$

2. Судалгаа хөгжүүлэлтийн ажил: Хүн, соёл, нийгмийн мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор хийгдэж байгаа системтэй, бүтээлч үйл ажиллагаа, түүний үр дүнд бий болсон шинэ мэдлэгийг хэрэглээнд нэвтрүүлж ашиглахад чиглэсэн цогц ажил юм.

СХА-ын нэр томъёонд дараах 3 үйл ажиллагааг хамруулна

- Суурь судалгаа
- Хэрэглээний судалгаа
- Туршилт, хөгжил

Судалгаа хөгжүүлэлтийн төсөл гүйцэтгэх зорилгоор биш бол дараах үйл ажиллагааг судалгаа хөгжүүлэлтийн ажил гэж тооцохгүй. Харин ШУТ-ийн үйл ажиллагаанд хамааруулж авч үзнэ. Үүнд:

- ШУТ-ийн мэдээллийн үйлчилгээ,
- Сорил тавих, стандартчилах,
- ТЭЗҮ боловсруулах,
- Мэргэжлийн эрүүл мэндийн судалгаа,
- Патент, лицензийн гэрээ,
- Бодлогын судалгаа,
- Программ хангамжийн хөгжүүлэлт.

3. Шинжлэх ухаан, техникийн боловсрол, сургалт (Scientific and technical education and training-STET): Энд эрдэмтэд болон инженерүүдэд зориулсан дараах боловсрол, сургалтын үйл ажиллагаануудыг хамруулж авч үзнэ.

- Их, дээд сургуулийн мэргэшлийн бус боловсрол, сургалт;
- Дээд боловсролын зэрэг олгох боловсрол, сургалт;
- Төгсөлтийн дараах болон нэмэлт сургалт;
- Насан туршийн боловсрол, сургалт;

4. Шинжлэх ухаан, технологийн үйлчилгээ (Scientific and technological services-STS): Шинжлэх ухаан, технологийн үйлчилгээ нь судалгаа, туршилт хөгжлийн ажил болон шинжлэх ухаан, техникийн мэдлэгийг бий болгох, түгээх, хэрэгжүүлэхэд хувь нэмэр оруулах үйл ажиллагаагаар тодорхойлогдоно. Үүнд:

- Номын сан, архив, мэдээлэл лавлагааны төвүүд, эрдэм шинжилгээний төвүүд, мэдээлэл боловсруулалтын алба газруудаас үзүүлж буй үйлчилгээнүүд,
- Шинжлэх ухааны болон технологийн музей, амьтны хүрээлэн, ботаник цэцэрлэг, бусад антропологи, археологи, геологийн чиглэлийн байгууллагуудын үйлчилгээ,
- ШУТ-ийн ном, хэвлэлийн орчуулга (ерөнхий болон их, дээд сургуулийн ном сурах бичгээс бусад),
- Байр зүй, геологи, гидрологийн хэмжилт; одон орон, цаг уур, газар хөдлөлийн байнгын ажиглалт; хөрс, ургамал, загас, ан амьтны нөөцийг судлах; хөрс, агаар мандал, усны ердийн туршилт; цацраг идэвхт байдлын түвшинг тогтмол хянах үйлчилгээнүүд;
- Газрын тос, ашигт малтмалын нөөцийг тогтоох, тодорхойлоход чиглэсэн хайгуулын болон бусад холбогдох үйл ажиллагаа;
- Хүн ам, нийгэм-эдийн засгийн юмс үзэгдлийг судлах, танин мэдэх зорилгоор өгөгдөл цуглуулах (хүн амын тооллого, үйлдвэрлэл, түгээлт, нийгэм, соёлын статистик гэх мэт)
- Сорил тавих, стандартчилал, чанарын хяналт, хэрэглэгчдэд өгөх зөвлөгөө үйлчилгээ,
- Төрийн байгууллагын патент, лицензийн үйл ажиллагаа зэрэг багтана.

5. Эрдэм шинжилгээний ажил: Аливаа шинжлэх ухааны сэдвийн хүрээнд хийсэн судалгаа шинжилгээний үр дүнг нэгтгэн дүгнэж, дүгнэлт өгсөн, шинжлэх ухааны тодорхой мэдээллийг агуулсан өгүүлэл, илтгэл, судалгаа, бүтээл төслүүдийг хамруулан авч үзнэ.

6. Эрдэм шинжилгээний ажлын үр дүн: Шинжлэх ухааны үйл ажиллагааны хүрээнд бий болсон шинэ болон нэмэлт мэдлэг, техник, технологийн шийдлийг илэрхийлсэн мэдээллийг ойлгоно.

7. Суурь судалгаа (Basic research): Аливаа үзэгдэл, ажиглаж болохуйц баримт, нотолгоонд түшиглэн, шинэ мэдлэгийг бий болгоход чиглэсэн, тодорхой хэрэглээнд ашиглах зорилгогүй, туршилтын буюу онолын ажил юм. Суурь судалгаа нь шинж чанар, бүтэц, өөр хоорондын харилцан хамааралд дүн шинжилгээ хийх замаар таамаглал, онол, зүй тогтлыг шинээр томъёолох, туршихад чиглэнэ.

ЗГ-ын 2014 оны 301-р тогтоолын тогтоолоор батлагдсан ШУТ-ийн технологийн төслийн ангилал дахь суурь судалгаанд чиглэсэн хөтөлбөрийн зорилтот төсөл, захиалгат төсөл, гадаадтай хамтарсан төслүүд нь энэ ангилалд ойлгоно.

8. Хэрэглээний судалгаа: Эхнээсээ тодорхой зорилгод чиглэсэн, шинэ мэдлэг бий болгох зорилготой судалгааны ажил бөгөөд суурь судалгааны ололт, үр дүнг тодорхой хэрэглээнд ашиглаж болох эсэхийг тодорхойлох, тодорхой зорилгод хүрэх арга замыг

тогтооход чиглэгдэнэ. Хэрэглээний судалгааны үр дүн нь нэг буюу цөөн бүтээгдэхүүн, үйл ажиллагаа, арга зүй, тогтолцоонд зориулагдсан байдаг.

ЗГ-ын 2014 оны 301-р тогтоолын тогтоолоор батлагдсан ШУТ-ийн технологийн төслийн ангилал дахь хэрэглээний судалгаанд чиглэсэн хөтөлбөрийн зорилтот төсөл, захиалгат төсөл, гадаадтай хамтарсан төслүүдийг энэ ангилалд ойлгоно.

9. Туршилт, хөгжүүлэлтийн ажил: Шинэ бараа, материал, бүтээгдэхүүн үйлдвэрлэх, мөн шинэ үйл явц, тогтолцоо, үйлчилгээг нэвтрүүлэх, эдгээрийг сайжруулахад чиглэсэн системтэй судалгаа, туршилтын ажлыг ойлгоно.

ЗГ-ын 2014 оны 301-р тогтоолын тогтоолоор батлагдсан ШУТ-ийн технологийн төслийн ангилал дахь цөм технологийн төсөл, технологи, туршилт зүгшрүүлэлтийн төслүүдийг энэ ангилалд ойлгоно.

10. Хөтөлбөрийн зорилтот төсөл: Нийгмийн болон салбарын хөгжлийн урт, дунд хугацааны стратеги төлөвлөгөө, хөтөлбөр, бодлогын бичгийн хүрээнд хэрэгжиж байгаа төслийг ойлгоно.

11. Захиалгат төсөл: Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан арга хэмжээ болон төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллага, агентлаг, аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны тулгамдсан асуудлыг судалж шийдвэрлэхэд чиглэсэн төсөл юм.

12. Цөм технологийн төсөл: Засгийн газраас баталсан шинжлэх ухаан, технологийн тэргүүлэх чиглэл, цөм технологийн жагсаалтад хамаарах технологийн судалгаа боловсруулалтын ажлыг хэрэгжүүлэх төслийг ойлгоно.

13. Технологийн туршилт, зүгшрүүлэлтийн төсөл: Лабораторийн түвшинд боловсруулсан технологи, бүтээгдэхүүний загварыг үйлдвэрлэлийн нөхцөлд турших, боловсронгуй болгох, технологийн баримтжуулалт хийх үйл ажиллагаа юм.

14. Гадаадтай хамтарсан төсөл: Монгол Улсын Засгийн газар, шинжлэх ухаан, технологийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагаас гадаад улс, олон улсын байгууллагатай хамтран ажиллах гэрээ (хэлэлцээр)-ний хүрээнд хэрэгжүүлэх 2 болон олон талт төслийг ойлгоно.

15. Технологи: Оюуны бүтээлийг хэрэглээний бүтээгдэхүүн болгон хувиргахад чиглэгдсэн хүн, техник, мэдээлэл, зохион байгуулалтын харилцан уялдаат үйл ажиллагааг хэрэгжүүлэх аргуудын цогц юм.

16. Шинжлэх ухаан, технологийн үйл ажиллагаа: Эдийн засаг нийгмийн болон бусад асуудлыг шийдвэрлэх цогцолбор арга хэмжээг хэрэгжүүлэх зорилгоор шинэ болон нэмэлт мэдлэг, шинэ арга бий болгох, хэрэглэхэд чиглэгдсэн үйл ажиллагааг ойлгоно.

17. Шинжлэх ухаан, технологийн төсөл: Эрдэм шинжилгээ, туршилт, зохион бүтээх ажлыг онол, аргазүйн өндөр түвшинд явуулж, захиалагчийн хэрэгцээ, шаардлагыг хангасан үр дүн бий болгох, түүнийг үйлдвэрлэл, үйлчилгээнд нэвтрүүлэх, ашиглах үйл ажиллагааг төлөвлөсөн баримт бичиг юм.

18. Шинэ мэдлэг: Шинжлэх ухаан, технологийн үйл ажиллагааны үр дүнд бий болсон эдийн засаг, нийгмийн асуудлыг шийдвэрлэх зорилгоор ашиглаж болохуйц, эрхийн хамгаалалт хийгдсэн оюуны бүтээл юм.

19. Технологийн инноваци: Эрдэм шинжилгээний ажлын үр дүнг эцсийн бүтээгдэхүүн болгон зах зээл, үйлдвэрлэл, үйлчилгээнд нэвтрүүлэх цогц үйл ажиллагаа юм.

20. Боловсролын зэрэгтэй ажилтан: Дээд боловсролын хуулиар баталсан шаталсан сургалтын шалгуурыг хангаж боловсролын зэрэг хамгаалсан ажилтан юм.

21. Эмбодиэд технологи (Embedded technology): Шинэ тоног, төхөөрөмжид хөрөнгө оруулж гаргаж авсан технологи. Технологи нь шинэ тоног төхөөрөмжийн бүрэлдэхүүн хэсэг.

22. Дизэмбодиэд технологи (Disembedded technology): Тоног төхөөрөмжид хөрөнгө оруулахгүйгээр гарцыг нэмэгдүүлэх технологи.

23. СХА-ын хүний нөөц: Судалгаа хөгжүүлэлтийн үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд оролцож буй хүний нөөц юм. Энд судалгаа хөгжүүлэлтийн үйл ажиллагааг гардан гүйцэтгэж буй хүний нөөц болон тэдгээрт СХА-ын менежер, администратор, бичиг хэргийн ажилтан, инженер техникийн ажилтан зэрэг шууд үйлчилгээ үзүүлдэг нийт ажилтныг хамруулна.

24. Удирдах албан тушаалтан гэдэгт судалгаа хөгжүүлэлтийн ажлыг ахлан ажилладаг судалгааны ажлын шинжлэх ухааны болон техникийн асуудалтай холбоотой менежментийн болон төлөвлөлтийн үйл ажиллагааны менежерүүд болон захиргааны ажилтнуудыг тооцох ба эдгээр нь ихэвчлэн судалгааны шууд ажилчдаас илүү өндөр эсвэл тэнцүү зэрэглэлд ордог бөгөөд өмнө нь ихэвчлэн эрдэм шинжилгээний цагийн ажилтан байсан хүмүүс байдаг.

25. Судлаач: Шинэ мэдлэг, бүтээгдэхүүн, процесс, аргачлал, системийн санаачлах, бүтээх мөн төслийн удирдлагыг хэрэгжүүлдэг мэргэжилтэн юм. Төгсөлтийн дараах сургалтын докторантыг мөн судлаачаар тооцно.

26. Техникч, түүнтэй дүйцэх ажилтан: Инженер, физик, амьдралын ухаан, нийгэм хүмүүнлэгийн ухааны нэг буюу хэд хэдэн салбарт техникийн мэдлэг, туршлага шаардсан ажил хийдэг мэргэжилтэн юм.

27. Бусад туслах ажилтан: Судалгаа хөгжүүлэлтийн төслийн ажилтан буюу төсөлтэй шууд холбоотой ажилладаг мэргэжилтэй, мэргэжилгүй урчууд, нарийн бичиг, бичиг хэргийн ажилтан ба бусад туслах ажилтан хамаарна.

28. Бүтэн цагаар ажилласан хүний тоонд шилжүүлсэн утга (БЦАХТШУ): Судалгаа хөгжүүлэлтийн хүний нөөцийг нэлэнхүй тооллогын дүн, бүтэн цагаар ажилласан хүний

тоонд шилжүүлсэн утгаар илэрхийлнэ. Нийт хүний тоогоор илэрхийлсэн хүний нөөцийн өгөгдөл нь СХА-ыг бүтэн цагаар буюу үндсэн ажилтан, цагийн буюу гэрээт ажилтны тооллогын нийлбэр юм.

29. Бүтэн цагаар ажиллагч: Бүтэн цагаар ажиллагч гэж Монгол Улсын “Хөдөлмөрийн тухай хууль”-д заасны дагуу долоо хоногийн ажлын цаг нь 40 хүртэл, ердийн ажлын өдрийн үргэлжлэл 8 хүртэл цаг, ажлын дараалсан 2 өдрийн хоорондох тасралтгүй амралт нь 12 цаг ба түүнээс дээш хугацаатай ажилладаг ажиллагч болон ээлжээр ажилладаг ажиллагчийг ойлгоно.

30. Хагас цагаар ажиллагч: Хөдөлмөрийн болон ажил гүйцэтгэх, хөлсөөр ажиллах гэрээ байгуулан ажиллаж, хөдөлмөрийн харилцаа нь Хөдөлмөрийн тухай болон Иргэний хуулиар зохицуулагддаг боловч долоо хоногийн ажлын цаг, ердийн ажлын өдрийн үргэлжлэлээс бага хугацаагаар ажиллаж, цалин хөлс, орлого олдог, татвар, нийгмийн даатгалын шимтгэлийг ажил олгогч болон өөрөө хариуцан төлдөг ажиллагчийг ойлгоно (үүнд цагийн ажил хийж буй хөдөлмөрийн насны суралцагчийг хамруулахгүй).

31. Шууд буюу дотоод зардал: Тухайн статистик нэгж өгөгдсөн хугацаанд тухайн эдийн засгийн салбарт дурын эх үүсвэрийн санхүүжилтээр гүйцэтгэсэн судалгаа хөгжүүлэлтийн нийт зардал юм. Үүнд, тухайн статистик нэгж буюу салбар дотоод СХА-ыг дэмжих зорилгоор бусдаар гүйцэтгүүлсэн, гадагш зарцуулсан шууд бус зарцуулалтыг тооцно.

32. Шууд бус (Гадаад зардал): Тодорхой хугацаанд бусад нэгж, байгууллага, салбараар СХА-ыг гүйцэтгүүлсний төлөө төлсөн буюу төлөх зардлын нийлбэр юм. Үүнд, бусад нэгжээр гүйцэтгүүлсэн СХА-ын үр дүнг худалдаж авах, бусдаар СХА гүйцэтгүүлэхээр олгосон грант багтана.

33. Үйл ажиллагааны зардал: Энд цалин хөлс, нийгмийн даатгалын шимтгэл болон тухайн жилд гүйцэтгэсэн эргэлтийн хөрөнгө, бараа материалын худалдан авалтууд, бусад үйл ажиллагааны зардлууд орно. Энд зөвхөн тухайн жилийн богино хугацаат зардлуудыг авч үзэхийг анхаарах хэрэгтэй.

34. Цалингийн зардал (Хүний нөөцийн цалин хөлс): Тухайн жилийн цалин, хөлс, болон урамшуулал, амралтын цалин, тэтгэврийн сан зэрэг нэмэлт зардлыг оруулна.

35. Нийгмийн даатгалын шимтгэл: Нийгмийн даатгалд даатгуулах зорилгоор даатгуулагч болон ажил олгогчоос хуульд заасан хугацаанд нийгмийн даатгалын санд төлөх урьдчилсан төлбөрийг ойлгоно.

36. Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал: Энд гэрэл цахилгаан, түлш халаалт, цэвэр бохир ус, байрны түрээс зэргийн зардлыг оруулна.

37. Хангамж, бараа материалын зардал: Бичиг хэрэг, тээвэр шатахуун, шуудан холбоо, интернэтийн төлбөр, хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал ариутгал, бага үнэтэй, түргэн элэгдэх ахуйн эд зүйлсийн зардлыг ойлгоно.

38. Нормативт зардал: Эм, бэлдмэл эмнэлэг, лабораторийн хэрэгсэл, нормын хувцас, зөөлөн эдлэлийг ойлгоно.

39. Урсгал засварын зардал: Засвар болон ашиглалт, үйлчилгээний зардлуудыг ойлгоно.

40. Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж: СХА-ыг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, тусгай туршилтын бааз, шинжилгээний ажил, инженер болон бусад мэргэжлийн үйлчилгээ гэх мэт гадны байгууллагуудаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээнд төлөх төлбөр.

41. Бусад үйл ажиллагааны зардал: Өгөгдсөн жил тухайн статистик нэгжид гүйцэтгэсэн СХА-д ашиглах материалын хангамж, багаж, тоног төхөөрөмж зэрэг эргэлтийн хөрөнгийн худалдан авалтууд болон төслийг хэрэгжүүлэхэд шууд бус үйлчилгээ үзүүлж буй ажилтнуудын хөдөлмөрийн хөлсийг оруулна.

42. Үндсэн хөрөнгийн зардал: Тухайн статистик нэгжийн СХА-д тогтмол ашиглаж байгаа хөрөнгийн нэг жилийн нийт зардлыг ойлгоно. Тухайн хугацааны турш гарсан зардлыг бүрэн тайлагнах ба элэгдэл хорогдол гэж бүртгэж болохгүй.

43. Газрын зардал: Тус зардлын төрөлд СХА-д ашиглах газар, эзэмшлийн талбайг ойлгоно.

44. Барилга байгууламжийн зардал: СХА-д (сорилт, туршилтын талбай, лаборатори, туршилтын үйлдвэр г.м.) ашиглах барьж, байгуулж буй буюу худалдан авсан барилга, байгууламж, өргөтгөлийн өөрчлөлт, засварыг тооцно.

45. Багаж, тоног төхөөрөмж, хэрэгсэл, эд хогшлын зардал: Тус зардлын төрөлд СХА-ыг гүйцэтгэхэд шаардлагатай үндсэн багаж, тоног төхөөрөмж, хэрэгсэл зэрэг эд хогшлын зардлыг ойлгоно. Энд тухайн статистик нэгжийн үндсэн хөрөнгүүдэд бүртгэгдсэн багаж, тоног төхөөрөмжүүдийг ойлгох бөгөөд тухайн нэг СХА-д ашиглах үйл ажиллагааны зардлаас ялгаж авч үзэх нь зүйтэй.

46. Компьютерын программ хангамжийн зардал: СХА-ыг гүйцэтгэхэд шаардлагатай тусгай компьютерын программ хангамж, системийн болон хэрэглээний программ хангамжийн гарын авлага, дэмжих материалуудыг оруулна (Тухайн байгууллага өөрийн дотоод хэрэгцээнд зориулж бүтээсэн программ хангамж). Программ хангамжийн лицензийн нэг жилийн хураамжийг нэмж тооцно.

47. СХА-д зарцуулсан дотоодын нийт зардал (GERD): Тайлант хугацаанд тухайн үндэсний нутаг дэвсгэр дээр гүйцэтгэсэн судалгаа, хөгжлийн ажлын дотоод зардлын нийлбэр юм. СХА-д зарцуулсан дотоодын нийт зардал гадаадын санхүүжилтээр дотоодод

гүйцэтгэсэн СХА-ыг хамруулж, харин гадаадад гүйцэтгэсэн СХА-ын төлбөрийн хамруулдаггүй. СХА-д зарцуулсан дотоодын нийт зардлыг гүйцэтгэгчийн 4 секторын дотоод зардлыг нэмэх замаар боддог. Ихэнхдээ үүнийг гүйцэтгэгч, санхүүжүүлэгч секторын солбисон хүснэгтээр илэрхийлнэ.

48. СХА-д зарцуулсан үндэсний нийт зардал (GNERD): Өгөгдсөн хугацаанд тухайн үндэсний байгууллагуудаас санхүүжүүлсэн СХА-ын дотоод зардлын нийлбэр юм. СХА-д зарцуулсан үндэсний нийт зардалд тухайн улсын иргэн, байгууллагуудаас санхүүжүүлж, гадаадад гүйцэтгэсэн СХА-ыг хамруулдаг. Харин гадаадын санхүүжилтээр дотоодод гүйцэтгэсэн СХА-ын төлбөрийг хамруулдаггүй. СХА-д зарцуулсан үндэсний нийт зардалд гүйцэтгэгч сектор тус бүрийн дотоод зардлын нийлбэр дээр дотоодын санхүүжилтээр гадаадад гүйцэтгэсэн СХА-ын зардлыг нэмж бодно.

49. Төрийн байгууллагын сектор: Бүх яам, агентлаг болон бусад байгууллага, Засгийн газраас удирдлага, санхүүжилтийн хувьд хамаардаг боловч дээд боловсролын секторт захирагддаггүй ашгийн бус байгууллагаас бүрдэнэ. Ердийн үед дээд боловсролоос бусад үйлчилгээг олон нийтэд худалдан борлуулдаггүй эдийн засаг, нийгмийн бодлогын хүрээнд үзүүлдэг олон нийтийн үйлчилгээ юм. Тус сектор нь дараах байгууллагаас бүрдэнэ. Үүнд:

- Бүх яам, агентлаг, орон нутгийн захиргааны байгууллагууд болон төрийн өмчийн бусад байгууллагууд.
- Засгийн газраас санхүүждэг төрийн өмчийн их, дээд сургууль, коллежууд.

50. Хувийн хэвшлийн сектор: Хувийн хэвшлийн секторт дараах нэгжүүдийг хамруулна.

- Бүх төрлийн бараа, үйлчилгээг үйлдвэрлэж зах зээлд нийлүүлэх, эдийн засгийн хувьд ач холбогдолтой үнээр олон нийтэд борлуулах үндсэн үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллага, компани, корпораци (дээд боловсролоос бусад) зэрэг бүх өмчийн хувийн хэвшлийн байгууллага.

51. Төрийн бус байгууллагын сектор: Бараа, бүтээгдэхүүний зах зээлийн үйлдвэрлэгч эсвэл бизнес эрхэлдэг бүх төрийн бус байгууллагууд.

52. Гадаад сектор: Улс орны хилээс гадна байрлаж буй бүх хүрээлэн, хувь хүмүүс, олон улсын байгууллага хамаарна. Харин, гадаадад үйл ажиллагаа явуулж буй үндэсний байгууллага, түүний эзэмшлийн туршилт, сорил тавих талбай орохгүй. Тухайн улс орны хилийн дотор үйл ажиллагаа явуулж буй хуулийн этгээдийн материаллаг баазыг тооцно.

- Гадаад улсын Засгийн газар
- Гадаадын аж ахуйн нэгж
- Гадаадын их, дээд сургуулиуд
- Гадаадын төрийн бус байгууллага
- Гадаадын ОУБ, төсөл хөтөлбөр
- Бусад аж ахуйн нэгж

53. Байгалийн шинжлэх ухааны салбар: Тус шинжлэх ухааны салбарт Математикийн шинжлэх ухаан, Компьютер, мэдээллийн шинжлэх ухаан, Физикийн шинжлэх ухаан, Химийн шинжлэх ухаан, Газар, хүрээлэн буй орчны шинжлэх ухаан, Биологийн шинжлэх ухаан болон бусад дэд байгалийн шинжлэх ухааны салбаруудыг хамруулан авч үзнэ.

54. Инженер технологийн шинжлэх ухааны салбар: Иргэний инженерчлэл, Цахилгааны инженерчлэл, Электроникийн инженерчлэл, Мэдээллийн инженерчлэл, Механик инженерчлэл, Химийн инженерчлэл, Материал (түүхий эд) судлал, Анагаах ухааны инженерчлэл, Хүрээлэн буй орчны инженерчлэл, Хүрээлэн буй орчны биотехнологи, Үйлдвэрлэлийн биотехнологи, нано-технологи, бусад инженерчлэл болон технологийн дэд салбаруудыг хамруулна.

55. Анагаахын шинжлэх ухааны салбар: Анагаах ухааны суурь судалгаа, эмнэл зүйн анагаах ухаан, эрүүл мэндийн шинжлэх ухаан, эрүүл мэндийн биотехнологи болон бусад анагаах ухааны дэд салбаруудыг авч үзнэ.

56. Хөдөө аж ахуйн шинжлэх ухааны салбар: Газар тариалан, Ой, загас, агнуур, Амьтан, сүү судлал, Мал эмнэлэг судлал, ХАА биотехнологи болон бусад ХАА-н шинжлэх ухааны дэд салбаруудыг авч үзнэ.

57. Нийгмийн шинжлэх ухааны салбар: Сэтгэл судлал, эдийн засаг, бизнес, Боловсрол судлал, Социологи, Хууль, Улс төр судлал, Нийгэм, эдийн засгийн газар зүй, Хэвлэл мэдээлэл, харилцаа холбоо, Бусад нийгмийн шинжлэх ухаануудыг хамруулна.

58. Хүмүүнлэгийн шинжлэх ухааны салбар: Түүх, археологи, Хэл, уран зохиол, Философи, ёс зүй, шашин, Урлаг болон бусад хүмүүнлэгийн шинжлэх ухааны дэд салбаруудыг ойлгоно.

59. СХА-д хуваарилсан Засгийн газрын төсвийн хуваарилалт (GBARD): Судалгаа хөгжүүлэлтийн ажилд Засгийн газраас зарцуулсан санхүүжилтийн хэмжээ, сая төгрөг.

60. Засгийн газрын СХА-ын зардал (GOVERD): СХА-д Засгийн газрын харьяа байгууллагуудын зарцуулсан зардлын хэмжээг ойлгоно.

61. Хувийн хэвшлийн байгууллагын СХА-ын зардал (BERD): Хувийн хэвшлийн байгууллагын СХА-д зарцуулсан зардал.

62. Дээд боловсролын байгууллагын СХА-ын зардал (HERD): Дээд боловсролын байгууллагын СХА-д зарцуулсан зардал.

63. Төрийн бус байгууллагын СХА-ын зардал (PNPERD): Төрийн бус байгууллагын зарцуулсан зардал.

64. БОУСА (Боловсролын олон улсын стандартын ангилал): Энэ нь судалгаа хөгжүүлэлтийн хүний нөөцийг албан ёсны, эзэмшсэн боловсролын зэргийн дагуу ангилдаг ангилал бөгөөд эрхэлж буй ажил мэргэжил, ажиллаж буй салбараар нь бус гагцхүү

эзэмшсэн боловсролын түвшингээр ангилдаг. СХА-ын статистик зорилгоор 6 ангид хувааж авч үзнэ.

65. Шинжлэх ухааны доктор: Академик эрдэм шинжилгээний ажил нь шинжлэх ухааны хөгжилд бодитой хувь нэмэр оруулсан гэж үнэлэгдсэний үндсэн дээр олгогдож буй эрдмийн зэрэг.

66. БОУСА-ын зэрэг 8: Доктор ба түүнтэй дүйцэх зэрэг. БОУСА-ын 8-р зэргийн хөтөлбөрүүд нь суралцагчид өндөр түвшний судалгааны арга зүй эзэмшүүлдэг. Энэхүү зэргийн хөтөлбөр нь их сургууль зэрэг судалгааны чиг баримжаатай мэргэжлийн боловсролын байгууллагуудад шинэлэг, дэвшилтэт судалгааны ажил гүйцэтгэсэн суралцагчид зэрэг олгодог. Докторын хөтөлбөрүүд нь шинжлэх ухааны болон мэргэжлийн салбараар төрөлждөг.

67. БОУСА-ын зэрэг 7: Магистр ба түүнтэй дүйцэх зэрэг. БОУСА-ын 7-р зэргийн хөтөлбөрүүд нь суралцагчийг төгсөлтийн дараах сургалтаар нарийн мэргэжлийн онолын мэдлэг, мэргэшил, ур чадварыг эзэмшүүлдэг. Энэ хөтөлбөрүүд нь докторын зэрэг олгох түвшнээс арай доогуур ч судалгааны бүрэлдэхүүн хэсэгтэй. Ийм хөтөлбөрүүд нь онолын чиг баримжаатай ч дадлага ажлын хэсэгтэй. Суралцагчид өндөр түвшний судалгааны арга зүй, мэргэжлийн арга зүйн дадлагыг олгодог. Их сургуулиуд, бусад мэргэжлийн боловсролын байгууллагууд энэ түвшний сургалт эрхэлдэг.

68. БОУСА-ын зэрэг 6: Бакалавр ба түүнтэй дүйцэх зэрэг. БОУСА-ын 6-р зэргийн хөтөлбөрүүд нь суралцагчид дунд түвшний академик мэдлэг, мэргэжлийн мэдлэг, ур чадвар олгодог анхдагч зэргийн сургалт юм. Суралцагчид онол, арга зүйг эзэмшүүлж, мэргэжлийн дадлага хийлгэдэг. Их сургуулиуд, бусад мэргэжлийн боловсролын байгууллагууд энэ сургалтыг эрхэлдэг. Суралцагчид нь мэргэжлийн боловсролын байгууллагад гурваас дөрвөн жил бүтэн цагаар суралцаж, төгсдөг.

69. БОУСА-ын зэрэг 5: Техник мэргэжлийн боловсрол. БОУСА-ын 5-р зэргийн хөтөлбөрүүд нь суралцагчид техникийн мэдлэг, ур чадвар, мэргэжлийн чиг баримжаа эзэмшүүлдэг. Бодит амьдралд суурилсан, тухайн мэргэжлийн онцлогийг тусгасан хөтөлбөр нь оюутнуудыг хөдөлмөрийн зах зээлд бэлтгэдэг. Түүнчлэн суралцагчид нь эдгээр хөтөлбөрүүдийг дүүргээд дараа нь бусад мэргэжлийн боловсролын хөтөлбөрүүдэд шат ахиж суралцах боломжтой. Бакалаврын хөтөлбөрөөс доогуур түвшний бүх академик мэргэжлийн боловсролын хөтөлбөрүүдийг БОУСА-ын 5-р зэрэгт хамааруулна.

70. БОУСА-ын зэрэг 0-4: Дээрх зэргээс бусад бүх боловсролын зэрэг хамаарна.

71. Дотоодын судалгаа хөгжүүлэлтийн ажил: Санхүүжүүлэгч нь хэн байхаас үл хамааран Монгол Улсын нутаг дэвсгэрт хэрэгжиж буй судалгаа хөгжүүлэлтийн ажлуудыг хамаарна.

72. Инженер технологийн чиглэлийн СХА: Инженер технологийн салбарт хэрэгжиж буй судалгаа хөгжүүлэлтийн ажлуудыг ойлгоно.

73. Төсвийн бус эх үүсвэр: Төсвийн буюу засгийн газрын санхүүжилтээс бусад секторын (хувийн байгууллагын сектор, дээд боловсролын сектор, төрийн бус байгууллагын сектор, гадаад сектор) эх үүсвэрийг ойлгоно.

74. Инженер технологийн чиглэлээр төгсөгчид: Инженер технологийн салбарын мэргэжлээр их, дээд сургууль, коллеж төгссөн төгсөгчдийг ойлгоно.

75. Аж үйлдвэрийн салбар: Эдийн засгийн үйл ажиллагааны салбарын олон улсын стандарт ангилал (ЭЗҮАСОУСА)-ын В ангилал “Уул уурхай”, С ангилал “Боловсруулах үйлдвэр”, D ангилал “Цахилгаан, эрчим хүч” гэсэн салбаруудыг аж үйлдвэрийн салбарт хамруулан авч үзнэ.

4.4.3 Хамрах хүрээ, мэдээллийн эх үүсвэр

4.4.3.1 Хамрах хүрээ

- Яам, агентлагийн харьяа судалгаа, эрдэм шинжилгээний байгууллагууд
- Шинжлэх ухааны академийн харьяа судалгаа, эрдэм шинжилгээний байгууллагууд
- Их, дээд сургууль, коллеж
- Их, дээд сургууль, коллежийн харьяа судалгаа, эрдэм шинжилгээний байгууллагууд
- Хувийн хэвшлийн судалгаа, эрдэм шинжилгээний ААН, байгууллагууд

4.4.3.2 Мэдээллийн эх үүсвэр

Шинжлэх ухаан, технологийн салбарын статистикийн арга зүй, аргачлалыг боловсруулахад дараах маягтуудыг эх үүсвэр болгов.

ШУТ-1.1 СХА-ын хүний нөөцийн 20.. оны мэдээ, ажил мэргэжлийн ангиллаар, шинжлэх ухааны салбараар, боловсролын зэргээр

ШУТ-1.2 СХА-ын хүний нөөцийн 20.. оны мэдээ, хүйсээр, боловсролын зэргээр, насаар, шинжлэх ухааны салбараар, ажил мэргэжлийн ангиллаар

ШУТ-2.1 СХА-ын зардал

ШУТ-2.2 ШУТА-ын тоо, зардал, шинжлэх ухааны салбараар, ШУТА-ын төрлөөр

ШУТ-3.1 СХА-ын санхүүжилт, эх үүсвэрээр, СХА-ын төрлөөр

ШУТ-3.2 СХА-ын санхүүжилт, шинжлэх ухааны салбараар

ШУТ-4 СХА-ын үр дүн

ШУТ-5 СХА-ын хөрөнгийн бүртгэл, тоо хэмжээ, хүчин чадлаар

4.4.4 Үндсэн үзүүлэлтийг тооцох арга зүй

1. Эрдэм шинжилгээний байгууллагын тоо

Тооцох арга зүй: Тайлант онд үйл ажиллагаа явуулсан нийт эрдэм шинжилгээний байгууллагын тоог тодорхойлно.

2. Шинжлэх ухаан, технологийн салбарын зардал

Үзүүлэлтийн тодорхойлолт: Өгөгдсөн хугацаанд тухайн улсын нутаг дэвсгэр дээр шинжлэх ухаан, технологийн салбарт гүйцэтгэсэн ажлын зардлын нийлбэр юм.

Тооцох арга зүй: Тайлант онд дотооддоо гүйцэтгэсэн шинжлэх ухаан, технологийн ажлын зардлын нийлбэрээр илэрхийлэгдэнэ.

Мэдээллийн эх үүсвэр, давтамж: БШУЯ-ны ШУТ-ийн жилийн эцсийн мэдээгээр жил бүр тооцно.

Мэдээллийн задаргаа: Улсын хэмжээнд тооцно.

3. ДНБ-нд шинжлэх ухаан, технологийн салбарын зардлын эзлэх хувь

Үзүүлэлтийн тодорхойлолт: Шинжлэх ухаан технологийн салбарын зардлыг эдийн засгийн нийт гарцад харьцуулсан харьцаа юм.

Тооцох арга зүй: Тайлант оны шинжлэх ухаан технологийн салбарын зардлыг тухайн оны ДНБ-ий хэмжээнд харьцуулж 100-д үржүүлнэ.

$$\text{ДНБШУТСЭХ} = \frac{\text{ШУТСЗ}}{\text{ДНБ}} * 100$$

ДНБШУТСЭХ – ДНБ-нд шинжлэх ухаан, технологийн салбарын зардлын эзлэх хувь

ШУТСЗ – Шинжлэх ухаан, технологийн салбарын зардал

Мэдээллийн эх үүсвэр, давтамж: БШУЯ-ны ШУТ-ийн жилийн эцсийн мэдээгээр жил бүр тооцно.

Мэдээллийн задаргаа: Улсын хэмжээнд тооцно.

4. Судалгаа хөгжүүлэлтийн ажлын дотоодын нийт зардал-GERD (СХАДНЗ)

Үзүүлэлтийн тодорхойлолт: Өгөгдсөн хугацаанд тухайн улсын нутаг дэвсгэр дээр гүйцэтгэсэн СХА-ын дотоод зардлын нийлбэр юм.

Тооцох арга зүй: Тайлант онд дотооддоо гүйцэтгэсэн СХА-ын зардлын нийлбэрээр илэрхийлэгдэнэ.

Мэдээллийн эх үүсвэр, давтамж: БШУЯ-ны ШУТ-ийн жилийн эцсийн мэдээгээр жил бүр тооцно.

Мэдээллийн задаргаа: Улсын хэмжээнд тооцно.

5. ДНБ-д судалгаа, хөгжүүлэлтийн зардлын эзлэх хувь

Тодорхойлолт: Судалгаа хөгжүүлэлтийн зардлын ДНБ-д эзлэх хувь нь СХ-ийн зардлын хэмжээг эдийн засгийн нийт гарцад харьцуулсан харьцаа юм.

Ойлголт: Судалгаа, туршилт, хөгжүүлэлт гэж хүн, соёл, нийгмийн мэдлэгийг дээшлүүлэх, бий болсон мэдлэгийн шинээр хэрэглэх боломжийг бүрдүүлэх зорилгоор авч хэрэгжүүлсэн системтэй, бүтээлч үйл ажиллагаа юм.

Дотоодын судалгаа, хөгжүүлэлтийн ажлын нийт зардал нь тухайн жилд судалгаа болон хөгжлийн ажилд зарцуулсан мөнгөний хэмжээг илэрхийлнэ.

Тооцох арга зүй: Тайлант оны судалгаа хөгжүүлэлтийн зардлын хэмжээг тухайн оны ДНБ-ий хэмжээнд харьцуулж 100-д үржүүлнэ.

$$\text{ДНБСХЗЭХ} = \frac{\text{СХЗ}}{\text{ДНБ}} * 100$$

Мэдээллийн эх үүсвэр, давтамж: Сангийн яам, БШУЯ, төсвийн мэдээ, захиргааны статистикийн мэдээ

Мэдээллийн задаргаа: СХ-ийн зардлыг салбараар, санхүүжилтийн эх үүсвэрээр, шинжлэх ухааны салбараар, судалгааны төрлөөр, зардлын төрлөөр гаргана.

Хариуцах байгууллага: Сангийн яам, БШУЯ, ҮСХ

6. Эрдэм шинжилгээний ажлын үр дүн

Тодорхойлолт: Шинжлэх ухааны үйл ажиллагааны хүрээнд бий болсон шинэ болон нэмэлт мэдлэг, техник, технологийн шийдлийг илэрхийлсэн мэдээллийг ойлгоно.

Тооцох арга зүй: Тайлант онд дотооддоо болон гадаадад гүйцэтгэсэн эрдэм шинжилгээ, судалгаа хөгжүүлэлтийн ажлуудын үр дүнгийн нийлбэрээр илэрхийлэгдэнэ.

Мэдээллийн эх үүсвэр, давтамж: БШУЯ-ны ШУТ-ийн жилийн эцсийн мэдээгээр жил бүр тооцно.

Мэдээллийн задаргаа: Улсын хэмжээнд тооцно.

7. Нэг хүнд ногдох судалгаа хөгжүүлэлтийн ажлын дотоодын нийт зардал (НХНСХАДНЗ)

Тооцох арга зүй: Тайлант оны судалгаа хөгжүүлэлтийн ажлын дотоодын нийт зардлыг тухайн жилийн хүн амын тоотой харьцуулна.

$$\text{НХНСХАДНЗ} = \frac{\text{Хүн амын тоо}}{\text{СХАДНЗ}}$$

НХНСХАДНЗ – Нэг хүнд ногдох судалгаа хөгжүүлэлтийн ажлын дотоодын нийт зардал

СХАДНЗ – Судалгаа хөгжүүлэлтийн ажлын дотоодын нийт зардал

Мэдээллийн эх үүсвэр, давтамж: БШУЯ-ны ШУТ-ийн жилийн эцсийн мэдээгээр жил бүр тооцно.

Мэдээллийн задаргаа: Улсын хэмжээнд тооцно.

8. Суурь судалгааны зардлын ДНБ-д эзлэх хувь

Тооцох арга зүй: Тайлант онд гүйцэтгэсэн суурь судалгааны нийт зардлыг тухайн жилийн ДНБ-д харьцуулж 100-аар үржүүлнэ.

$$\text{ССЗДНБЭХ} = \frac{\text{ССАНЗ}}{\text{ДНБ}} * 100$$

ССАНЗ – Суурь судалгааны ажлын нийт зардал

ССЗДНБЭХ – Суурь судалгааны зардлын дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь

Мэдээллийн эх үүсвэр, давтамж: БШУЯ-ны ШУТ-ийн жилийн эцсийн мэдээгээр жил бүр тооцно.

Мэдээллийн задаргаа: Улсын хэмжээнд тооцно.

9. Салбарын нийт зардалд Байгалийн ухааны салбарын зардлын эзлэх хувь (СНЗБУСЗЭХ)

Тооцох арга зүй: Тайлант жилд Байгалийн шинжлэх ухаанд зарцуулсан зардлыг салбарын нийт зардлын хэмжээнд харьцуулж 100-гаар үржүүлнэ.

$$\text{СНЗБУСЗЭХ} = \frac{\text{БШУ – ны зардал}}{\text{ШУ – ны нийт салбарын зардал}} * 100$$

СНЗБУСЗЭХ – Салбарын нийт зардалд Байгалийн ухааны салбарын зардлын эзлэх хувь

Мэдээллийн эх үүсвэр, давтамж: БШУЯ-ны ШУТ-ийн жилийн эцсийн мэдээгээр жил бүр тооцно.

Мэдээллийн задаргаа: Улсын хэмжээнд салбар тус бүрээр тооцох боломжтой.

10. Салбарын нийт зардалд Инженер технологийн салбарын зардлын эзлэх хувь (СНЗИТСЗЭХ)

Тооцох арга зүй: Тайлант жилд Инженер технологийн шинжлэх ухаанд зарцуулсан зардлыг салбарын нийт зардлын хэмжээнд харьцуулж 100-гаар үржүүлнэ.

$$\text{СНЗИТСЗЭХ} = \frac{\text{НШУ} - \text{ны зардал}}{\text{ШУ} - \text{ны нийт салбарын зардал}} * 100$$

СНЗИТСЗЭХ – Салбарын нийт зардалд Инженер технологийн салбарын зардлын эзлэх хувь

Мэдээллийн эх үүсвэр, давтамж: БШУЯ-ны ШУТ-ийн жилийн эцсийн мэдээгээр жил бүр тооцно.

Мэдээллийн задаргаа: Улсын хэмжээнд салбар тус бүрээр тооцох боломжтой.

11. Салбарын нийт зардалд Анагаах ухааны салбарын зардлын эзлэх хувь (СНЗАУСЗЭХ)

Тооцох арга зүй: Тайлант жилд Анагаахын шинжлэх ухаанд зарцуулсан зардлыг салбарын нийт зардлын хэмжээнд харьцуулж 100-гаар үржүүлнэ.

$$\text{СНЗАУСЗЭХ} = \frac{\text{АШУ} - \text{ны зардал}}{\text{ШУ} - \text{ны нийт салбарын зардал}} * 100$$

СНЗАУСЗЭХ – Салбарын нийт зардалд Анагаах ухааны салбарын зардлын эзлэх хувь

Мэдээллийн эх үүсвэр, давтамж: БШУЯ-ны ШУТ-ийн жилийн эцсийн мэдээгээр жил бүр тооцно.

Мэдээллийн задаргаа: Улсын хэмжээнд салбар тус бүрээр тооцох боломжтой.

12. Салбарын нийт зардалд Хөдөө аж ахуйн салбарын зардлын эзлэх хувь (СНЗХААСЗЭХ)

Тооцох арга зүй: Тайлант жилд Хөдөө аж ахуйн шинжлэх ухаанд зарцуулсан зардлыг салбарын нийт зардлын хэмжээнд харьцуулж 100-гаар үржүүлнэ.

$$\text{СНЗХААСЗЭХ} = \frac{\text{ХААС} - \text{ын зардал}}{\text{ШУ} - \text{ны нийт салбарын зардал}} * 100$$

СНЗХААСЗЭХ – Салбарын нийт зардалд Хөдөө аж ахуйн салбарын зардлын эзлэх хувь

Мэдээллийн эх үүсвэр, давтамж: БШУЯ-ны ШУТ-ийн жилийн эцсийн мэдээгээр жил бүр тооцно.

Мэдээллийн задаргаа: Улсын хэмжээнд салбар тус бүрээр тооцох боломжтой.

13. Салбарын нийт зардалд Нийгмийн ухааны салбарын зардлын эзлэх хувь (СНЗНУСЗЭХ)

Тооцох арга зүй: Тайлант жилд Нийгмийн шинжлэх ухаанд зарцуулсан зардлыг салбарын нийт зардлын хэмжээнд харьцуулж 100-гаар үржүүлнэ.

$$\text{СНЗНУСЗЭХ} = \frac{\text{НШУ} - \text{ны зардал}}{\text{ШУ} - \text{ны нийт салбарын зардал}} * 100$$

СНЗНУСЗЭХ – Салбарын нийт зардалд Нийгмийн ухааны салбарын зардлын эзлэх хувь

Мэдээллийн эх үүсвэр, давтамж: БШУЯ-ны ШУТ-ийн жилийн эцсийн мэдээгээр жил бүр тооцно.

Мэдээллийн задаргаа: Улсын хэмжээнд салбар тус бүрээр тооцох боломжтой.

14. Салбарын нийт зардалд Хүмүүнлэгийн ухааны салбарын зардлын эзлэх хувь (СНЗХУСЗЭХ)

Тооцох арга зүй: Тайлант жилд Хүмүүнлэгийн шинжлэх ухаанд зарцуулсан зардлыг салбарын нийт зардлын хэмжээнд харьцуулж 100-гаар үржүүлнэ.

$$\text{СНЗХУСЗЭХ} = \frac{\text{ХУС} - \text{ын зардал}}{\text{ШУ} - \text{ны нийт салбарын зардал}} * 100$$

СНЗХУСЗЭХ – Салбарын нийт зардалд Хүмүүнлэгийн ухааны салбарын зардлын эзлэх хувь

Мэдээллийн эх үүсвэр, давтамж: БШУЯ-ны ШУТ-ийн жилийн эцсийн мэдээгээр жил бүр тооцно.

Мэдээллийн задаргаа: Улсын хэмжээнд салбар тус бүрээр тооцох боломжтой.

15. Судалгаа хөгжүүлэлтийн ажлын дотоодын нийт зардалд төсвийн санхүүжилтийн эзлэх хувь

Тооцох арга зүй: Тайлант жилийн судалгаа хөгжүүлэлтэд зарцуулсан Засгийн газрын санхүүжилтийн хэмжээг судалгаа хөгжүүлэлтэд зарцуулсан дотоодын нийт зардлын хэмжээнд харьцуулж, 100-гаар үржүүлнэ.

$$\text{СХАДНЗТСЭХ} = \frac{\text{СХА} - \text{д зарцуулсан ЗГСХ}}{\text{СХА} - \text{д зарцуулсан ДНЗХ}} * 100$$

СХАДНЗТСЭХ – Судалгаа хөгжүүлэлтийн ажлын дотоодын нийт зардалд төсвийн санхүүжилтийн эзлэх хувь

ЗГСХ-Засгийн газрын санхүүжилтийн хэмжээ

ДНЗХ-Дотоодын нийт зардлын хэмжээ

Мэдээллийн эх үүсвэр, давтамж: БШУЯ-ны ШУТ-ийн жилийн эцсийн мэдээгээр жил бүр тооцно.

Мэдээллийн задаргаа: Улсын хэмжээнд тооцох боломжтой.

16. Дотоодын судалгаа хөгжүүлэлтийн ажлын нийт зардалд төсвийн бус эх үүсвэрийн эзлэх хувь

Тооцох арга зүй: Тайлант жилийн судалгаа хөгжүүлэлтэд зарцуулсан төсвийн бус эх үүсвэрийн хэмжээг судалгаа хөгжүүлэлтэд зарцуулсан дотоодын нийт зардлын хэмжээнд харьцуулж, 100-гаар үржүүлнэ.

$$ДСХАНЗТБСЭҮЭХ = \frac{СХА - д зарцуулсан ТБЭҮХ}{СХА - д зарцуулсан ДНЗХ} * 100$$

ДСХАНЗТБСЭҮЭХ - Дотоодын судалгаа хөгжүүлэлтийн ажлын нийт зардалд төсвийн бус эх үүсвэрийн эзлэх хувь

Мэдээллийн эх үүсвэр, давтамж: БШУЯ-ны ШУТ-ийн жилийн эцсийн мэдээгээр жил бүр тооцно.

Мэдээллийн задаргаа: Улсын хэмжээнд тооцох боломжтой.

17. Дотоодын судалгаа хөгжүүлэлтийн ажлын нийт зардалд суурь болон хэрэглээний судалгааны зардлын эзлэх хувь

Тооцох арга зүй: Тайлант жилийн судалгаа хөгжүүлэлтэд зарцуулсан суурь болон хэрэглээний судалгааны зардлын хэмжээг судалгаа хөгжүүлэлтэд зарцуулсан дотоодын нийт зардлын хэмжээнд харьцуулж, 100-гаар үржүүлнэ.

$$СХСЗЭХ = \frac{СХА - д зарцуулсан СБХСЗХН}{СХА - д зарцуулсан ДНЗХ} * 100$$

*СБХСЗХ- Суурь болон хэрэглээний судалгааны зардлын хэмжээний нийлбэр
ДНЗСХСЗЭХ-Дотоодын нийт зардалд суурь, хэрэглээний судалгааны зардлын эзлэх хувь*

Мэдээллийн эх үүсвэр, давтамж: БШУЯ-ны ШУТ-ийн жилийн эцсийн мэдээгээр жил бүр тооцно.

Мэдээллийн задаргаа: Улсын хэмжээнд тооцох боломжтой.

18. Хувийн хэвшлийн байгууллагын судалгаа хөгжүүлэлтийн ажилд Засгийн газраас олгосон санхүүжилтийн дундаж хэмжээ, сая төгрөг (ХХБСХАЗГОСДХ)

Тооцох арга зүй: Хувийн хэвшлийн судалгаа хөгжүүлэлтийн ажилд Засгийн газраас үзүүлж буй санхүүгийн дэмжлэгийн хэмжээ. *Олгосон санхүүжилтийн хэмжээгээр.*

Мэдээллийн эх үүсвэр, давтамж: БШУЯ-ны ШУТ-ийн жилийн эцсийн мэдээгээр жил бүр тооцно.

Мэдээллийн задаргаа: Улсын хэмжээнд тооцох боломжтой.

19. Хувийн хэвшлийн байгууллагын СХА-ын зардал (BERD)

Тооцох арга зүй: Хувийн хэвшлийн байгууллагын СХА-д зарцуулсан зардал.

Мэдээллийн эх үүсвэр, давтамж: БШУЯ-ны ШУТ-ийн жилийн эцсийн мэдээгээр жил бүр тооцно.

Мэдээллийн задаргаа: Улсын хэмжээнд тооцох боломжтой.

20. Хувийн хэвшлийн байгууллагын судалгаа хөгжүүлэлтийн ажлын зардлын ДНБ-д эзлэх хувь (ХХБСХАЗДНБЭХ)

Тооцох арга зүй: Тайлант жилийн хувийн хэвшлийн байгууллагын СХА-ын зардлыг тайлант оны ДНБ-ий хэмжээнд харьцуулж 100-д үржүүлнэ.

$$\text{ХХБСХАЗДНБЭХ} = \frac{\text{ХХБСХАЗ}}{\text{ДНБ}} * 100$$

Мэдээллийн эх үүсвэр, давтамж: БШУЯ-ны ШУТ-ийн жилийн эцсийн мэдээгээр жил бүр тооцно.

Мэдээллийн задаргаа: Улсын хэмжээнд тооцох боломжтой.

21. Дээд боловсролын байгууллагын СХА-ын зардал (HERD)

Тооцох арга зүй: Дээд боловсролын байгууллагын СХА-д зарцуулсан зардал.

Мэдээллийн эх үүсвэр, давтамж: БШУЯ-ны ШУТ-ийн жилийн эцсийн мэдээгээр жил бүр тооцно.

Мэдээллийн задаргаа: Улсын хэмжээнд тооцох боломжтой.

22. Төрийн бус байгууллагын СХА-ын зардал (PNPERD)

Тооцох арга зүй: Төрийн бус байгууллагын зарцуулсан зардал.

Мэдээллийн эх үүсвэр, давтамж: БШУЯ-ны ШУТ-ийн жилийн эцсийн мэдээгээр жил бүр тооцно.

Мэдээллийн задаргаа: Улсын хэмжээнд тооцох боломжтой.

23. Инженер технологийн чиглэлийн Судалгаа хөгжүүлэлтийн ажилд зориулж Засгийн газраас олгосон санхүүжилтийн хэмжээ

Тооцох арга зүй: Инженер технологийн судалгаа хөгжүүлэлтийн ажилд Засгийн газраас үзүүлж буй санхүүгийн дэмжлэгийн хэмжээ. Олгосон санхүүжилтийн хэмжээгээр

Мэдээллийн эх үүсвэр, давтамж: БШУЯ-ны ШУТ-ийн жилийн эцсийн мэдээгээр жил бүр тооцно.

Мэдээллийн задаргаа: Улсын хэмжээнд тооцох боломжтой.

24. Инженер технологийн чиглэлийн Судалгаа хөгжүүлэлтийн ажилд зориулж төсвийн бус эх үүсвэрээс олгосон санхүүжилт

Тооцох арга зүй: Инженер технологийн судалгаа хөгжүүлэлтийн ажилд төсвийн бус эх үүсвэрээс үзүүлж буй санхүүгийн дэмжлэгийн хэмжээ. Олгосон санхүүжилтийн хэмжээгээр

Мэдээллийн эх үүсвэр, давтамж: БШУЯ-ны ШУТ-ийн жилийн эцсийн мэдээгээр жил бүр тооцно.

Мэдээллийн задаргаа: Улсын хэмжээнд тооцох боломжтой.

25. Их, дээд сургууль, коллеж төгсөгчдийн нийт дүнд инженер технологийн чиглэлээр төгсөгчдийн эзлэх хувь

Тооцох арга зүй: Тайланд жилд их, дээд сургууль, коллежийг инженер технологийн чиглэлээр төгсөгчдийн тоог тухайн онд их, дээд сургууль, коллежийг төгсөгчдийн тоонд харьцуулж 100-аар үржүүлнэ.

$$ИТЧТЭХ = \frac{ИДСКИТЧТТ}{ИДСКТТ} * 100$$

ИТЧТЭХ – Инженер технологийн чиглэлээр төгсөгчдийн эзлэх хувь

ИДСКИТЧТТ – Их, дээд сургууль, коллежийг инженер технологийн чиглэлээр төгсөгчдийн тоо

ИДСКТТ - Их, дээд сургууль, коллежийг төгсөгчдийн тоо

Мэдээллийн эх үүсвэр, давтамж: БШУЯ-ны дээд боловсролын статистик мэдээгээр жил бүр тооцно.

Мэдээллийн задаргаа: Улсын хэмжээнд тооцох боломжтой.

26. Нийт судлаачид (бүтэн цагийн):

Үзүүлэлтийн тодорхойлолт: Судалгаа хөгжүүлэлтийн ажилд бүтэн цагаар оролцдог шинэ мэдлэг, бүтээгдэхүүн, процесс, аргачлал, системийн санаачлах, бүтээх мөн төслийн удирдлагыг хэрэгжүүлдэг мэргэжилтнийг оруулна.

Тооцох арга зүй: Тухайн жилд шинжлэх ухаан, технологийн салбарт бүтэн цагаар ажилласан нийт судлаачдын тоогоор гарна.

Мэдээллийн эх үүсвэр, давтамж: БШУЯ-ны ШУТ-ийн жилийн эцсийн мэдээгээр жил бүр тооцно.

Мэдээллийн задаргаа: Улсын хэмжээнд ЭШБ-уудын өмчийн хэлбэр, ажиллаж буй шинжлэх ухааны салбараар тооцох боломжтой.

27. Нийт судлаачдын дотор төрийн байгууллагын судлаачдын эзлэх хувь (НСДТБСЭХ)

Тооцох арга зүй: Тайланд жилд төрийн байгууллагад ажилласан судлаачдын тоог тухайн оны нийт судлаачдын тоонд харьцуулж 100-аар үржүүлнэ.

$$\text{НСДХХБСЭХ} = \frac{\text{ТБАСТ}}{\text{НСТ}} * 100$$

НСДТБСЭХ – Нийт судлаачдын дотор төрийн байгууллагын судлаачдын эзлэх хувь

ТБАСТ – Төрийн байгууллагад ажилласан судлаачдын тоо

НСТ - Нийт судлаачдын тоо

Мэдээллийн эх үүсвэр, давтамж: БШУЯ-ны ШУТ-ийн жилийн эцсийн мэдээгээр жил бүр тооцно.

Мэдээллийн задаргаа: Улсын хэмжээнд тооцох боломжтой.

28. Нийт судлаачдын дотор хувийн хэвшлийн байгууллагын судлаачдын эзлэх хувь

Тооцох арга зүй: Тайланд жилд хувийн хэвшлийн байгууллагад ажилласан судлаачдын тоог тухайн оны нийт судлаачдын тоонд харьцуулж 100-аар үржүүлнэ.

$$\text{НСДХХБСЭХ} = \frac{\text{ХХБАСТ}}{\text{НСТ}} * 100$$

НСДХХБСЭХ – Нийт судлаачдын дотор хувийн хэвшлийн байгууллагын судлаачдын эзлэх хувь

ХХБАСТ – Хэвшлийн байгууллагад ажилласан судлаачдын тоо

НСТ - Нийт судлаачдын тоо

Мэдээллийн эх үүсвэр, давтамж: БШУЯ-ны ШУТ-ийн жилийн эцсийн мэдээгээр жил бүр тооцно.

Мэдээллийн задаргаа: Улсын хэмжээнд тооцох боломжтой.

29. Нийт судлаачдын дотор төрийн бус байгууллагын судлаачдын эзлэх хувь

Тооцох арга зүй: Тайланд жилд хувийн хэвшлийн байгууллагад ажилласан судлаачдын тоог тухайн оны нийт судлаачдын тоонд харьцуулж 100-аар үржүүлнэ.

$$\text{НСДТБСЭХ} = \frac{\text{ХХБАСТ}}{\text{НСТ}} * 100$$

НСДТБСЭХ – Нийт судлаачдын дотор төрийн бус байгууллагын судлаачдын эзлэх хувь

ТББАСТ – Төрийн бус байгууллагад ажилласан судлаачдын тоо

Мэдээллийн эх үүсвэр, давтамж: БШУЯ-ны ШУТ-ийн жилийн эцсийн мэдээгээр жил бүр тооцно.

Мэдээллийн задаргаа: Улсын хэмжээнд тооцох боломжтой.

30. Нийт судлаачдын дотор докторын зэрэгтэй судлаачдын эзлэх хувь

Тооцох арга зүй: Тайланд жилд докторын зэрэгтэй судлаачдын тоог тухайн оны нийт судлаачдын тоонд харьцуулж 100-аар үржүүлнэ. Шинэчлэн санал болгож буй ШУТ маягтад докторын зэргийг шинжлэх ухааны доктор, боловсролын доктор гэж ангилсан. Тус үзүүлэлтийг тооцоходоо дээрх 2 ангиллын нийлбэрийг авна.

$$\text{НСДДЗСЭХ} = \frac{\text{ДЗСТ}}{\text{НСТ}} * 100$$

НСДДЗСЭХ – Нийт судлаачдын дотор докторын зэрэгтэй судлаачдын эзлэх хувь

ДЗСТ – Докторын зэрэгтэй судлаачдын тоо

НСТ - Нийт судлаачдын тоо

Мэдээллийн эх үүсвэр, давтамж: БШУЯ-ны ШУТ-ийн жилийн эцсийн мэдээгээр жил бүр тооцно.

Мэдээллийн задаргаа: Улсын хэмжээнд тооцох боломжтой.

31. Нийт судлаачдын дотор эмэгтэй судлаачдын эзлэх хувь (НСДЭСЭХ)

Тооцох арга зүй: Тайланд жилийн эмэгтэй судлаачдын тоог тухайн оны нийт судлаачдын тоонд харьцуулж 100-аар үржүүлнэ.

$$\text{НСДЭСЭХ} = \frac{\text{ЭСТ}}{\text{НСТ}} * 100$$

НСДЭСЭХ – Нийт судлаачдын дотор эмэгтэй судлаачдын эзлэх хувь

ЭСТ – Эмэгтэй судлаачдын тоо

НСТ - Нийт судлаачдын тоо

Мэдээллийн эх үүсвэр, давтамж: БШУЯ-ны ШУТ-ийн жилийн эцсийн мэдээгээр жил бүр тооцно.

Мэдээллийн задаргаа: Улсын хэмжээнд тооцох боломжтой.

32. Аж үйлдвэрийн 1000 ажил эрхлэгчид ногдох судлаачдын тоо

Тооцох арга зүй: Тайланд жилд нийт судлаачдын тоог тухайн оны аж үйлдвэрийн салбарт ажиллагчдын тоонд харьцуулж 1000-аар үржүүлнэ.

$$\text{АУСМАЭНСТ} = \frac{\text{НСТ}}{\text{АУСА}} * 1000$$

АУСА – Аж үйлдвэрийн салбарт ажиллагчид

АУСМАЭНСТ – Аж үйлдвэрийн салбарын мянган ажил эрхлэгчид ногдох судлаачдын тоо

Мэдээллийн эх үүсвэр, давтамж: ҮСХ-ны аж үйлдвэрийн салбарын статистик мэдээнээс жил бүр, БШУЯ-ны ШУТ-ийн жилийн эцсийн мэдээгээр жил бүр тооцно.

Мэдээллийн задаргаа: Улсын хэмжээнд тооцох боломжтой.

33. 1000 ажил эрхэлдэг хүнд ногдох “СХА-ын нийт ажиллагчдын тоо”

Тооцох арга зүй: Тайлант онд ажилласан СХА-ын нийт ажиллагчдын тоог тухайн жилд ажил эрхэлж буй хүний тоонд хувааж 1000-аар үржүүлнэ.

$$\text{МАЭХНСХАНАТ} = \frac{\text{СХАНАТ}}{\text{АЭХТ}} * 1000$$

СХАНАТ – Судалгаа хөгжүүлэлтийн ажлын нийт ажиллагчдын тоо

АЭХТ – Ажил эрхэлдэг хүний тоо

МАЭХНСХАНАТ – 1000 ажил эрхэлдэг хүнд ногдох СХА-ын нийт ажиллагчдын тоо

Мэдээллийн эх үүсвэр, давтамж: ҮСХ-ны хүн амын салбарын статистик, БШУЯ-ны ШУТ-ийн жилийн эцсийн мэдээгээр жил бүр тооцно.

Мэдээллийн задаргаа: Улсын хэмжээнд тооцох боломжтой.

34. ДНБ-д өндөр, дунд технологийн боловсруулах үйлдвэрийн салбарын нэмэгдэл өртгийн эзлэх хувь

Тодорхойлолт: Өндөр болон дунд технологийн боловсруулах үйлдвэрийн салбарын нэмэгдэл өртгийн хэмжээг эдийн засгийн нийт гарцад харьцуулсан харьцаа юм.

Тооцох арга зүй: Тайлант жилийн өндөр болон дунд технологийн боловсруулах үйлдвэрийн салбарын нэмэгдэл өртгийн хэмжээг тухайн оны ДНБ-ий хэмжээнд харьцуулж 100-д үржүүлнэ.

$$\text{ӨДТБҮСНӨЭХ} = \frac{\text{ӨДТБҮСНӨ}}{\text{ДНБ}} * 100$$

ӨДТБҮСНӨЭХ – Өндөр, дунд технологийн боловсруулах үйлдвэрийн салбарын нэмэгдэл өртгийн эзлэх хувь

ӨДТБҮСНӨ – Өндөр, дунд технологийн боловсруулах үйлдвэрийн салбарын нэмэгдэл өртөг

Мэдээллийн эх үүсвэр, давтамж: Сангийн яам, БШУЯ, төсвийн мэдээ, захиргааны статистикийн мэдээ

Мэдээллийн задаргаа: СХА-ын зардлыг санхүүжилтийн эх үүсвэрээр, шинжлэх ухааны салбараар, судалгааны төрлөөр, зардлын төрлөөр гаргана.

Хариуцах байгууллага: Сангийн яам, БШУЯ, ҮСХ

35. Дотоодын судалгаа хөгжүүлэлтийн ажлын нийт зардалд эрдэм шинжилгээний байгууллагын судалгаа хөгжүүлэлтийн ажлын зардлын эзлэх хувь (ЭШБСХАЗЭХ)

Тооцох арга зүй: Тайлант жилийн судалгаа хөгжүүлэлтэд зарцуулсан дээд боловсролын байгууллагын зардлын хэмжээг судалгаа хөгжүүлэлтэд зарцуулсан дотоодын нийт зардлын хэмжээнд харьцуулж, 100-гаар үржүүлнэ.

$$\text{ЭШБСХАЗЭХ} = \frac{\text{ЭШБСХАЗ}}{\text{СХАДНЗ}} * 100$$

ЭШБСХАЗЭХ – Эрдэм шинжилгээний байгууллагын судалгаа хөгжүүлэлтийн ажлын зардлын эзлэх хувь

ЭШБСХАЗ – Эрдэм шинжилгээний байгууллагын судалгаа хөгжүүлэлтийн ажлын зардал

Мэдээллийн эх үүсвэр, давтамж: БШУЯ-ны ШУТ-ийн жилийн эцсийн мэдээгээр жил бүр тооцно.

Мэдээллийн задаргаа: Улсын хэмжээнд тооцох боломжтой.

36. 10 мянган оршин суугчдад ногдох бүтэн цагаар ажилладаг судлаачдын тоо (АМОСНБЦАСТ)

Тооцох арга зүй: Тайланд жилийн бүтэн цагаар ажилласан судлаачдын тоог 10 мянган оршин суугчдын тоонд харьцуулна.

$$\text{АМОСНБЦАСТ} = \frac{\text{БЦАС}}{10000}$$

АМОСНБЦАСТ – Эрдэм шинжилгээний байгууллагын судалгаа хөгжүүлэлтийн ажлын зардлын эзлэх хувь

БЦАС – Бүтэн цагаар ажилладаг судлаач

Мэдээллийн эх үүсвэр, давтамж: БШУЯ-ны ШУТ-ийн жилийн эцсийн мэдээгээр жил бүр тооцно.

Мэдээллийн задаргаа: Улсын хэмжээнд тооцох боломжтой.

37. 1000 ажил эрхэлдэг хүнд ногдох “бүтэн цагаар ажилладаг нийт судлаачийн тоо” (МАЭХТНБЦАНСТ)

Тооцох арга зүй: Тайланд жилийн бүтэн цагаар ажилладаг нийт судлаачийн тоог ажил эрхлэгчдийн тоонд хувааж 1000-аар үржүүлнэ.

$$\text{АМОСНБЦАСТ} = \frac{\text{БЦАНСТ}}{\text{АЭХТ}} * 1000$$

МАЭХТНБЦАНСТ – 33. 1000 ажил эрхэлдэг хүнд ногдох “бүтэн цагаар ажилладаг нийт судлаачийн тоо”

БЦАНСТ – Бүтэн цагаар ажилладаг нийт судлаачийн тоо

Мэдээллийн эх үүсвэр, давтамж: БШУЯ-ны ШУТ-ийн жилийн эцсийн мэдээгээр жил бүр тооцно.

Мэдээллийн задаргаа: Улсын хэмжээнд тооцох боломжтой.

38. СХА-д хуваарилсан Засгийн газрын төсвийн хуваарилалт (GBARD)

Тооцох арга зүй: Судалгаа хөгжүүлэлтийн ажилд Засгийн газраас зарцуулсан санхүүжилтийн хэмжээ, сая төгрөг.

Мэдээллийн эх үүсвэр, давтамж: БШУЯ-ны ШУТ-ийн жилийн эцсийн мэдээгээр жил бүр тооцно.

Мэдээллийн задаргаа: Улсын хэмжээнд тооцох боломжтой.

39. Засгийн газрын СХА-ын зардал (GOVERD)

Тооцох арга зүй: СХА-д Засгийн газрын харьяа байгууллагуудын зарцуулсан зардлын хэмжээ, сая төгрөг.

Мэдээллийн эх үүсвэр, давтамж: БШУЯ-ны ШУТ-ийн жилийн эцсийн мэдээгээр жил бүр тооцно.

Мэдээллийн задаргаа: Улсын хэмжээнд тооцох боломжтой.

4.4.5 Үр дүнг ашиглах

1. Шинжлэх ухаан технологийн үндсэн үзүүлэлтийг нэгдсэн арга зүйн дагуу цуглуулж, статистикийн эмхэтгэл, танилцуулгад тусгаж нийтэд тархаана.
2. Энэхүү аргачлалыг шинжлэх ухаан, технологийн үйл ажиллагаа хариуцсан байгууллагууд үйл ажиллагаандаа мөрдөж, мэдээллийн нэгдсэн санг бий болгох, мэдээ, мэдээллийг уялдуулах суурь болно

4.4.6 ШУТ-ийн үндсэн үзүүлэлтийг тооцох аргачлалын хүрээ

Хүснэгт 38. ШУТ-ийн үндсэн үзүүлэлтийг тооцох аргачлалын хүрээ

№	Indicators	Үндсэн үзүүлэлт	Тооцох үзүүлэлт	Эх үүсвэр	Томьёо	Тайлбар	Тооцоолж байгаа эсэх	Боломжтой эсэх	Судалгаа авах аргачлал
1	Total research organization	Эрдэм шинжилгээний байгууллагын тоо		ШУТ-1 маягт, I.Хаягийн хэсгийн 5-р хүснэгт	ШУТ маягтад хамрагдсан нийт байгууллагын тоогоор гарна.	Тайлант онд үйл ажиллагаа явуулсан нийт эрдэм шинжилгээний байгууллагын тоог тодорхойлно.	+	+	ШУТ маягтаар
2	Expenditure on science and technology	Шинжлэх ухаан, технологийн салбарын зардал (ШУТСЗ)		ШУТ-2.III маягт, Мөр 20 ААНБ-1 ААНБ-2	Тайлант онд дотооддоо гүйцэтгэсэн шинжлэх ухаан, технологийн ажлын зардлын нийлбэрээр илэрхийлэгдэнэ.	ШУТ-2 маягтын нийлбэрээр. Хэрэв ШУТ маягтыг хувийн хэвшлийн ААНБ-аас авч чадахгүй бол ААНБ-1 болон ААНБ-2 маягтаас ҮСХ-оос авч ашиглана.	-	+	ШУТ маягтаар
3	Science and technology expenditure as a percentage of GDP	ДНБ-нд шинжлэх ухаан, технологийн салбарын зардлын эзлэх хувь	ШУТ-ийн салбарын нийт зардал	ШУТ-2.III маягт, Мөр 20	(ШУТ-2.III маягт, Мөр 20)/ ДНБ*100	Тайлант оны шинжлэх ухаан технологийн салбарын зардлыг тухайн оны ДНБ-ий хэмжээнд харьцуулж 100-д үржүүлнэ.	-	+	Тооцооллоор
			ДНБ	ҮСХ					
4	Gross Domestic Expenditure on R&D (GERD)	Судалгаа хөгжүүлэлтийн ажлын дотоодын нийт зардал-GERD (СХАДНЗ)		ШУТ-2 маягт, Мөр32 ААНБ-1 ААНБ-2	Тайлант онд дотооддоо гүйцэтгэсэн СХА-ын зардлын нийлбэрээр илэрхийлэгдэнэ.	ШУТ-2 маягтын нийлбэрээр. Хэрэв ШУТ маягтыг хувийн хэвшлийн ААНБ-аас авч чадахгүй бол ААНБ-1 болон ААНБ-2 маягтаас ҮСХ-оос авч ашиглана.	-	+	Тооцооллоор
5	GERD as a percentage of GDP	ДНБ-д судалгаа, хөгжүүлэлтийн ажлын зардлын	СХА-ын зардлын нийт хэмжээ	ШУТ-2 маягт, Мөр32	(ШУТ-2 маягт, Мөр32)/	Тайлант оны судалгаа хөгжүүлэлтийн зардлын хэмжээг тухайн оны ДНБ-ий	-	+	Тооцооллоор

		эзлэх хувь (ДНБСХЗЭХ)	ДНБ	ҮСХ	ДНБ*100	хэмжээнд харьцуулж 100-д үржүүлнэ.			
6	Result of research work	Эрдэм шинжилгээний ажлын үр дүн		ШУТ-4 маягт		Тайлант онд дотооддоо болон гадаадад гүйцэтгэсэн эрдэм шинжилгээ, судалгаа хөгжүүлэлтийн ажлуудын үр дүнгийн нийлбэрээр илэрхийлэгдэнэ.	+	+	ШУТ маягтаар
7	GERD per capita population	Нэг хүнд ногдох судалгаа хөгжүүлэлтийн ажлын дотоодын нийт зардал (НХНСХАДНЗ)	Хүн амын тоо	ҮСХ, Хүн амын статистик	(Хүн амын тоо)/	Тайлант оны судалгаа хөгжүүлэлтийн ажлын дотоодын нийт зардлыг тухайн жилийн хүн амын тоотой харьцуулна.			Тооцооллоор
			Судалгаа хөгжүүлэлтийн ажлын дотоодын нийт зардал (СХАДНЗ)	ШУТ-2 ААНБ-1 ААНБ-2	СХАДНЗ	Хэрэв ШУТ маягтыг хувийн хэвшлийн ААНБ-аас авч чадахгүй бол ААНБ-1 болон ААНБ-2 маягтаас ҮСХ-оос авч ашиглана.	-	+	
8	Basic research expenditure as a percentage of GDP	Суурь судалгааны ажлын зардлын ДНБ-д эзлэх хувь (ССАЗДНБЭХ)	Суурь судалгааны ажлын нийт зардал (ССАНЗ)	ШУТ-2 маягт, (Мөр 9, Багана 2)	(ШУТ-2 маягт, (Мөр 9, Багана 2))/ДНБ*100	Тайлант онд гүйцэтгэсэн суурь судалгааны нийт зардлыг тухайн жилийн ДНБ-д харьцуулж 100-аар үржүүлнэ.	+	+	Тооцооллоор
			ДНБ	ҮСХ					
9	Natural sciences expenditure as a percentage of total R&D expenditure	Салбарын нийт зардалд Байгалийн ухааны салбарын зардлын эзлэх хувь (СНЗБУСЗЭХ)	Байгалийн шинжлэх ухааны зардал	ШУТ-2 маягт, Мөр 1	(ШУТ-2 маягт, Мөр 1)/	Тайлант жилд Байгалийн шинжлэх ухаанд зарцуулсан зардлыг салбарын нийт зардлын хэмжээнд харьцуулж 100-гаар үржүүлнэ.	-	+	Тооцооллоор
			ШУ-ны нийт салбарын зардал	ШУТ-2 маягт, Мөр 8	(ШУТ-2 маягт, Мөр 8)*100				

10	Engineering and technology sciences expenditure as a percentage of R&D	Салбарын нийт зардалд Инженер технологийн салбарын зардлын эзлэх хувь (СНЗИТСЗЭХ)	Инженер технологийн шинжлэх ухааны зардал	ШУТ-2 маягт, Мөр 2	(ШУТ-2 маягт, Мөр 2)/	Тайлант жилд Инженер технологийн шинжлэх ухаанд зарцуулсан зардлыг салбарын нийт зардлын хэмжээнд харьцуулж 100-гаар үржүүлнэ.	-	+	Тооцооллоор
			ШУ-ны нийт салбарын зардал	ШУТ-2 маягт, Мөр 8	(ШУТ-2 маягт, Мөр 8)*100				
11	Medical and health sciences expenditure as a percentage of R&D	Салбарын нийт зардалд Анагаах ухааны салбарын зардлын эзлэх хувь (СНЗАУСЗЭХ)	Анагаахын шинжлэх ухааны зардал	ШУТ-2 маягт, Мөр 3	(ШУТ-2 маягт, Мөр 3)/	Тайлант жилд Анагаахын шинжлэх ухаанд зарцуулсан зардлыг салбарын нийт зардлын хэмжээнд харьцуулж 100-гаар үржүүлнэ.	-	+	Тооцооллоор
			ШУ-ны нийт салбарын зардал	ШУТ-2 маягт, Мөр 8	(ШУТ-2 маягт, Мөр 8)*100				
12	Agricultural and veterinary sciences expenditure as a percentage of R&D	Салбарын нийт зардалд Хөдөө аж ахуйн салбарын зардлын эзлэх хувь (СНЗХААСЗЭХ)	Хөдөө аж ахуйн шинжлэх ухааны зардал	ШУТ-2 маягт, Мөр 4	(ШУТ-2 маягт, Мөр 4)/	Тайлант жилд Хөдөө аж ахуйн шинжлэх ухаанд зарцуулсан зардлыг салбарын нийт зардлын хэмжээнд харьцуулж 100-гаар үржүүлнэ.	-	+	Тооцооллоор
			ШУ-ны нийт салбарын зардал	ШУТ-2 маягт, Мөр 8	(ШУТ-2 маягт, Мөр 8)*100				
13	Social sciences expenditure as a percentage of R&D	Салбарын нийт зардалд Нийгмийн ухааны салбарын зардлын эзлэх хувь (СНЗНУСЗЭХ)	Нийгмийн шинжлэх ухааны зардал	ШУТ-2 маягт, Мөр 5	(ШУТ-2 маягт, Мөр 5)/	Тайлант жилд Нийгмийн шинжлэх ухаанд зарцуулсан зардлыг салбарын нийт зардлын хэмжээнд харьцуулж 100-гаар үржүүлнэ.	-	+	Тооцооллоор
			ШУ-ны нийт салбарын зардал	ШУТ-2 маягт, Мөр 8	(ШУТ-2 маягт, Мөр 8)*100				
14	Humanities and the arts science expenditure	Салбарын нийт зардалд Хүмүүнлэгийн ухааны	Хүмүүнлэгийн шинжлэх ухааны зардал	ШУТ-2 маягт, Мөр 6	(ШУТ-2 маягт, Мөр 6)/	Тайлант жилд Хүмүүнлэгийн шинжлэх ухаанд зарцуулсан зардлыг салбарын нийт зардлын хэмжээнд	-	+	Тооцооллоор

	as a percentage of R&D	салбарын зардлын эзлэх хувь (СНЗХУСЗЭХ)	ШУ-ны нийт салбарын зардал	ШУТ-2 маягт, Мөр 8	(ШУТ-2 маягт, Мөр 8)*100	харьцуулж 100-гаар үржүүлнэ.			
15	Percentage of GERD financed by government	Судалгаа хөгжүүлэлтийн ажлын дотоодын нийт зардалд төсвийн санхүүжилтийн эзлэх хувь (СХАДНЗТСЭХ)	СХА-д зарцуулсан засгийн газрын санхүүжилтийн хэмжээ (ЗГСХ)	ШУТ-3 маягт, Мөр 1, Багана(6+9+12)	(ШУТ-3 маягт, Мөр 1, Багана(6+9+12)/	Тайлант жилийн судалгаа хөгжүүлэлтэд зарцуулсан Засгийн газрын санхүүжилтийн хэмжээг судалгаа хөгжүүлэлтэд зарцуулсан дотоодын нийт зардлын хэмжээнд харьцуулж, 100-гаар үржүүлнэ.	-	+	Тооцооллоор
			СХА-д зарцуулсан ДНЗХ	ШУТ-2 ААНБ-1 ААНБ-2	СХАДНЗ*100	Хэрэв ШУТ маягтыг хувийн хэвшлийн ААНБ-аас авч чадахгүй бол ААНБ-1 болон ААНБ-2 маягтаас ҮСХ-оос авч ашиглана.			
16	Percentage of GERD financed by non-government sources	Дотоодын судалгаа хөгжүүлэлтийн ажлын нийт зардалд төсвийн бус эх үүсвэрийн эзлэх хувь (ДСХАНЗТБСЭҮЭХ)	СХА-д зарцуулсан төсвийн бус эх үүсвэрийн эзлэх хувь (ТБЭҮХ)	(ШУТ-3 маягт, Мөр(13+17+20+27), Багана(6+9+12))	(ШУТ-3 маягт, Мөр(13+17+20+27), Багана(6+9+12))/	Тайлант жилийн судалгаа хөгжүүлэлтэд зарцуулсан төсвийн бус эх үүсвэрийн хэмжээг судалгаа хөгжүүлэлтэд зарцуулсан дотоодын нийт зардлын хэмжээнд харьцуулж, 100-гаар үржүүлнэ.	-	+	Тооцооллоор
						Хэрэв ШУТ маягтыг хувийн хэвшлийн ААНБ-аас авч чадахгүй бол ААНБ-1 болон ААНБ-2 маягтаас ҮСХ-оос авч ашиглана.			

			СХА-д зарцуулсан ДНЗХ	ШУТ-2 ААНБ-1 ААНБ-2	СХАДНЗ*100				
17	Basic and Applied research expenditure as a percentage of GERD	Дотоодын судалгаа хөгжүүлэлтийн ажлын нийт зардалд суурь болон хэрэглээний судалгааны зардлын эзлэх хувь (СБХСЗЭХ)	СХА-д зарцуулсан суурь болон хэрэглээний судалгааны зардлын хэмжээний нийлбэр (СБХСЗХН)	ШУТ-2 маягт, Мөр(8+12)	(ШУТ-2 маягт, Мөр(8+12))/СХА ДНЗ*100	Тайлант жилийн судалгаа хөгжүүлэлтэд зарцуулсан суурь болон хэрэглээний судалгааны зардлын хэмжээг судалгаа хөгжүүлэлтэд зарцуулсан дотоодын нийт зардлын хэмжээнд харьцуулж, 100-гаар үржүүлнэ.	-	+	Тооцооллоор
			СХА-д зарцуулсан ДНЗХ	ШУТ-2 ААНБ-1 ААНБ-2					
18	Percentage of BERD financed by government	Хувийн хэвшлийн байгууллагын судалгаа хөгжүүлэлтийн ажилд Засгийн газраас олгосон санхүүжилтийн хэмжээ, сая төгрөг (ХХБСХАЗГОСДХ)		ШУТ-3 маягт, Хаягийн хэсгийн 3.21-р ангиллаар ШУТ-3 маягтын Мөр 1, Багана-3-ын нийлбэр		Хувийн хэвшлийн судалгаа хөгжүүлэлтийн ажилд Засгийн газраас үзүүлж буй санхүүгийн дэмжлэгийн хэмжээ.	-	+	ШУТ маягтаар

19	Business enterprise expenditure on R&D (BERD)	Хувийн хэвшлийн байгууллагын СХА-ын зардал (BERD)		ШУТ-3 маягт, Хаягийн хэсгийн 3.21-р ангиллаар ШУТ-3 маягтын, Мөр 13-ын нийлбэр		Хувийн хэвшлийн байгууллагын СХА-д зарцуулсан зардал.	-	+	ШУТ маягтаар
20	BERD as a percentage of GDP	Хувийн хэвшлийн байгууллагын судалгаа хөгжүүлэлтийн ажлын зардлын ДНБ-д эзлэх хувь (ХХБСХАЗДНБЭХ)	Хувийн хэвшлийн байгууллагын СХА-ын зардал BERD (ХХБСХАЗ)	ШУТ-3 маягт, Хаягийн хэсгийн 3.21-р ангиллаар ШУТ-3 маягтын, Мөр 13-ын нийлбэр	BERD/ДНБ*100	Тайлант жилийн хувийн хэвшлийн байгууллагын СХА-ын зардлыг тайлант оны ДНБ-ий хэмжээнд харьцуулж 100-д үржүүлнэ.	-	+	Тооцооллоор
			ДНБ	ҮСХ					
21	Higher education expenditure on R&D	Дээд боловсролын байгууллагын СХА-ын зардал (HERD)		ШУТ-3 маягт, Хаягийн хэсгийн 3.21-р ангиллаар ШУТ-3 маягт, I-хүснэгтийн Мөр 17-ийн нийлбэр		Дээд боловсролын байгууллагын СХА-д зарцуулсан зардал.	+	+	ШУТ маягтаар
22	Private non-profit expenditure on R&D	Төрийн бус байгууллагын СХА-ын зардал (PNPERD)		ШУТ-3 маягт, Хаягийн хэсгийн 2-ын 70 кодоор, ШУТ-3 маягт, I-хүснэгтийн Мөр 20-ийн нийлбэр		Төрийн бус байгууллагын зарцуулсан зардал.	+	+	ШУТ маягтаар
23	Government budget allocation for Engineering and technology research	Инженер технологийн чиглэлийн Судалгаа хөгжүүлэлтийн ажилд зориулж Засгийн газраас олгосон		ШУТ-3 маягт, III-хүснэгт, Мөр-1 Багана-6		Инженер технологийн судалгаа хөгжүүлэлтийн ажилд Засгийн газраас үзүүлж буй санхүүгийн дэмжлэгийн хэмжээ. Олгосон санхүүжилтийн хэмжээгээр	-	+	ШУТ маягтаар

	and development	санхүүжилтийн хэмжээ							
24	Non-government budget allocation for engineering and technology research and development	Инженер технологийн салбарын Судалгаа хөгжүүлэлтийн ажилд зориулж төсвийн бус эх үүсвэрээс олгосон санхүүжилт		ШУТ-3 маягт, III-хүснэгт, Мөр(13+17+20+27, Багана 6)		Инженер технологийн судалгаа хөгжүүлэлтийн ажилд төсвийн бус эх үүсвэрээс үзүүлж буй санхүүгийн дэмжлэгийн хэмжээ. Олгосон санхүүжилтийн хэмжээгээр	-	+	Тооцоолоор
25	Engineer and technology graduates as a percentage of total higher education institution graduates	Их, дээд сургууль, коллеж төгсөгчдийн нийт дүнд инженер технологийн чиглэлээр төгсөгчдийн эзлэх хувь	Их, дээд сургууль, коллежийг инженер технологийн чиглэлээр төгсөгчдийн тоо (ИДСКИТЧТТ)	Боловсролын статистик, Их, дээд сургууль, коллеж төгсөгчдийн тоо мэдээ	(ИДСКИТЧТТ/ИДСКТТ)*100	Тайланд жилд их, дээд сургууль, коллежийг инженер технологийн чиглэлээр төгсөгчдийн тоог тухайн онд их, дээд сургууль, коллежийг төгсөгчдийн тоонд харьцуулж 100-аар үржүүлнэ.	-	+	Тооцоолоор
			Их, дээд сургууль, коллежийг төгсөгчдийн тоо (ИДСКТТ)	Боловсролын статистик, Их, дээд сургууль, коллеж төгсөгчдийн тоо мэдээ					

26	Full time researchers	Нийт судлаачид (бүтэн цагийн)		(ШУТ-1 маягт, Мөр 1)-(ШУТ-1 маягт, Мөр 6)		Тухайн жилд шинжлэх ухаан, технологийн салбарт бүтэн цагаар ажилласан нийт судлаачдын тоогоор гарна. ШУТ маягтаас нийт ажиллагчдын тоо болон БЦАХТШУ-ын зарүүгээр гарна.	-	+	ШУТ маягтаар
27	Government researchers as a percentage of total researchers	Нийт судлаачдын дотор төрийн байгууллагын судлаачдын эзлэх хувь (НСДТБСЭХ)	Төрийн байгууллагад ажилласан судлаачдын тоо (ТБАСТ)	ШУТ-1 маягтын Хаягийн хэсгийн 3-р хүснэгтээс төрийн байгууллагын судлаачдын тооны нийлбэрийг авна	(ТБАСТ)/(ШУТ-1 маягт, Мөр 1)*100	Тайланд жилд төрийн байгууллагад ажилласан судлаачдын тоог тухайн оны нийт судлаачдын тоонд харьцуулж 100-аар үржүүлнэ.	+	+	Тооцооллоор
			Нийт судлаачдын тоо (НСТ)	ШУТ-1 маягт, Мөр 1					
28	Business Enterprise researchers as a percentatge of total researchers	Нийт судлаачдын дотор хувийн хэвшлийн байгууллагын судлаачдын эзлэх хувь	Хэвшлийн байгууллагад ажилласан судлаачдын тоо (ХХБАСТ)	ШУТ-1 маягтын Хаягийн хэсгийн 3-р хүснэгтээс ХХБ-ын судлаачдын тооны нийлбэрийг авна.	(ХХБАСТ)/(ШУТ-1 маягт, Мөр 1)*100	Тайланд жилд хувийн хэвшлийн байгууллагад ажилласан судлаачдын тоог тухайн оны нийт судлаачдын тоонд харьцуулж 100-аар үржүүлнэ.	-	+	Тооцооллоор
			Нийт судлаачдын тоо (НСТ)	ШУТ-1 маягт, Мөр 1					

29	Private non-profit sector researchers as a percentatge of total researchers	Нийт судлаачдын дотор төрийн бус байгууллагын судлаачдын эзлэх хувь	Төрийн бус байгууллагад ажилласан судлаачдын тоо (ТББАСТ)	ШУТ-1 маягтын Хаягийн хэсгийн 2.70 ангиллаар ТББ-ын судлаачдын тооны нийлбэрийг авна	(ТББСТ)/(ШУТ-1 маягт, Мөр 1)*100	Тайланд жилд төрийн бус байгууллагад ажилласан судлаачдын тоог тухайн оны нийт судлаачдын тоонд харьцуулж 100-аар үржүүлнэ.	-	+	Тооцооллоор
			Нийт судлаачдын тоо (НСТ)	ШУТ-1 маягт, Мөр 1					
30	PhD Researchers as a percentage of total researchers	Нийт судлаачдын дотор докторын зэрэгтэй судлаачдын эзлэх хувь (НСДДЗСЭХ)	Докторын зэрэгтэй судлаачдын тоо (ДЗСТ)	ШУТ-1 маягт, Мөр 2, Багана 3+4	(ШУТ-1 маягт, Мөр 2, Багана 3+4)/ (ШУТ-1 маягт, Мөр 1)*100	Тайланд жилд докторын зэрэгтэй судлаачдын тоог тухайн оны нийт судлаачдын тоонд харьцуулж 100-аар үржүүлнэ.	-	+	Тооцооллоор
			Нийт судлаачдын тоо (НСТ)	ШУТ-1 маягт, Мөр 1					
31	Women researchers as a percentatge of total researchers	Нийт судлаачдын дотор эмэгтэй судлаачдын эзлэх хувь (НСДЭСЭХ)	Эмэгтэй судлаачдын тоо (ЭСТ)	ШУТ-1 маягт, II-хүснэгт, Мөр 1, Багана 3	(ШУТ-1 маягт, II-хүснэгт, Мөр1, Багана3) (ШУТ-1 маягт, Мөр 1)*100	Тайланд жилийн эмэгтэй судлаачдын тоог тухайн оны нийт судлаачдын тоонд харьцуулж 100-аар үржүүлнэ.	-	+	Тооцооллоор
			Нийт судлаачдын тоо (НСТ)	ШУТ-1 маягт, Мөр 1					
32	Researchers per thousand employment in industry	Аж үйлдвэрийн 1000 ажил эрхлэгчид ногдох судлаачдын тоо (АУМАЭНСТ)	Нийт судлаачдын тоо (НСТ)	ШУТ-1 маягт, Мөр 1	(ШУТ-1 маягт, Мөр 1)/ (АУСА)*1000	Тайланд жилд нийт судлаачдын тоог тухайн оны аж үйлдвэрийн салбарт ажиллагчдын тоонд харьцуулж 1000-аар үржүүлнэ.	-	+	Тооцооллоор
			Аж үйлдвэрийн салбарт ажиллагчид (АУСА)	Ажиллах хүчний судалгаа					
33	Total R&D personnel per thousand employment	1000 ажил эрхэлдэг хүнд ногдох "СХА-ын нийт ажиллагчдын	Судалгаа хөгжүүлэлтийн ажлын нийт ажиллагчдын тоо (СХАНАТ)	ШУТ-1 маягт, Мөр 1	(ШУТ-1 маягт, Мөр 1)/	Тайланд онд ажилласан СХА-ын нийт ажиллагчдын тоог тухайн жилд ажил эрхэлж буй хүний тоонд хувааж 1000-аар үржүүлнэ.	-	+	Тооцооллоор


		тоо” (МАЭХНСХАНАТ)	Ажил эрхэлдэг хүний тоо (АЭХТ)	Ажиллах хүчний судалгаа	АЭХТ*1000				
34	Medium and high-tech manufacturing value added share in GDP	ДНБ-д өндөр, дунд технологийн боловсруулах үйлдвэрийн салбарын нэмэгдэл өртгийн эзлэх хувь (ӨДТБҮСНӨЭХ)	Өндөр, дунд технологийн боловсруулах үйлдвэрийн салбарын нэмэгдэл өртгийн (ӨДТБҮСНӨ)	ААНБ-1 ААНБ-2 ҮСХ	(ӨДТБҮСНӨ)/ ДНБ*100	Тайлант жилийн өндөр болон дунд технологийн боловсруулах үйлдвэрийн салбарын нэмэгдэл өртгийн хэмжээг тухайн оны ДНБ-ий хэмжээнд харьцуулж 100-д үржүүлнэ.	-	+	Тооцоол лоор
			ДНБ	ҮСХ					
35	Business enterprise expenditure on R&D (BERD) as a percentage of GERD	Дотоодын судалгаа хөгжүүлэлтийн ажлын нийт зардалд хувийн хэвшлийн судалгаа, ААНБ-уудын судалгаа хөгжүүлэлтийн ажлын зардлын эзлэх хувь (ЭШБСХАЗЭХ)	Хувийн хэвшлийн судалгаа, ААНБ-уудын судалгаа хөгжүүлэлтийн ажлын зардал (ЭШБСХАЗ)	ШУТ-2 маягт, Хаягийн хэсгийн 3.21-р ангиллаар ШУТ-2.11 маягтын, Мөр32-ын нийлбэр.	(ШУТ-2 маягт, Мөр 32)/ СХАДНЗ*100	Тайлант жилийн судалгаа хөгжүүлэлтэд зарцуулсан дээд боловсролын байгууллагын зардлын хэмжээг судалгаа хөгжүүлэлтэд зарцуулсан дотоодын нийт зардлын хэмжээнд харьцуулж, 100-гаар үржүүлнэ. Хэрэв ШУТ маягтыг хувийн хэвшлийн ААНБ-аас авч чадахгүй бол ААНБ-1 болон ААНБ-2 маягтаас ҮСХ-оос авч ашиглана.	-	+	Тооцоол лоор
			СХА-д зарцуулсан ДНЗХ	ШУТ-2 ААНБ-1 ААНБ-2					
36	Full time researchers per ten thousand inhabitants	10 мянган оршин суугчдад ногдох бүтэн цагаар ажилладаг судлаачдын тоо (АМОСНБЦАСТ)	Бүтэн цагаар ажилладаг судлаач (БЦАС)	ШУТ-1 маягт нийт ажиллагчид болон БЦАХТШУ-ын	БЦАС/10000	Тайлант жилийн бүтэн цагаар ажилласан судлаачдын тоог 10 мянган оршин суугчдын тоонд харьцуулна.	-	+	Тооцоол лоор

				зөрүүгээр гарна.					
37	Total full time researchers per thousand employment	1000 ажил эрхэлдэг хүнд ногдох “бүтэн цагаар ажилладаг нийт судлаачийн тоо” (МАЭХТНБЦАНСТ)	Бүтэн цагаар ажилладаг нийт судлаачийн тоо (БЦАНСТ) Ажил эрхэлдэг хүний тоо (АЭХТ)	ШУТ-1 маягт нийт ажиллагчид болон БЦАХТШУ-ын зөрүүгээр гарна. Ажиллах хүчний судалгаа	(БЦАНСТ)/ АЭХТ*1000	Тайланд жилийн бүтэн цагаар ажилладаг нийт судлаачийн тоог ажил эрхлэгчдийн тоонд хувааж 1000-аар үржүүлнэ.	-	+	Тооцооллоор
38	Government budget allocations for R&D (GBARD)	СХА-д хуваарилсан Засгийн газрын төсвийн хуваарилалт (GBARD)	СХА-д Засгийн газраас зарцуулсан санхүүжилтийн хэмжээ	ШУТ-5, ШУТ-6 маягт	Засгийн газрын зарцуулсан санхүүжилтийн нийлбэр дүнгээр гаргана.	СХА-д Засгийн газраас зарцуулсан санхүүжилтийн хэмжээ	-	+	ШУТ маягтаар
39	Government expenditure on R&D (GOVERD)	Засгийн газрын СХА-ын зардал (GOVERD)	СХА-д Засгийн газрын харьяа байгууллагуудын зарцуулсан зардлын хэмжээ	ШУТ-3, II болон III-хүснэгт	Засгийн газрын зарцуулсан санхүүжилтийн нийлбэр дүнгээр гаргана.	СХА-д Засгийн газрын харьяа байгууллагуудын зарцуулсан зардлын хэмжээ	-	+	ШУТ маягтаар

ТАВ. ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН САЛБАРЫН СТАТИСТИК МЭДЭЭЛЛИЙГ ТАРХААХ НЬ

Шинжлэх ухааны статистик нь Боловсрол, шинжлэх ухаан, соёл, урлагийн салбарын статистикийн эмхэтгэлийн 4-р бүлэгт нийт 24 хүснэгт бүхий үзүүлэлтээр тархаагдаж байна. Харин Монгол Улсын статистикийн эмхэтгэлд тус салбарын статистик гурван хүснэгтээр тархаагдаж байна.

Зураг 4. Боловсрол, шинжлэх ухаан, соёл, урлагийн статистикийн мэдээллийн урсгал



Дээрх зурагт Боловсрол, шинжлэх ухаан, соёл, урлагийн статистикийн мэдээллийн урсгалыг харуулсан бөгөөд холбогдох боловсролын байгууллагууд тогтсон хугацаанд статистикийн мэдээллийг оршин сууж буй аймаг, нийслэлийн боловсролын газарт хүргүүлнэ. Аймаг, нийслэлийн боловсролын газар нь статистикийг нэгтгэж БШУСЯ-нд хүргүүлэх бөгөөд яам нь нэгтгэж ҮСХ-нд хүргүүлдэг.

Харин шинжлэх ухааны байгууллагууд статистик мэдээллийг шууд БШУСЯ-нд хүргүүлнэ. Энэ салбарт судалгаа шинжилгээ, туршилт, зохион бүтээх ажил эрхэлж буй байгууллага, аж ахуйн нэгжүүд хамаарах бөгөөд доорх зурагт ШУТ-ийн мэдээллийн урсгалыг дэлгэрэнгүй харуулав.

Зураг 5. ШУТ-ийн статистикийн мэдээллийн урсгал



БШУЯ-наас гаргасан 2018 оны эцсийн статистикийн мэдээллээр төрийн болон хувийн хэвшлийн эрдэм шинжилгээ, судалгааны нийт 59 байгууллага Монгол Улсад үйл ажиллагаагаа явуулж байна. Тус байгууллагууд, аж ахуйн нэгжүүд шинжлэх технологийн статистикийг 8 маягт, 246 үзүүлэлт бүхий асуулгаар бөглөж байна.

Төсвийн бус хөрөнгөөр бий болж байгаа эрдэм шинжилгээ, туршилт зохион бүтээх ажлын талаар мэдээлэл ШУТС-нд нэгтгэгдэж байгаа боловч, салбарын статистикийг бүртгэж буй байгууллагуудын (БШУЯ, ШУТС) мэдээлэл зөрүүтэй, түүнчлэн ЮНЕСКО болон олон улсын байгууллагаас гаргадаг “Шинжлэх ухааны оны эмхэтгэл”-д Монгол Улсын шинжлэх ухаан, технологийн талаар зарим мэдээлэл тусгагдаагүй зэрэг шалтгаануудаар манай улсын шинжлэх ухаан, технологийн мэдээлэл олон улсын хэмжээнд бүрэн хэмжээнд тархаагдаж чадахгүй байна.

ШУТ-ийн салбарын статистикийн мэдээллийг албан ёсоор дараах хэвлэмэл болон дижитал хэлбэрээр олон нийтэд хүргэх нь зүйтэй. Үүнд:

1. Монгол Улсын ... оны статистикийн эмхэтгэл. ҮСХ
2. ҮСХ-ны Статистикийн мэдээллийн нэгдсэн сан. ҮСХ www.1212.mn
3. ШУТ-ийн салбарын тайлан, БШУЯ
4. ШУТ-ийн салбарын статистикийн эмхэтгэл, БШУЯ

Шинэчлэн боловсруулсан 5 маягт 1724 үзүүлэлт бүхий мэдээллийн хүрээнээс дараах үзүүлэлтүүдээр албан ёсны статистикийн эмхэтгэл буюу ҮСХ-ны статистикийн эмхэтгэлүүдэд тархаахыг санал болгож байна. Үүнд:

5. Эрдэм шинжилгээний байгууллага, өмчийн хэлбэрээр
6. Шинжлэх ухааны салбарын үндсэн үзүүлэлтүүд
7. Шинжлэх ухааны салбарын үндсэн ажиллагчид, боловсролын зэргээр
8. Шинжлэх ухааны салбарын үндсэн ажиллагчид, шинжлэх ухааны салбараар
9. СХА-ын үр дүн, төрлөөр

10. Шинжлэх ухааны салбарын санхүүжилтийн эх үүсвэр, өмчийн хэлбэрээр,
11. Улсын төсвөөс санхүүжүүлсэн төсөв шинжлэх ухаан, технологийн зардал, СХА-ын төрлөөр
12. Улсын төсвөөс санхүүжүүлсэн төсөв шинжлэх ухаан, технологийн зардал, шинжлэх ухааны салбараар

БШУ-ны жилийн эцсийн тайлан мэдээг бусад улсын нийтлэг жишгийн дагуу жилийн эцсийн эмхэтгэл, тайлан хэлбэрээр олон нийтэд хүргэх нь илүү үр дүнтэй. Шинээр мөрдсөн 5 маягт 1564 үзүүлэлтийг ашиглан гарах ШУТ-ийн салбарын жилийн эцсийн тайлан, эмхэтгэлд оруулж болох үр дүнгийн хүснэгтийн төслийг боловсруулан хавсралтад оруулж өгсөн.

Боловсрол, шинжлэх ухаан, соёл урлагийн салбарын статистикийн мэдээллийн эмхэтгэлд тархагддаг хүснэгт, статистикуудыг өөрчлөх саналыг хавсралтад орууллаа.

ЗУРГАА. СУДАЛГАА ХӨГЖҮҮЛЭЛТИЙН АЖЛЫН ФРАСКАТИЙН ГАРЫН АВЛАГЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗӨВЛӨМЖ

6.1 ФРАСКАТИЙН ГАРЫН АВЛАГЫН ТУХАЙ

Эдийн Засгийн Хамтын Ажиллагааны Хөгжлийн Байгууллагаас (ЭЗХАХБ) Судалгаа, туршилт хөгжлийн ажлын (СХА) статистикийн үндэсний мэргэжилтнүүдтэй 1963 оны 6 дугаар сард Италийн Фраскати хотын Vill Falcioneri-д уулзалт зохион байгуулжээ. Уг уулзалтын үр дүнд Фраскати гарын авлага (уулзалт анх зохион байгуулагдсан хотын нэрээр нэрлэсэн) гэж нэрлэн санал болгож буй “Судалгаа, туршилт хөгжлийн асуулгад баримтлах жишиг стандарт”-ын албан ёсны анхны хувилбарыг баталсан байна. СХА-ын статистик мэдээ бол Фраскати гарын авлагыг удирдамж болгон системтэй хөгжүүлсэн ЭЗХАХБ-ын гишүүн улс орнуудын туршлага, ажлын үр дүн юм. Фраскати гарын авлага нь зөвхөн ЭЗХАХБ-ын гишүүн улс орнуудад мөрддөг СХА-ын асуулга стандарт биш юм. ЭЗХАХБ, ЮНЕСКО, Европын холбоо, олон улс, бүс нутгийн байгууллагын нэр бүхий санаачилгуудын үр дүнд дэлхий дахины СХА-ын асуулгын стандарт болжээ.

Энэхүү гарын авлагыг үндэсний СХА-ын өгөгдөл, статистик мэдээг цуглуулан эмхэтгэж, ЭЗХАХБ-д тайлагнадаг гишүүн улс орнуудын мэргэжилтнүүдэд зориулагдсан энэхүү гарын авлага нь лавлагааны үндсэн үүрэгтэй техникийн бичиг баримт юм. Аливаа байгууллагын удирдлагууд эдийн засгийн өсөлт, бүтээмжийн талаар шийдвэр гаргахдаа СХА статистикийг технологийн өөрчлөлтийн нэгэн төрлийн илтгэлцүүр гэж үздэг. Шинжлэх ухааны бодлого, аж үйлдвэрийн бодлого, тэр бүү хэл ерөнхий эдийн засаг, нийгмийн бодлогын зөвлөхүүд энэ судалгааг маш идэвхтэй ашиглаж байна. Засгийн газрын боловсруулах хөтөлбөрийн салшгүй үндэслэл, хөтөлбөрийг үнэлэх чухал хэрэгслийн нэг бол СХА-ын статистик юм. Олон улсад СХА-ын статистикийг эдийн засгийн ерөнхий статистикийн бүрдэл хэсэг гэж үздэг

Фраскати гарын авлагыг судалгаа, туршилт хөгжлийн ажлыг хэмжихэд зориулсан. Судалгаа, туршилт хөгжил гэдэг нь хүн, соёл, нийгмийн мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор хийгдэж байгаа системтэй, бүтээлч үйл ажиллагаа, түүний үр дүнд бий болсон шинэ мэдлэгийг хэрэглээнд нэвтрүүлж ашиглахад чиглэсэн цогц ажил юм.

СХА-ын нэр томъёонд дараах 3 үйл ажиллагааг хамруулна.

- **суурь судалгаа** - Аливаа үзэгдэл, ажиглаж болохуйц баримт, нотолгоонд түшиглэн, шинэ мэдлэгийг бий болгоход чиглэсэн, тодорхой хэрэглээнд ашиглах зорилгогүй, туршилтын буюу онолын ажил юм. Суурь судалгаа нь шинж чанар, бүтэц, өөр хоорондын харилцан хамааралд дүн шинжилгээ хийх замаар таамаглал, онол, зүй тогтлыг шинээр томъёолох, туршихад чиглэнэ. Суурь судалгааны ажлын үр дүн нь ихэвчлэн мэргэжлийн хүрээнд хэлэлцүүлэх зорилгоор шинжлэх ухааны сэтгүүлд хэвлэгддэг. Суурь судалгааны ажил хийхэд эрдэмтэд өөрсдөө зорилгоо тодорхойлон гаргаж тавих харьцангуй чөлөөтэй ажиллах боломжтой байдаг.
- **хэрэглээний судалгаа** - Эхнээсээ тодорхой зорилгод чиглэсэн, шинэ мэдлэг бий болгох зорилготой судалгааны ажил байх бөгөөд суурь судалгааны ололт, үр дүнг тодорхой хэрэглээнд ашиглаж болох эсэхийг тодорхойлох, тодорхой

зорилгод хүрэх арга замыг тогтооход чиглэгддэг. Хэрэглээний судалгааны үр дүн нь нэг буюу цөөн бүтээгдэхүүн, үйл ажиллагаа, арга зүй, тогтолцоонд зориулагдсан байдаг. Хэрэглээний судалгааны үр дүн нь ихэвчлэн патент, эсвэл бизнесийн байгууллагын нууц хэлбэрээр гардаг.

- **туршилт, хөгжил** - Шинэ бараа, материал, бүтээгдэхүүн үйлдвэрлэх, мөн шинэ үйл явц, тогтолцоо, үйлчилгээг нэвтрүүлэх, эдгээрийг сайжруулахад чиглэсэн системтэй судалгаа, туршилтын ажлыг хэлнэ.

6.2 ФРАСКАТИЙН ГАРЫН АВЛАГЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭД АНХААРАХ АСУУДАЛ

ШУТ-ийн статистикийн үзүүлэлтийг олон улсын жишигт нийцүүлэх хүрээнд одоогоор мөрдөгдөж буй статистикийн маягтууд шинэчлэгдэж байна. Маягтыг боловсруулахад Фраскатийн гарын авлагыг голчлон баримталсан бөгөөд дотоод болон олон улсад тархаахад ач холбогдолтой байх мэдээллийг оруулахад анхаарсан болно. Түүнчлэн ШУТ-ийн статистикийн мэдээлэлд хамрагддаг анхан шатны нэгжүүдэд маягтыг бөглөхөд гардаг хүндрэлийг шийдвэрлэх нь чухал. Үүний тулд шинээр боловсруулсан маягт зааврын анхан шатанд бөглөхөд Фраскатийн гарын авлагыг ашиглах нь зүйтэй. Анхан шатны ажилтнууд Фраскатийн гарын авлагыг бүрэн уншихад төвөгтэй байдлыг харгалзан манай улсад хэрэгжүүлэхэд шаардлагатай хэсгийг түүвэрлэн холбогдох жишээний хамт оруулж өгсөн энэхүү зөвлөмжийг боловсруулсан. Энэхүү төслийг хэрэгжүүлэх явцад анхан шатанд ШУТ-ийн мэдээллийг байгууллага бүрд харилцан адилгүй албан тушаалтан хариуцаж байсан. Тэдгээр ажилтнуудын хувьд нэгдсэн ойлголт, зөвлөмж байхгүй, зарим үзүүлэлтүүдийг хэрхэн ойлгож бөглөх нь тодорхойгүй болон санхүүгийн тайлангийн үзүүлэлтээс зарим үзүүлэлт зөрдгөөс таамаглан бөглөдөг гэсэн асуудлууд гарч байсан. Энэ бүхэнд тулгуурлан Фраскатийн гарын авлагыг хэрэгжүүлэхэд дараах зүйлд анхаарах нь зүйтэй. Үүнд:

- ШУТ-ийн мэдээ тайланд хамрагдах ААНБ-уудын ШУТ-ийн статистикийн мэдээ тайлан хариуцсан ажилтнуудыг ижил түвшний албан тушаалтан байхаар чиглэл өгөх
- Мэдээ тайлан хариуцсан албан тушаалтныг ШУТ-ийн захиргааны статистикийн маягт батлагдсаны дараа албан ёсоор мөрдөж эхлэхээс өмнө нэгдсэн сургаалтанд хамруулах. Сургалтаар мэдээлэгчдэд маягтыг бөглөх нэгдсэн ойлголт өгөхөөс гадна практик жишээ ажиллуулж чадавхжуулах замаар чанар, үр дүнг сайжруулах боломжтой.
- ШУТ-ийн статистикийн мэдээллийг анхан шатны нэгжүүдээс ирүүлэхдээ орчин үеийн дэвшилтэт технологийг ашиглах нь зүйтэй. Өөрөөр хэлбэл онлайн мэдээллийн системийг бий болгож судалгаанд хамрагдах ААНБ-ын ажилтнууд тогтсон хугацаанд судалгааг бөглөн баталгаажуулж ирүүлэх боломжтой байдлаар зохион байгуулах шаардлагатай. Онлайн мэдээллийн системд тухайн асуулгыг бөглөх жишээ, тайлбар, аргачлалыг оруулж өгснөөр илүү үр дүнтэй байх боломжтой.

6.3 СУДАЛГАА ХӨГЖЛИЙН АЖЛЫН ФРАСКАТИЙН ГАРЫН АВЛАГЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗӨВЛӨМЖ

Уг зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлыг 3 чиглэлээр авч үзсэн. Үүнд:

1. ФРАСКАТИЙН гарын авлагад тусгагдсан ангиллууд нэвтрүүлэх;
2. Судалгаа, хөгжлийн ажлын хүний нөөцийг хэмжих;
3. Судалгаа хөгжүүлэлтийн ажлыг бүртгэх, хэмжих.

Статистикийн зорилгоор судалгаа хөгжүүлэлтийн ажил, хүний нөөц гэсэн 2 орцыг хэмжинэ. Энэхүү 2 орцыг хэмжиж зохих ангиллуудыг ашиглана.

1. ФРАСКАТИЙН гарын авлагад тусгагдсан ангиллууд нэвтрүүлэх:

1.1 Судалгаа хөгжүүлэлтийн ажил (СХА)-ыг хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, төрийн байгууллага, ашгийн бус хувийн байгууллага (PNP), дээд боловсрол, гадаадын гэсэн 5 секторт ангилна. Үндэсний 4 салбараас аж ахуйн нэгж, хувийн ашгийн бус (PNP), дээд боловсролын салбарыг дэд ангилалд хамруулна. **(1.7.1)**

1.2 Судалгаа хөгжүүлэлтийн ажилд суурь судалгаа, хэрэглээний судалгаа, туршилт, хөгжил гэсэн 3 үйл ажиллагааг хамруулна. **(2.1)**

1.3 СХА-ыг хэмжихдээ доорх үйл ажиллагааг тооцохгүй. **(2.2)**

- Боловсрол, сургалт;
- Шинжлэх ухаан, технологид холбоотой бусад үйл ажиллагаа;
- Аж үйлдвэрийн бусад үйл ажиллагаа;
- Удирдлага, бусад дэмжих үйл ажиллагаа.

1.4 СХА-ыг шийдвэрлэхдээ боловсрол буюу сургалтын үйл ажиллагааны бүтээгдэхүүн нь асуудал дэвшүүлж байгаа эсэхээр ялгана. **(2.3.2)** Дараах тохиолдлууд байдаг. Үүнд:

- Төгсөлтийн дараах сургалтын докторант оюутан, тэдний үйл ажиллагаа;
- Их сургуулийн багшаар удирдуулж буй оюутан;
- Мэргэжлийн эрүүл мэндийн үйлчилгээ;
- Академик ажилтны мэргэжил дээшлүүлэх(хувь хүний хөгжил).

1.5 СХА-ын төрөл хооронд ялгах илтгэлцүүр: Чанд дараалал, ялгааг агуулдаг тул ангиллыг бодит амьдрал дээр баримтлахад хүндрэлтэй. СХА-ын 3 төрлийг заримдаа нэг байгууллагад нэг л ажилтан гүйцэтгэдэг. Түүнчлэн, судалгааны төрөл хоорондын зааг тодорхойгүй.

Жишээ 1.

- *Хэрэв хэрэглээний судалгаа/туршилт, хөгжлийн үе шатны судалгаа хөгжлийн төсөлд цаашид дэвшил гаргахын тулд холбогдох юмс үзэгдлийн шинж чанарын тухай илүү мэдлэг олж авах зорилгоор нэмэлт туршилт буюу онолын судалгааны ажил хийх санхүүжилт хэрэгтэй болно. Зарим судалгааны төсөл 2 ангилалд зэрэг хамаарах боломжтой. Жишээлбэл, нийгмийн гарал угсаа, ястан, угсаатны бүлэг хүүхдийн боловсролын түвшинд нөлөөлөх хувьсагчдын судалгаа бол суурь, хэрэглээний судалгааны аль аль нь мөн.*

1.6 Программ хангамж хөгжүүлэлтэд судалгаа хөгжүүлэлтийн ажлыг оношлохдоо дараах зүйлсийг харгалзана.

- Хэрэв тухайн программ хангамжийг хөгжүүлэх төсөл нь шинжлэх ухаан, технологийн тодорхой биш байдалд системтэй шийдэл санал болгох зорилготой, өөрөө шинжлэх ухаан, технологийн дэвшлээс урган гарсан бол түүнийг СХА-д тооцно.
- Түүнчлэн судалгаа хөгжүүлэлтийн төслийн бүрдэл хэсэг болсон программ хангамж, эцсийн бүтээгдэхүүн программ хангамжтай холбоотой СХА-ыг мөн СХА-д тооцно.
- Тухайн программ хангамж хөгжүүлэх бүрдэл хэсэг нь тэрхүү компьютерын программ хангамжийн дэвшлийг хөтөлж байвал түүнийг СХА-д тооцно. Хэрэв одоо ашиглаж буй программ буюу системийн шинэчлэл, нэмэлт, өөрчлөлт нь мэдлэг бүтээж, шинжлэх ухаан, технологийн дэвшилд хөтөлж байгаа бол СХА-д тооцож болно. Харин программ хангамжийн шинэ хэрэглээ бий болгох зорилготой бол дэвшил гэж үзэхгүй.
- Программ хангамжийн нэгж төслийг СХА-д тооцохгүй ч, тэдний нийлбэр том хэмжээний төслийг тооцож болно. Жишээлбэл, хамаарлын технологийг 4 дүгээр үеийн хэлний процессорт нэвтрүүлснээр файлын бүтэц, хэрэглэгчийн интерфэйсийн өөрчлөлт хийх шаардлагатай болж болно. Нэгж хэсгийн өөрчлөлт тус бүрийг СХА-д тооцохгүй ч, хэрэв төслийн хүрээнд хийсэн нийт өөрчлөлт бүхэлдээ шинжлэх ухаан, технологийн тодорхой биш байдалд шийдэл санал болгосон бол СХА-д тооцно. Заримдаа программ хангамжийн төсөл амжилттай дуусаагүй байсан хэдий ч шинжлэх ухаан технологийн дэвшил гэж үзнэ. Учир нь амжилтгүй болсон шалтгаан нь компьютерын программ хангамж технологийн мэдлэгийг нэмж болно Жишээлбэл тухайн аргачлалаар асуудлыг шийдэж болохгүй юм байна гэдгийг мэднэ гэдэг нь өөрөө мэдлэг юм.
- Программ хангамж хөгжүүлэлтийн ажил СХА-ийн аль ангилалд орохыг доорх жишээнээс харж болно.

Жишээ 2.

- *Тооцоолон бодох алтернатив аргачлалыг эрэлхийлэх, квант тооцоолон бодох, квант мэдээллийн онол зэрэг бол суурь судалгааны жишээ юм.*
- *Шинэ салбар буюу шинэ аргаар мэдээлэл боловсруулах хэрэглээний программын судалгаа (шинэ программчлалын хэл, шинэ үйлдлийн систем, программ үүсгэгч (generators) зэргийг боловсруулах г.м.), газар зүйн мэдээлэл, шинжээчийн системд ашиглах мэдээлэл боловсруулах судалгаа нь хэрэглээний судалгаа болно.*
- *Хэрэглээний шинэ программ хангамж хөгжүүлэх, үйлдлийн систем, хэрэглээний программ хангамжийг мэдэгдэхүйц сайжруулах зэрэг нь туршилт, хөгжлийн ажил юм.*

Программ хангамжийн ямар үзэл санааг СХА гэж тооцох талаар дараах жишээгээр харуулав.

Жишээ 3.

- Онолын компьютерын шинжлэх ухаанд шинэ теорем, алгоритм бүтээх СХА.
- Үйлдлийн систем, программчлалын хэл, өгөгдөл удирдлага, холбооны программ хангамж, программ хангамж хөгжүүлэх хэрэгслийн түвшний мэдээллийн технологи.
- Интернэт технологийн хөгжил.
- Программ хангамж бүтээх, загварчлах, ашиглалт үйлчилгээгээр хангах аргачлалын судалгаа.
- Мэдээллийг олж авах, дамжуулах, хадгалах, дуудах, ашиглах, харуулах ерөнхий арга зүйг хөгжүүлэх, дэвшил авчрах программ хангамж. Программ хангамж буюу системийг хөгжүүлэхэд дутуу технологийн мэдлэгийг олж авах туршилт, хөгжил.
- Мэргэжлийн программ хангамж техник хэрэгслийг хөгжүүлэх СХА (дүрс боловсруулах, газар зүйн өгөгдөл харуулах, тэмдэгт таних, хиймэл оюун ухаан болон бусад) ажлын зардлыг оруулна.

Программ хангамж, түүний үйлчилгээтэй холбоотой, тодорхой давтамжтай хийгддэг үйл ажиллагаануудыг СХА-д тооцохгүй. Эдгээр ажил нь шинжлэх ухаан, технологийн дэвшил авчирдаггүй мөн технологийн шийдэл санал болгодоггүй. **(2.4.1)**

1.7 Гарын авлагад нийгэм, хүмүүнлэгийн ухааны СХА-ыг “хүн, соёл, нийгмийн мэдлэг” хэмээн тодорхойлсон. Нийгэм, хүмүүнлэгийн ухааны СХА-ыг (ердийн) үйл ажиллагаанаас ялгах гол шинжүүр бол шинэлэг тал, шинжлэх ухаан, технологийн тодорхой биш байдлын шийдэл юм. Энэ нь төслийн үзэл баримтлал, арга зүй буюу эмпирик хэсэгт хамааралтай бөгөөд ердийн үйл ажиллагаа нь тодорхой давтамжтай хийгддэг. Хэрэв судалгааны төслийн бүрдэл хэсэг болж гүйцэтгэсэн, зөвхөн тодорхой судалгааны төсөлд ашиглахаар хэрэгжүүлсэн бол СХА-д тооцно. **(2.4.2)**

Нийгэм, хүмүүнлэгийн ухааны СХА-ын жишээ 4.

- Эдийн засгийн өсөлтөд нөлөөлөх бүс нутгийн хүчин зүйлийг тодорхойлогч нарыг олох онолын судалгаа бол суурь судалгаа. Харин энэхүү судалгааг засгийн газрын бодлого боловсруулах зорилгоор гүйцэтгэсэн бол хэрэглээний судалгаа. Судалгааны үр дүнд боловсруулсан бүс нутгийн хөгжлийн ялгааг өөрчлөх зорилготой зүй тогтол, үйл ажиллагаа загвар бол туршилт, хөгжлийн ажил юм.
- Суралцах чадварын хүрээлэн буй орчныг тодорхойлох шинжилгээ бол суурь судалгаа. Хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдын хүрээлэн буй орчныг сайжруулах зорилгоор боловсролын хөтөлбөрийг үнэлэх, суралцах чадварын хүрээлэн буй орчныг тодорхойлох шинжилгээ хийх бол хэрэглээний судалгаа. Тухайн хүүхдүүдийн хөгжлийн онцлогт тохируулсан боловсрол хөтөлбөрийг олох туршилт, хөгжлийн ажил юм.
- Эрсдэлийн шинэ онол бий болгох нь суурь судалгаа. Шинэ зах зээлийн эрсдэлийг хамрах шинэ төрлийн даатгалын гэрээний судалгаа хэрэглээний судалгаа юм. Шинэ төрлийн хадгаламжийн хэрэгслийн судалгаа хэрэглээний судалгаа, харин

хөрөнгө оруулалтын санг удирдах шинэ аргачлал хөгжүүлэх бол туршилт, хөгжлийн ажил юм.

- Өнөөг хүртэл тайлагдаагүй мөхсөн хэлний бүтэц, дүрмийг судлах нь суурь судалгаа. Хэлний хөгжилд газар зүй, нийгмийн нөлөөлөх хувьсагчдыг тодорхойлох ба нутгийн аялга, бусад аялгын дүн шинжилгээ нь хэрэглээний судалгаа. Хүмүүнлэгийн ухаанд туршилт, хөгжлийн ажил байхгүй.

Нийгэм, хүмүүнлэгийн ухааны судалгаа, хөгжлийн ажлын 3 төрлийн жишээг хүснэгдэт харуулав.

Суурь судалгаа	Хэрэглээний судалгаа	Туршилт, хөгжил
Эдийн засгийн нөхцөл, нийгмийн хөгжлийн шалтгаант холбооны судалгаа	Хөдөөгийн хөдөө аж ахуйн салбарт ажиллагсад хот уруу нүүж байгаа үзэгдлийг судлах. хөдөө аж ахуйг дэмжих, аж үйлдвэржсэн бүст үүсэж болох нийгмийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх хөтөлбөр боловсруулах	Хөдөө аж ахуйн салбарт ажиллагсад хот уруу нүүж байгаа үзэгдлээс санхүүгийн дэмжлэгийн аргаар урьдчилан сэргийлэх хөтөлбөрийг боловсруулж, турших.
Нийгмийн байгуулал, нийгмийн хөдөлмөрийн зах зээл /ажил мэргэжлийн шилжилт хөдөлгөөн буюу ажил мэргэжил, нийгмийн давхарга, нийгмийн анги	Нийгмийн шилжилт хөдөлгөөний өгөгдлийг ашиглан ирээдүйд үүсэж болох үр дагаврыг загварчлах	Тодорхой нийгмийн бүлэг, угсаатны шилжилт хөдөлгөөнд зориулсан хөтөлбөрийг боловсруулж, турших.
Өнгөрсөн болон одоо үед олон янзын иргэншилд гэр бүлийн үүргийг судлах	Холбогдох нийгмийн арга хэмжээний санал боловсруулах зорилгоор нэг улсын тухайн нэг бүс нутагт өнөө цагийн гэр бүлийн үүрэг, эзлэх байр суурийг судлах	Бага орлоготой ажилчдын бүлгүүдэд гэр бүлийг бэхжүүлэх хөтөлбөрийг боловсруулж, турших.
Насанд хүрэгчид ба хүүхдийн унших чадварын судалгаа. Хүний харааны систем хэрхэн яаж, үг, зураг, диаграммын мэдээллийг таньж, боловсруулдаг болохыг судлах	уншиж сургах шинэ аргачлалыг боловсруулах зорилгоор Насанд хүрэгчид болон хүүхдүүдийн унших үйл явцыг судлах	Цагаач хүүхдийн дунд унших хөтөлбөрийг боловсруулж, турших.
Үндэсний эдийн засгийн хөгжилд нөлөөлөх олон улсын хүчин зүйлсийг судлах	Гадаад худалдааны бодлогыг өөрчлөх зорилгоор тодорхой хугацаанд тухайн улсын эдийн засгийн хөгжилд нөлөөлөх олон улсын хүчин зүйлийг судлах	-
Өгүүлбэр зүй, үг зүй, авиа зүй, фенологи, орон нутгийн болон нийгмийн аялга зэрэг тухайн нэг	Тухайн хэлийг заах арга боловсруулах буюу орчуулах	-

хэлний онцлогийг бусад хэд хэдэн хэлтэй харьцуулан судлах	зорилгоор хэлийг нарийвчлан судлах	
Хэлний түүхэн хөгжлийг судлах	-	-
Түүхэн үйл явдлыг (улсын улс төр, нийгэм, соёл, түүхт хүний) нарийвчлан ойлгох зорилгоор(гар бичмэл, баримт сэлт, хөшөө дурсгал, барилга, урлагийн бүтээлийг) эх сурвалж судлах	-	-

Эх сурвалж: ЮНЕСКО (1984b), "Шинжлэх ухаан, технологийн статистикийн гарын авлага"

Байгаль, инженерчлэлийн ухааны СХА-ын Жишээ 5:

- Янз бүрийн нөхцөлд полимеризацийн урвал явуулах, урвалын бүтээгдэхүүний гарц, тэдгээрийн физик, химийн шинж чанарын судалгаа нь суурь судалгаа юм. Харин тодорхой физик, механик (хэсэгчилсэн ашиглах тодорхой зорилгоор) шинж чанартай полимер гаргаж авах зорилгоор дээр дурдсан урвалын нэгийг оновчтой сонгох арга зүйг хэрэглээний судалгаа гэнэ. Туршилт, хөгжлийн ажил нь лабораторийн түвшинд нэгэнт оновчтой болсон процессыг томруулан явуулах, тус полимерыг судлах, үнэлэх боломжит аргыг судлах, үнэлэх, үр дүнг хэвлэн нийтлэх үйл явц юм.
- Электрон холбоосны бүтцийн мэдээллийг олох зорилгоор хийгдэж буй кристаллын цахилгаан соронзон цацрагийн шингээлтийн /абсорбцийн/ судалгаа нь суурь судалгаа юм. Тодорхой шинж чанартай (мэдрэмж, хурд) цацрагийг тодорхойлох зорилгоор хувьсах олон нөхцөлд (загвар температур, цэвэршил, концентраци г.м.) тухайн материалын цахилгаан соронзон цацрагийн шингээлтийн судалгаа нь хэрэглээний судалгаа юм. Одоо ашиглаж буй цацрагийн хэмжигчээс илүү сайныг хийхэд шаардлагатай тус материалыг ашиглаж, төхөөрөмж зохион бүтээх нь туршилт, зохион бүтээх боловсруулалт юм. Эсрэг биеийн молекулын амин хүчлийн дарааллыг тодорхойлох үйл явц нь суурь судалгаа юм. Олон янзын өвчний эсрэг биетүүдийг ялгаж салгах судалгаа нь хэрэглээний судалгаа. Туршилтын ахисан түвшний эмчилгээг хүлээн зөвшөөрсөн өвчтөн дээр нийлэгжүүлсэн эсрэг биеийн үр ашгийн клиник туршилт ба эсрэг биеийн бүтцийн мэдлэгт тулгуурлан тухайн өвчинд нь тохирсон эсрэг биетийг нийлэгжүүлэх хэсгүүдээс бүрдсэн үйл явцыг туршилт, хөгжлийн ажил гэнэ.

1.8 Статистик нэгж гэж статистикийн боловсруулалтад шаардлагатай ангилал юм. **(3.1)** Статистик ажиглалтаар цугларсан мэдээний үнэн бодитой байдал нь цаашид тухайн тоо мэдээг ашиглан хийх судалгаа, шинжилгээний үр дүн, шийдвэр гаргахад шууд нөлөөлдөг. Статистик судалгаанд хамрагдаж байгаа юмс үзэгдлийн нийлбэр болох ажиглах объектын бүрэлдэхүүний үндсэн элементийн тоо, мэдээ өгөх нэгжийг ажиглалтын нэгж гэнэ. **(3.2)**

- 1.9 Статистик нэгж(үүд)-ийг эдийн засгийн үйл ажиллагааны стандарт ангилалтай аль болох нягт уялдуулж, эдийн засгийн сектороор бүлэглэн ангилна. **(3.2.1)**
- 1.10 Үндэсний тооцооны системд санхүүгийн бус корпорац; санхүүгийн корпорац; төрийн байгууллага; өрхийн аж ахуйд үйлчилдэг ашгийн бус байгууллага гэсэн секторыг тодорхойлсон. Дээд боловсролыг бие даасан сектор болгож, мөрдүүлэх; айл өрхийг ашгийн бус хувийн салбарт хамруулна. **(3.2.2)** ШУТ-ийн салбарын дагуу статистик нэгжийг ангилахдаа тухайн байгууллагын үндсэн үйл ажиллагааг харгалзах ёстой
- 1.11 СХА-ын төрлийн задаргааг үндэсний 4 салбарын гүйцэтгэлээр гаргана. **(4.2.1)**
- 1.12 СХА-ын нэгжид гүйцэтгэсэн дараах үйл ажиллагааг хүний нөөц, зардлын өгөгдлийн статистикийн мэдээнд тооцно. **(5.1)**
- Шинжлэх ухаан, техникийн ажлыг гүйцэтгэх (туршилт тавих буюу судалгааг төлөвлөж, гүйцэтгэх; бүтээгдэхүүний анхдагч загвар бүтээх г.м.);
 - Судалгаа хөгжүүлэлтийн төсөл, ялангуяа түүний ШУТ асуудлыг төлөвлөх, удирдах;
 - Судалгаа хөгжүүлэлтийн төслийн завсрын, эцсийн тайланг бичих, ялангуяа нэгдсэн СХА-ын тайланг бичих;
 - Тооцоолон бодох хэрэгсэл буюу номын сан, бичиг баримтын ажил хийх зэрэг судалгаа хөгжүүлэлтийн төслийн дотоод үйлчилгээг үзүүлэх;
 - Судалгаа хөгжүүлэлтийн төслийг санхүү, хүний нөөцийн удирдлагаар дэмжих.

2. Судалгаа, хөгжлийн ажлын хүний нөөцийг хэмжих:

- 2.1. Судалгаа хөгжүүлэлтийн үйл ажиллагааг гардан гүйцэтгэж буй хүний нөөц болон тэдгээрт СХА-ын менежер, администратор, бичиг хэргийн ажилтан шууд үйлчилгээ үзүүлдэг нийт ажилтныг хамруулна.
- Хоол, хүнс хариуцсан, аюулгүй байдлын ажилтан г.м. шууд бус үйлчилгээ үзүүлдэг ажилтныг тооцохгүй боловч тэдний цалин, хөлсийг үйл ажиллагааны зардалд тооцно.
 - Зөвлөх авч ажиллуулдаг тохиолдолд судалгаа, хөгжлийн хүний нөөцийг дутуу тооцох магадлалтай байдаг. Мөн тусдаа зөвлөх эсвэл бусдаар гүйцэтгүүлж буй ажил үйлчилгээ хэлцлийн хүрээнд зөвлөх үйлчилгээ хийж байгааг тодорхойлоход хэцүү юм. Уг асуудлыг шийдэхийн тулд ажлын талбар дээрх зөвлөхүүдийг бүтэн цагаар ажилласан хүний тоонд шилжүүлсэн утгыг (БЦАХТШУ) бодох асуулга авах хэрэгтэй. СХА-ын судалгаандаа харгалзах зардлыг нь “бусад урсгал зардал”-д бичнэ. Бусдаар гүйцэтгүүлж буй ажил үйлчилгээ, зөвлөхийн зардлыг бусад гадаад зардалд тооцно. **(5.2.1)**

Судалгаа, хөгжлийн хүний нөөцийг 1-т ажил, мэргэжил, 2-т эзэмшсэн албан ёсны боловсрол гэсэн 2 аргачлалаар ангилна. Хамгийн түгээмэл ангилал нь хоёр дахь нь юм. **(5.2.2)**

2.2. Ажил, мэргэжлийн ангиллыг 3 ангилна.

- Судлаач;
Судлаач гэдэг нь шинэ мэдлэг, бүтээгдэхүүн, процесс, аргачлал, системийн санаачлах, бүтээх мөн төслийн удирдлагыг хэрэгжүүлдэг мэргэжилтэн юм.

- Техникч, түүнтэй дүйцэх ажилтан;
Техникч, түүнтэй дүйцэх ажилтан гэж инженер, физик, амьдралын ухаан, нийгэм хүмүүнлэгийн ухааны нэг буюу хэд хэдэн салбарт техникийн мэдлэг, туршлага шаардсан ажил хийдэг мэргэжилтнийг хэлнэ.
- Бусад туслах ажилтан гэж ангилдаг.
Судалгаа хөгжлийн төслийн ажилтан буюу төсөлтэй шууд холбоотой ажилладаг мэргэжилтэй, мэргэжилгүй урчууд, нарийн бичиг, бичиг хэргийн ажилтан ба бусад туслах ажилтан хамаарна. **(5.2.3)**

2.3. Албан ёсны боловсролын зэргийг СХА-ын статистикийн зорилгоор 6 ангилна. **(5.2.4)**

- Их сургуулийг PhD докторын зэрэгтэй төгсөгчид (БОУСА-ын 6 түвшин);
- Их сургуулийг PhD доктороос доош зэрэгтэй төгсөгчид (БОУСА-ын 5А түвшин);
- Мэргэжлийн боловсролын бусад диплом, гэрчилгээний төгсөгчид (БОУСА-ын 5В түвшин) эзэмшигчид;
- Дээд боловсролын биш диплом, гэрчилгээтэй төгсөгчид (БОУСА-ын 4 түвшин) эзэмшигчид;
- Бүрэн дунд боловсролын диплом, гэрчилгээ эзэмшигчид (БОУСА-ын 3 түвшин)
- Бусад гэж 6 ангилна.

2.4. Судалгаа хөгжүүлэлтийн хүний нөөцийг 3 үе шатаар хэмжинэ. **(5.3.1)**

- Тооллогын дүнгээр;
- Тэдний судалгаа хөгжүүлэлтийн үйл ажиллагааг БЦАХТШУ /бүтэн цагаар ажилласан хүний тоонд тэгшитгэсэн/ хүн жилээр илэрхийлэх;
- Үзүүлэлтийн шинж чанарыг хэмжих.

2.5. Нийт хүний тоогоор илэрхийлэгдсэн хүний нөөцийн өгөгдөл нь СХА-ыг бүтэн цагийн буюу үндсэн ажилтан, цагийн ажилтан буюу гэрээт ажилтны тооны нийлбэр юм. **(5.3.2)**

2.6. Бүтэн цагаар ажилласан хүний тоонд шилжүүлсэн утга (БЦАХТШУ)-ыг бодит СХА-ын багтаамжийг хэмжих, гишүүн улс орнуудад олон улсын харьцуулалт хийхэд ашиглана. Нэг БЦАХТШУ гэдгийг нэг хүн-нэг жил гэж үзнэ. БЦАХТШУ нь СХА-ын хүний нөөцийн бодит хэмжээг илэрхийлнэ. Хэрэв нийт ажлын цагийнхаа 30 хувийг СХА-д, үлдсэнийг нь бусад ажилд зарцуулж буй хүнийг 0.3 БЦАХТШУ үзнэ. Үүнтэй ижил судлаач жилийн 6 сарыг судалгаа, хөгжилд зарцуулсан бол 0.6 БЦАХТШУ болно. Нийт ажлын цагт үндэслэж бүтэн-цагаар ажилласан хүний тоонд шилжүүлсэн утгыг тооцоолдог. Түүнчлэн тухайн жил нэг хүн хамгийн ихдээ нэг хүн-жил буюу БЦАХТШУ нь нэгтэй тэнцүү байна. Гэвч амьдрал дээр энэ зарчмыг үргэлж мөрдөх боломжгүй юм.

Жишээ 6:

- Зарим судлаач хэд хэдэн СХА-ын нэгжид үйл ажиллагаа явуулдаг. Мөн аж ахуйн нэгжид давхар ажилладаг судлаачийн тоо нэмэгдэж байна. Энэ тохиолдолд тухайн хүний БЦАХТШУ-ыг нэгтэй тэнцүүлнэ.

2.7 Дараах 2 нийлбэрийг үндэсний хэмжээнд тооцох шаардлагатай. **(5.3.4)**

- СХА гүйцэтгэж буй нийт хүн;

- Тухайн улсын нутагт 12 сарын хугацаанд СХА гүйцэтгэсэн нийт БЦАХТШУ.

Жишээ 7.

- *Цаг ашиглалтын судалгаанаас бүтэн цагаар ажилласан хүний (БЦАХ) тоонд тэгшитгэсэн СХА-ын хөдөлмөрийн хөлсийг бодоход ашиглах коэффициентийг тооцоолно. Бусад СХА-ын зардлыг зорилгод тулгуурлаж үнэлэх ёстой. Жишээлбэл, судалгааны багаж, тоног төхөөрөмжийн худалдан авалт, судалгааны лабораторийн зардлыг судалгааны хэсэгт, сургалтын хэрэглэгдэхүүн, материаллаг баазын ашиглалт үйлчилгээг сургалтын хэсэгт тооцох хэрэгтэй. Судалгаа, сургалтын алинд нь хамаарах нь тодорхойгүй зардлыг судалгааны коэффициентийг ашиглаж тооцож бодно*

Шинжлэх ухаан, техникийн хүний нөөцийн онцлог шинж чанарыг судлах зорилгоор судалгаа хийж буй хүний нөөцийг дараах ангиллаар тооллогод хамруулна.

- Хүйс
- Нас

Судалгаа, хөгжлийн хүний нөөцийн насны өгөгдлийг 6 зэрэглэлээр задалж авч үзэх нь зүйтэй.

- 25-аас доош насны
- 25-34 насны
- 35-44 насны
- 45-54 насны
- 55-64 насны
- 65-аас дээш насны. Цалингийн түвшин, үндэс, угсаа зэрэг бусад хувьсагчдыг мөн шалгах хэрэгтэй. Гэвч, тус өгөгдлийг цуглуулах нь хувь хүний тухай судалгаа хийх шаардлагатай болох ч, энэ нь хүн хүч, санхүүжилт зэрэг их нөөцийг шаардана. Иймээс хүн амын бүртгэл, нийгмийн даатгалын бүртгэл зэрэг бусад захиргааны эх сурвалжаас өгөгдөл олж авах шаардлагатай.

3. Судалгаа хөгжүүлэлтийн ажлыг бүртгэх, хэмжих:

3.1 Тухайн статистик нэгжийн СХА-ын зардал

- а) нэгж шууд гүйцэтгэсэн дотоод
- б) бусдаар гүйцэтгүүлсэн шууд бус гэсэн хоёр төрлөөс бүрдэнэ.

Тус зардлыг дараах үе шатаар бүрэн хэмжинэ. Үүнд:

- Статистик нэгж тус бүр шууд гүйцэтгэсэн дотоод судалгаа, хөгжлийн зардлыг тогтоох;
- Гүйцэтгэгчийн тайлангийн дагуу дотоод судалгаа, хөгжлийн зардлын санхүүжилтийн эх үүсвэрийг тогтоох;
- Тухайн статистик нэгж тус бүрийн гадаад судалгаа, хөгжлийн зардлыг тогтоох;

- СХА-ыг гүйцэтгэсэн салбар болон санхүүжилтийн эх үүсвэр тус бүрээр өгөгдлийг нэгтгэж, үндэсний нийт зардлыг бодно. **(6.1)**

3.2 Шууд буюу дотоод зардал гэдэг нь тухайн статистик нэгж өгөгдсөн хугацаанд тухайн эдийн засгийн салбарт дурын эх үүсвэрийн санхүүжилтээр гүйцэтгэсэн **Судалгаа хөгжүүлэлтийн нийт зардал** юм. Тухайн статистик нэгж буюу салбар дотоод СХА-ыг дэмжих зорилгоор бусдаар гүйцэтгүүлсэн, гадагш зарцуулсан шууд бус зарцуулалтыг тооцно (СХ-ийн хангамжийг нийлүүлэх г.м үйл ажиллагааны болон үндсэн хөрөнгийн зардлыг тооцно). **(6.2.1)**

Жишээ 8.

- *Шинэ баригдах лабораторийг авч үзвэл үүний яг СХА-ын зорилгоор хэрэглэх хэсгийн зардал нь СХА-ын зардалд багтах ба харин туршилт болон чанарын хяналтын хэсгийн зардал нь СХА-ын зардлаас хасагдана гэсэн үг юм. Хэрэв энэхүү шинэ лабораторийн нийт хэрэглээний 40%-ийг СХА-д ашиглахаар зориулагдсан бол (Жишээ нь: Үлдсэн 60%-ийг бусад үйл ажиллагаанд) тус барилгын нийт барилгын ажлын зардлын 40%-ийг холбогдох СХА-ын зардал хэмээн тооцно.*

3.3 Үйл ажиллагааны зардалд цалин хөлс болон бусад үйл ажиллагааны зардал орно. **(6.2.2)**

Судалгаа хөгжүүлэлтийн хүний нөөцийн цалин хөлс: Тухайн жилийн цалин, хөлс, болон урамшуулал, амралтын цалин, тэтгэврийн сан, нийгмийн даатгалын шимтгэл, татвар зэрэг нэмэлт зардлыг судалгаа хөгжүүлэлтийн хүний нөөцийн цалин хөлсөнд оруулна. Шууд бус үйлчилгээ үзүүлдэг ажилтны (хамгаалалт, ашиглалт үйлчилгээ, төв номын сан, компьютерын тэнхим, админ/төв удирдлагын ажилтан) тоо нь хүний нөөцийн өгөгдөлд ордоггүй боловч тэдгээрийн цалин хөлсийг тус зардлын зүйл ангид тооцохгүй, харин үйл ажиллагааны бусад зардалд оруулах нь зүйтэй

Жишээ 9.

- *Хүмүүнлэгийн ухааны их сургууль нь телефон болон цахилгаан эрчим хүчний төлбөрт жилд 9 саяыг төлдөг.*
- *Нийт телефон, цахилгаан эрчим хүчний төлбөрийн зардал нь 9 сая байна. Ийм зардлыг ихэвчлэн "бусад урсгал зардал" гэж үздэг. Холбогдох СХА-ын зардлыг тооцохдоо, бусад урсгал зардалд СХА-ын эзлэх хувийг харгалзан үзэх нь зүйтэй. СХА-ын эзлэх хувийг ихэвчлэн төлөвлөсөн хэрэглээгээрээ тооцдог. Учир нь их сургуулийн телефон болон эрчим хүчний зардал нь бүх үйл ажиллагааны зардал болдог тул хэрэглэгдсэн хэмжээгээр тооцоолох боломжгүй. Дээрх жишээнд Хүмүүнлэгийн ухааны их сургууль нь нийт үйл ажиллагааны 11 хувь СХА байдаг гэж үзвэл $9.0 \text{ сая} * 0.11$ буюу 0.99 сая төгрөг нь СХА-ын зардал болж маягтад бөглөгдөнө.*

Нэмүү өртгийн албан татвар (НӨАТ)

Судалгаа хөгжүүлэлтийн зардлын өгөгдөл нь гүйцэтгэгч болон санхүүжүүлэгч хоёрын хувьд нөлөөтэй хүчин зүйлийн зардал байна. Засгийн газраас судалгаа хөгжүүлэлтийн

санхүүжилтэд олгосон зардлаас НӨАТ болон түүнтэй адилтгах борлуулалтын татварыг тооцохгүй.

3.4 Тухайн статистик нэгж СХА-ын хөтөлбөрт ашиглаж буй тогтмол ашиглагдах хөрөнгийн нэг жилийн нийт зардлыг **үндсэн хөрөнгийн зардал** гэнэ. (6.2.3) Тухайн хугацааны турш гарсан зардлыг бүрэн тайлагнах ба элэгдэл хорогдол гэж бүртгэж болохгүй. Нийт барилга үйлдвэр багаж тоног төхөөрөмжийн элэгдэл хорогдлыг дотоодын СХА-ын зардалд тооцохгүй. Энэ аргачлал нь дараах хоёр үндэслэлтэй.

- Хэрэв элэгдэл хорогдлыг (байгаа хөрөнгийг шинэчлэх санхүүжилт) үйл ажиллагааны зардалд оруулан тооцвол үндсэн хөрөнгийн зардал нэмэгдэж давхар тоологдоно.
- Төрийн байгууллагын хувьд үндсэн хөрөнгийн элэгдэл хорогдлыг тооцох заалт байхгүй.

Үндсэн хөрөнгийн зардлын доорх төрөл байна:

- Газар, барилга байгууламж;
- Багаж, тоног төхөөрөмж, хэрэгсэл;
- Компьютерын программ хангамж.

Газар, барилга байгууламж

Тус зардлын төрөлд СХА-д (сорилт, туршилтын талбай, лаборатори, туршилтын үйлдвэр г.м.) ашиглах газар, барьж, байгуулж буй буюу худалдан авсан барилга, байгууламж, өргөтгөлийн өөрчлөлт, засварыг тооцно.

Шинэ барилга байгууламжийн зардалд СХА эзлэх хувийг тоогоор илэрхийлэх нь хүндрэлтэй байдаг. Ихэнх улс орон СХА-ын зардлын (Дээд боловсролын сектор) тус элементийг тооцдоггүй буюу ашиглалтын хуваарьт (Үндсэн хөрөнгийн ашиглалтын Судалгаа хөгжүүлэлтийн ажилд оногдох хувь, агуулгыг тогтоох хэсэг) үндэслэн оновчтой үнэлдэг

Жишээ 10.


Үндсэн болон лабораторийн барилга. СХА эрхлэх боломж бүхий оффисын зориулалттай байр болон туршилт, үйлдвэрлэл хийх боломж бүхий лабораторийн барилгыг ойлгоно.

Жишээ нь: Шинэ баригдах лабораторийг авч үзвэл үүний яг СХА-ын зорилгоор хэрэглэх хэсгийн зардал нь СХА-ын зардалд багтах ба харин туршилт болон чанарын хяналтын хэсгийн зардал нь СХА-ын зардлаас хасагдана гэсэн үг юм. Хэрэв энэхүү шинэ лабораторийн нийт хэрэглээний 40%-ийг СХА-д ашиглахаар зориулагдсан бол (Жишээ нь: Үлдсэн 60%-ийг бусад үйл ажиллагаанд) тус барилгын нийт барилгын ажлын зардлын 40%-ийг холбогдох СХА-ын зардал хэмээн тооцно.

Бусад байгууламж. Орон сууцны бус зориулалттай үйлдвэр, үйлчилгээний барилга, байгууламж, далан, зам, гүүр, шугам, сүлжээ болон газар, хөрс сайжруулалтаас бүрдэнэ.

Тээврийн хэрэгсэл. СХА-д ашиглагдаж буй бүх төрлийн машин, тээврийн хэрэгслийг ойлгоно.

Багаж, тоног төхөөрөмж, хэрэгслийн зардал. Судалгаа хөгжүүлэлтийн ажлыг гүйцэтгэхэд шаардлагатай үндсэн багаж, тоног төхөөрөмж болон цэрэг дайны зориулалтаар худалдан авсан зэр зэвсгийн системээс бусад тоног төхөөрөмжийг энд оруулна. Харьцангуй бага үнэтэй болон тогтмол худалдан авдаг гар багаж зэргийг оруулахгүй.

Жишээ: ШУТИС-ын БУФ шинэ тоног төхөөрөмжийг 20 саяар худалдан авч ашиглав. Багш нарын үзэж байгаагаар, энэ тоног төхөөрөмж нь судалгаа болон сургалтын үйл ажиллагаанд адилхан ашиглагдах болно гэж тооцоолж байна.

*Шинэ тоног төхөөрөмж худалдан авахад нийт хөрөнгө оруулалтын зардал нь 20 сая төгрөг болж байна. Холбогдох СХА-ын зардлыг тооцохдоо нийт хөрөнгө оруулалтын зардлын СХА-ын эзлэх хувийг харгалзан үзнэ. БУФ-ийн багш нарын үзэж байгаагаар, энэ тоног төхөөрөмж нь судалгаа болон сургалтын үйл ажиллагаанд адилхан ашиглагдах (50.0 хувь) тул хөрөнгө оруулалтын зардлын СХА-д эзлэх хувь нь 10 сая байна гэж тооцно. (20 * 0.5).*

*ШУТИС нь хүнсний технологийн сургуульд албан хэрэгцээнд 100.0 сая төгрөгөөр автомашин худалдан авсан байна. Тухайн автомашин ашиглалтын 30 хувийг СХА-д зориулахаар төлөвлөсөн байна. Энэ тохиолдолд автомашин худалдан авсан үнийн дүнгийн 30 хувьтай тэнцэх хэмжээний хөрөнгийн зардлыг СХА-ын зардал гэж бүртгэнэ. (100.0 сая*0.3)*

Тавилга, эд хогшил. СХА-д өдөр тутам болон давтамжтайгаар ашиглагдаж буй тавилга, эд хогшлыг ойлгоно.

Оюуны өмчийн бүтээгдэхүүн. Биет шинж чанаргүй, хүний оюуны хүчин чармайлтаар бий болдог, нэг буюу түүнээс дээш жил ашиглагддаг, өөрийн эзэмшигчдэдээ давуу болон онцгой эрх, өрсөлдөөний давуу талыг олгосон хөрөнгийг ойлгоно. Үүнд шинжилгээ судалгаа, хөгжлийн ажил, геологи хайгуулын ажил болон үнэлгээ, компьютерын программ хангамж, мэдээллийн сан, утга зохиол, урлагийн эх бүтээл, лиценз, патент зэрэг орно. Оюуны өмчийн бүтээгдэхүүнийг компьютерын программ хангамж, мэдээллийн сан, бусад оюуны өмчийн хөрөнгөөр бүртгэнэ.

Компьютерын программ хангамжийн зардал. СХА-ыг гүйцэтгэхэд шаардлагатай тусгай компьютерын программ хангамжийн зардлыг ойлгоно.

Жишээ: Техник технологийн дээд сургууль нь мэдээлэл зүйн анги танхимаа тохижуулахын тулд шинэ программ хангамж худалдан авахад 300.0 сая төгрөг зарцуулжээ. Энэ тохиолдолд эдгээр программ хангамжууд нь сургалтын зорилгоор ашиглагдах тул үүнийг СХА-ын зардал гэж тооцохгүй.

Мэдээллийн сан. Нэгдсэн ангилал, код, индекс, арга зүй, стандарт, баримт бичгийн шаардлага хангасан цуглуулж, боловсруулж, хадгалсан цаасан болон цахим мэдээллийн бүрдлийг ойлгоно.

Бусад оюуны өмчийн хөрөнгө. Дээрх оюуны өмчийн бүтээгдэхүүний тодорхойлолтод дурдсан, программ хангамж болон мэдээллийн сангаас бусад судалгаа, хөгжлийн ажил, геологи хайгуулын ажил болон үнэлгээ, утга зохиол, урлагийн эх бүтээл, лиценз, патент зэргийг оруулна.

Өсөж үрждэг хөрөнгө. СХА-ын зорилгоор байгууллагын шууд хяналт, удирдлагын дор үр төл болон үр жимсээ байнга давтан өгдөг мал амьтан, мод, ургамлыг хамруулна.

Мал, амьтад. СХА-ын зорилгоор өсгөж, үржүүлж буй мал амьтныг оруулна.

Олон наст ургамал. СХА-ын туршилтын зорилгоор өсгөж, үржүүлж буй олон наст ургамлыг ойлгоно.

Үнэт зүйлс. Үнэт зүйлсийг үнэт металл, чулуу болон бусад гэсэн ангиллаар бүртгэнэ. Үнэт зүйлсийн хуримтлалд үйлдвэрлэл, хэрэглээнд ашиглагддаггүй, цаг хугацааны явцад хэрэглээний чанар эсвэл бодит үнэ цэнээ алддаггүй, үнэ нь улам нэмэгддэг зүйлс орно.

Үнэт металл, чулуу. СХА-д туршилт, судалгааны чиглэлээр ашиглагдаж буй бүх төрлийн үнэт металл, чулууг ойлгоно.

Бусад үнэт зүйл. Бусад үнэт зүйлд эртний эдлэл, түүх соёл, гар урлалын бүтээл зэргийг ойлгоно.

Бусад үндсэн хөрөнгийн зардал. Дээрх ангилалд ороогүй бусад үндсэн хөрөнгийг хамруулна.

III. ШУТА-ын тоо, зардал

ШУТА-ын тоо. Тайлант онд гүйцэтгэсэн ШУТА-ын тоог шинжлэх ухааны салбар болон ШУТА-ын ажлын төрлөөр бүртгэнэ. ШУТА-д СХА-д орохгүй бусад ШУТ-ийн үйлчилгээ болон мэргэжлийн боловсрол, сургалтууд орно.

ШУТА-ын зардал. Баганаар ШУТА-ын зардлыг үйл ажиллагааны зардал болон үндсэн хөрөнгийн зардлаар бүртгэнэ.

Шинжлэх ухааны салбараар бүртгэсэн ШУТА-ын зардал буюу ШУТ-2 маягтын III-хүснэгтийн мөр 7 нь мөр 29-тэй тохирч байна. Мөн мөр 8, 12, 16-ын нийлбэр нь ШУТ-2 маягтын II-хүснэгтийн мөр 32-той тэнцүү байна.

Шинжлэх ухааны салбараар:

Байгалийн ухаан. Математикийн шинжлэх ухаан, Компьютер, мэдээллийн шинжлэх ухаан, Физикийн шинжлэх ухаан, Химийн шинжлэх ухаан, Газар, хүрээлэн буй орчны шинжлэх ухаан, Биологийн шинжлэх ухаан болон бусад дэд байгалийн шинжлэх ухааны салбаруудад гүйцэтгэгдсэн СХА-ын тоо болон зардлыг бүртгэнэ.

Инженер технологи. Иргэний инженерчлэл, Цахилгааны инженерчлэл, Электроникийн инженерчлэл, Мэдээллийн инженерчлэл, Механик инженерчлэл, Химийн инженерчлэл, Материал (түүхий эд) судлал, Анагаах ухааны инженерчлэл, Хүрээлэн буй орчны инженерчлэл, Хүрээлэн буй орчны биотехнологи, Үйлдвэрлэлийн биотехнологи, нано-технологи, бусад инженерчлэл болон технологийн дэд салбаруудад гүйцэтгэгдсэн СХА-ын тоо болон зардлыг бүртгэнэ.

Анагаах ухаан. Анагаах ухааны суурь судалгаа, эмнэл зүйн анагаах ухаан, эрүүл мэндийн шинжлэх ухаан, эрүүл мэндийн биотехнологи болон бусад анагаах ухааны дэд салбаруудад гүйцэтгэгдсэн СХА-ын тоо болон зардлыг бүртгэнэ.

Хөдөө аж ахуй. Газар тариалан, Ой, загас, агнуур, Амьтан, сүү судлал, Мал эмнэлэг судлал, ХАА биотехнологи болон бусад ХАА-н шинжлэх ухааны дэд салбаруудад гүйцэтгэгдсэн СХА-ын тоо болон зардлыг бүртгэнэ.

Нийгмийн шинжлэх ухааны салбар. Сэтгэл судлал, эдийн засаг, бизнес, Боловсрол судлал, Социологи, Хууль, Улс төр судлал, Нийгэм, эдийн засгийн газар зүй, Хэвлэл мэдээлэл, харилцаа холбоо, бусад нийгмийн шинжлэх ухааны салбаруудад гүйцэтгэгдсэн СХА-ын тоо болон зардлыг бүртгэнэ.

Хүмүүнлэгийн шинжлэх ухааны салбар. Түүх, археологи, Хэл, уран зохиол, Философи, ёс зүй, шашин, Урлаг болон бусад хүмүүнлэгийн шинжлэх ухааны дэд салбаруудад гүйцэтгэгдсэн СХА-ын тоо болон зардлыг бүртгэнэ.

СХА-ын төрөл:

Судалгаа хөгжүүлэлтийн ажил. СХА-д дараах ажлуудыг хамаарна.

- СХА-д шууд оролцоотой ажилтнуудад үзүүлж буй мэргэжлийн, техникийн, зохион байгуулалтын болон захиргааны дэмжлэг туслалцаа.
- СХА-д (их дээд сургуулийн эрдэм шинжилгээний сургалтын хүрээнд) оролцож байгаа оюутнуудад мэргэжил, техник болон захиргааны дэмжлэг туслалцаа үзүүлж байгаа болон СХА-д шууд оролцоотой ажилтнуудын хүний нөөцийн удирдлага.

- Шинжлэх ухааны тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэх зорилготой программ хангамж хөгжүүлэх төсөл.
- Байгалийн ухаан, инженер, технологи, анагаах ухаан, хөдөө аж ахуй, нийгэм, хүмүүнлэгийн ухааны эрдэм шинжилгээний ажлууд.
- Ямар нэгэн албан ёсны бус хамтарсан үйл ажиллагаанд оролцогч байгууллагын гүйцэтгэж буй СХА.
- Бусад хуулийн этгээд болон аж ахуйн нэгжүүдэд гэрээгээр хийж гүйцэтгэсэн СХА төслүүд.
- Үндсэн СХА-ын дараа гарсан асуудлуудыг шийдвэрлэхэд чиглэсэн “эргэх холбоо бүхий СХА” жишээ нь үйлдвэрлэл эхлүүлэх үед гарсан техникийн асуудлууд.

СХА-д хамаарахгүй үйл ажиллагаа:

- Сургалтад бэлтгэх.
- Дээд боловсролын байгууллагын багшийн хөгжил.
- Шинжлэх ухаан, технологийн мэдээллийн үйлчилгээ.
- Инженер, техникийн үйлчилгээ.
- Ерөнхий буюу тогтсон мэдээлэл цуглуулах ажил.
- Стандартчилах болон ээлжит туршилтууд.
- Техник эдийн засгийн судалгаа (Судалгаа хөгжлийн төслийнх биш бол).
- Эрүүл мэндийн мэргэжлийн үзлэг, жишээ нь эмгэг судлалын үзлэг.
- Оюуны өмч, зохиогчийн эрх, лицензийн эрх, олгох арилжаа, эрх зүй болон захиргааны үйл ажиллагаа.
- Технологийн шинэ шийдэлтэй холбоогүй энгийн компьютерын программчлал, системийн болон программ хангамж ашиглалт, үйлчилгээ.

Жишээ:

- Талстын цахилгаан дамжуулах чанарыг судлах нь суурь судалгаа юм. Харин хайлшны шинж чанарт кристаллографийг хэрэглэх нь хэрэглээний судалгаа болно.
- Шинэ чипийн загвар гаргах нь туршилт хөгжүүлэлтийн ажил шаардана.
- Чип элементийг байрлуулахад хязгаарлах хүчин зүйлийг судлах нь суурь болон хэрэглээний судалгааны зааг дээр орших ба нано технологийг оролцуулна.
- Төслийн гүйцэтгэл нь шинжлэх ухааны технологийн дэвшлээс ихээхэн хамаардаг тул СХА-ын үйлчилгээ нь программ хангамжийн хөгжлөөс хамаарна. Мөн төслийн зорилго нь шинжлэх ухааны болон технологийн тодорхой бус байдлыг системтэй шийдвэрлэхэд оршино.

Суурь судалгаа. Аливаа үзэгдэл, ажиглаж болохуйц баримт, нотолгоонд түшиглэн, шинэ мэдлэгийг бий болгоход чиглэсэн, тодорхой хэрэглээнд ашиглах зорилгогүй, туршилтын буюу онолын ажил юм.

- Суурь судалгаа нь шинж чанар, бүтэц, өөр хоорондын харилцан хамааралд дүн шинжилгээ хийх замаар таамаглал, онол, зүй тогтлыг шинээр томъёолох, туршихад чиглэнэ.
- Суурь судалгааны үр дүн нь мэргэжлийн хүрээнд хэлэлцүүлэх зорилгоор ихэвчлэн шинжлэх ухааны сэтгүүлд хэвлэгддэг.
- ЗГ-ын 2014 оны 301-р тогтоолын тогтоолоор батлагдсан ШУТ-ийн технологийн төслийн ангилал дахь хөтөлбөрийн зорилтот төсөл, захиалгат төсөл, гадаадтай хамтарсан төслүүд нь суурь судалгаанд чиглэгдсэн байж болно.

Хэрэглээний судалгаа. Эхнээсээ тодорхой зорилгод чиглэсэн, шинэ мэдлэг бий болгох зорилготой судалгааны ажил бөгөөд суурь судалгааны ололт, үр дүнг тодорхой хэрэглээнд ашиглаж болох эсэхийг тодорхойлох, тодорхой зорилгод хүрэх арга замыг тогтооход чиглэгдэнэ.

- Хэрэглээний судалгааны үр дүн нь нэг буюу хэд хэдэн бүтээгдэхүүн, үйл ажиллагаа, арга зүй, тогтолцоонд зориулагдсан байдаг.
- Хэрэглээний судалгаа нь шинэ санааг бодит ажиллагааны хэлбэрт хөгжүүлнэ.
- Хэрэглээний судалгааны үр дүн нь ихэвчлэн патент, эсвэл бизнесийн байгууллагын нууц хэлбэрээр гардаг. Хэрэглээний судалгаанаас олсон мэдлэг эсвэл мэдээллийг шинжлэх ухааны сэтгүүлд хэвлэнэ.
- ЗГ-ын 2014 оны 301-р тогтоолын тогтоолоор батлагдсан ШУТ-ийн технологийн төслийн ангилал дахь хөтөлбөрийн зорилтот төсөл, захиалгат төсөл, гадаадтай хамтарсан төслүүд нь хэрэглээний судалгаанд чиглэгдсэн байж болно.

Туршилт-боловсруулалт, зохион бүтээх. Шинэ бараа, материал, бүтээгдэхүүн үйлдвэрлэх, мөн шинэ үйл явц, тогтолцоо, үйлчилгээг нэвтрүүлэх, эдгээрийг сайжруулахад чиглэсэн системтэй судалгаа, туршилтын ажлыг ойлгоно.

ЗГ-ын 2014 оны 301-р тогтоолын тогтоолоор батлагдсан ШУТ-ийн технологийн төслийн ангилал дахь цөм технологийн төсөл, технологи, туршилт зүгшрүүлэлтийн төслүүд нь туршилт-боловсруулалт, зохион бүтээх ажилд чиглэгдсэн байж болно.

Хөтөлбөрийн зорилтот төсөл. Нийгмийн болон салбарын хөгжлийн урт, дунд хугацааны стратеги төлөвлөгөө, хөтөлбөр, бодлогын бичгийн хүрээнд хэрэгжиж байгаа төслийг ойлгоно.

Захиалгат төсөл. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан арга хэмжээ болон төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллага, агентлаг, аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны тулгамдсан асуудлыг судалж шийдвэрлэхэд чиглэсэн төсөл юм.

Гадаадтай хамтарсан төсөл. Монгол Улсын Засгийн газар, шинжлэх ухаан, технологийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагаас гадаад улс, олон улсын байгууллагатай хамтран ажиллах гэрээ (хэлэлцээр)-ний хүрээнд хэрэгжүүлэх 2 болон олон талт төслийг ойлгоно.

Технологийн туршилт, зүгшрүүлэлтийн төсөл. Лабораторийн түвшинд боловсруулсан технологи, бүтээгдэхүүний загварыг үйлдвэрлэлийн нөхцөлд турших, боловсронгуй болгох, технологийн баримтжуулалт хийх үйл ажиллагаа юм.

Цөм технологийн төсөл. Засгийн газраас баталсан шинжлэх ухаан, технологийн тэргүүлэх чиглэл, цөм технологийн жагсаалтад хамаарах технологийн судалгаа боловсруулалтын ажлыг хэрэгжүүлэх төслийг ойлгоно.

СХА-д ордоггүй бусад ШУТ-ийн үйл ажиллагаа: СХА-д орохгүй боловч ШУТ-ийн үйл ажиллагаанд багтдаг шинжлэх ухаан, техникийн боловсрол сургалт, шинжлэх ухаан технологийн үйлчилгээнүүдийн тоо болон зардлыг бүртгэнэ.

Шинжлэх ухаан, техникийн боловсрол, сургалтад эрдэмтэд болон инженерүүдэд зориулсан дараах боловсрол, сургалтын үйл ажиллагаануудыг хамруулж авч үзнэ. Үүнд: Их, дээд сургуулийн мэргэшлийн бус боловсрол, сургалт; Дээд боловсролын зэрэг олгох

боловсрол, сургалт; Төгсөлтийн дараах болон нэмэлт сургалт; Насан туршийн боловсрол, сургалт;

Шинжлэх ухаан, технологийн үйлчилгээнд дараах үйлчилгээнүүдийг ойлгоно. Үүнд:

- Номын сан, архив, мэдээлэл лавлагааны төвүүд, эрдэм шинжилгээний төвүүд, мэдээлэл боловсруулалтын алба газруудаас үзүүлж буй үйлчилгээнүүд,
- Шинжлэх ухааны болон технологийн музей, амьтны хүрээлэн, ботаник цэцэрлэг, бусад антропологи, археологи, геологийн чиглэлийн байгууллагуудын үйлчилгээ,
- ШУТ-ийн ном, хэвлэлийн орчуулга (ерөнхий болон их, дээд сургуулийн ном сурах бичгээс бусад),
- Байр зүй, геологи, гидрологийн хэмжилт; одон орон, цаг уур, газар хөдлөлийн байнгын ажиглалт; хөрс, ургамал, загас, ан амьтны нөөцийг судлах; хөрс, агаар мандал, усны ердийн туршилт; цацраг идэвхт байдлын түвшинг тогтмол хянах үйлчилгээнүүд;
- Газрын тос, ашигт малтмалын нөөцийг тогтоох, тодорхойлоход чиглэсэн хайгуулын болон бусад холбогдох үйл ажиллагаа;
- Хүн ам, нийгэм-эдийн засгийн юмс үзэгдлийг судлах, танин мэдэх зорилгоор өгөгдөл цуглуулах (хүн амын тооллого, үйлдвэрлэл, түгээлт, нийгэм, соёлын статистик гэх мэт)
- Сорил тавих, стандартчилал, чанарын хяналт, хэрэглэгчдэд өгөх зөвлөгөө үйлчилгээ,
- Төрийн байгууллагын патент, лицензийн үйл ажиллагаа г.м.

ШУТ-ийн мэдээллийн үйлчилгээ. Номын сан, архив, мэдээлэл лавлагааны төвүүд, эрдэм шинжилгээний төвүүд, мэдээлэл боловсруулалтын алба газруудаас үзүүлж буй үйлчилгээнүүд.

Сорил тавих, стандартчилах. Бүтээгдэхүүн, үйлчилгээний харилцан орлуулалт, мэдээлэл, техник, хэмжилт, сорилтын нэгдмэл, нийцтэй, аюулгүй байдлыг хангах зорилгоор нийтээр, дахин давтан хэрэглэх журам тогтоох үйл ажиллагааг ойлгоно.

ТЭЗҮ. ТЭЗҮ нь санал болгож буй инженерийн ухааны төсөл хэрэгжих боломжтой эсэхийг шийдвэрлэх, нэмэлт мэдээлэл олж авах зорилготой судалгаа юм. Өөрөөр хэлбэл тухайн төслийн хэрэгжих боломжийн судалгаа бөгөөд тойм судалгаа, урьдчилсан ТЭЗҮ, нарийвчилсан ТЭЗҮ гэсэн хэлбэртэй байж болно.

Мэргэжлийн эрүүл мэндийн судалгаа: Анагаахын тусгай мэдлэгийн хэрэглээний судалгаа, давтан судалгааг хамааруулна.

Патент, лицензийн гэрээ. Энд лиценз өгөгч тухайн шинэ бүтээлийг гэрээнд заасан нөхцөл хэмжээгээр үйлдвэрлэлд нэвтрүүлж ашиглах эрх зүйн болон хэрэгжүүлэх бодит нөхцөлөөр лиценз авагчийг хангах, харин лиценз авагч нь ямар нэг хэлбэрээр түүнд нөхөн төлбөр олгох тухай гэрээг ойлгоно.

Бодлогын судалгаа. Бодлогын судалгаа нь нийгэм, эдийн засгийн болон улс төрийн янз бүрийн асуудлуудад чиглэдэг бөгөөд тэдгээр үзэгдлийг бүрэн үнэлж ойлгохын тулд тухайн асуудлын цаана байгаа учир шалтгааныг тодорхойлох, зорилго, зорилтод хүрэх арга замыг тодорхойлох арга зам бүхий судалгаа юм.

Программ хангамжийн хөгжүүлэлт: Тодорхой ажлын хүрээнд хийгдэж буй программ хангамжийн хөгжүүлэлт, систем бүтээх, шинэчлэлт хийх болон компьютерын архитектурын ажлуудыг ойлгоно.

Бизнесийн судалгаа. Бизнесийн судалгаа нь бүтээгдэхүүн, үйлчилгээний шинж чанар, нийлүүлэлтийн байдал, бизнесийн нөхцөл боломж болон худалдан авалтын шийдвэр гаргалтын тухай мэдээллийг цуглуулах тасралтгүй үйл ажиллагаа юм. Бизнесийн судалгааг тухайн хувийн байгууллагууд дотооддоо болон бусад мэргэжлийн байгууллагуудаар гүйцэтгүүлдэг бөгөөд өрсөлдөгчийн, хэрэглэгчийн, зан төлөвийн, сэтгэл ханамжийн гэх мэт төрөлтэй байна.

Бусад ШУТ-ийн үйл ажиллагаа: Дээрхээс бусад бүх СХА-д орохгүй шинжлэх ухаан технологийн үйл ажиллагаануудыг ойлгоно. Гэрээт ажил, газар, ус, хөрсний судалгаа г.м.

Гол мөрөн, нуур цөөрөм, загасны чиглэлийн судалгаа. Гол мөрөн, нуур цөөрөм, загасны чиглэлээр гүйцэтгэсэн судалгаа хөгжүүлэлтийн ажлын зардлыг бүртгэнэ.

Зөвлөх үйлчилгээ. Зөвлөх үйлчилгээ гэж гүйцэтгэгчээс төсөл зохиох, хэрэгжүүлэх, сургалт явуулах, техникийн туслалцаа үзүүлэх, судалгаа шинжилгээ хийх, зураг төсөл боловсруулах, гэрээний хэрэгжилтэд хяналт тавих тусгай мэдлэг ур чадварын үндсэн дээр үзүүлж байгаа мэргэжлийн үйлчилгээг хэлнэ. Энэ утгаараа СХА-д орохгүй бусад ШУТ-ийн үйл ажиллагаа нь зөвлөх үйлчилгээ юм.

Баталгаажуулалтын хэсэг:

Мэдээ гаргасан. Тухайн байгууллагын мэдээг гаргасан албан хаагчийн албан тушаал, нэр, гарын үсэг байна.

Мэдээ хянасан. Тухайн байгууллагын мэдээг хянасан албан хаагч албан тушаал, нэр, гарын үсгээ зурж, байгууллагын тамга тэмдгийг дарна.

Огноо. Мэдээ гаргасан он, сар, өдөр байна.

СХА-ЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН 20... ОНЫ МЭДЭЭ /МАЯГТ ШУТ-3/-НИЙ МАЯГТЫГ НӨХӨХ ЗААВАР

I. Ерөнхий мэдээллийн хэсэг

Аж ахуйн нэгж, байгууллагын мэдээлэл. Тухайн аж ахуйн нэгж, байгууллагын нэр, регистрийн дугаарыг улсын бүртгэлийн гэрчилгээнд тусгагдсанаар товчлохгүйгээр нөхнө.

Регистрийн дугаар. Улсын бүртгэлийн газраас олгосон 7 оронтой регистрийн дугаарыг бичнэ. Өөрөөр хэлбэл, тухайн мэдээллийг хариуцаж буй байгууллагын улсын бүртгэлийн дугаарыг бичнэ.

Байгууллагын нэр. Тухайн байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээн дээрх нэрийг товчлохгүйгээр бичнэ.

Аймаг/нийслэл/сум/дүүргийн нэр, код. Аж ахуйн нэгж, байгууллагын аймаг, нийслэл, сум, дүүргийн нэрийг бичиж, кодыг “Монгол улсын засаг, захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн код”-оос харж бөглөнө.

Хариуцлагын хэлбэр. Хариуцлагын хэлбэр нь дараах дэд бүлгээс бүрдэх ба тодорхойлолтын дагуу ойлгоно. Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээнээс хариуцлагын хэлбэрийг нөхөж бичнэ. ХК, ХХК, НҮТББ, ӨҮТББ, төсөвт байгууллага, сан, нөхөрлөл, хоршоо гэх мэт. Тухайн аж ахуйн нэгж, байгууллага нь өөрийн байгууллагын хариуцлагын болон өмчийн хэлбэрийг нөхөхдөө холбогдох кодыг дугуйлна.

Код	Байгууллагын хариуцлагын хэлбэр	Тодорхойлолт
10	Хувьцаат компани	Иргэний хуулийн хоёрдугаар дэд бүлгийн 33 дүгээр зүйл:
11	Хязгаарлагдмал хариуцлагатай компани	<ul style="list-style-type: none"> 34.1.Хувьцаа эзэмшигчийн оруулсан хөрөнгө нь тодорхой тооны хувьцаанд хуваагддаг, өөрийн тусгайлсан хөрөнгөтэй, ашгийн төлөө үндсэн зорилготой хуулийн этгээдийг компани гэнэ. <p>Компанийн тухай хуулийн 2 дугаар бүлэг 3 дугаар зүйл:</p> <ul style="list-style-type: none"> 3.1.Хувьцаа эзэмшигчийн оруулсан хөрөнгө нь тодорхой тооны хувьцаанд хуваагддаг, өөрийн тусгайлсан эд хөрөнгөтэй, үндсэн зорилго нь ашгийн төлөө хуулийн этгээдийг компани гэнэ. 3.4.Компани нь хязгаарлагдмал хариуцлагатай болон хувьцаат компани гэсэн хэлбэртэй байна. 3.5.Хязгаарлагдмал хариуцлагатай компани гэж хувьцаа эзэмшигчийн оруулсан хөрөнгө нь хувьцаанд хуваагдаж, түүнийг захиран зарцуулах эрх нь хууль болон компанийн дүрмээр хязгаарлагддаг компанийг хэлнэ. 3.7."Нээлттэй хувьцаат компани" гэж хувьцаа эзэмшигчийн оруулсан хөрөнгө нь хувьцаанд хуваагдаж, хувьцаа нь үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагад бүртгэгдэж, нийтэд чөлөөтэй арилжаалагддаг компанийг хэлнэ. 3.8."Хаалттай хувьцаат компани" гэж хувьцаа эзэмшигчийн оруулсан хөрөнгө нь хувьцаанд хуваагдаж, хувьцаа нь үнэт цаасны хадгаламжийн үйл ажиллагаа эрхлэх байгууллагад бүртгэгдэж, үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагаас гадуур зах зээлд хаалттай хүрээнд арилжаалагддаг компанийг хэлнэ.
20	Бүх гишүүн нь бүрэн хариуцлагатай нөхөрлөл	Иргэний хуулийн хоёрдугаар дэд бүлгийн 33 дугаар зүйлийн 33.1.Ашгийн төлөө хуулийн этгээдийг нөхөрлөл, компанийн хэлбэрээр байгуулна.
21	Зарим гишүүн нь бүрэн хариуцлагатай нөхөрлөл	35.1.Гишүүдийн оруулсан хувь хөрөнгөөс бүрдэх эд хөрөнгөтэй, хүлээсэн үүргээ уг эд хөрөнгө болон гишүүдийн хувийн өмчийн эд хөрөнгөөр хуульд заасны дагуу хариуцдаг хуулийн этгээдийг нөхөрлөл гэнэ.
22	Хязгаарлагдмал хариуцлагатай нөхөрлөл	Нөхөрлөлийн тухай хуулийн 3 дугаар зүйл: <ul style="list-style-type: none"> Нөхөрлөл дор дурдсан хэлбэрээр зохион байгуулагдаж болно:

		<p>1/ бүх гишүүд нь бүрэн хариуцлагатай; 2/ зарим гишүүд нь бүрэн хариуцлагатай. 3/ хязгаарлагдмал хариуцлагатай.</p> <p>Нөхөрлөлийн тухай хуулийн 19 дүгээр зүйл:</p> <ul style="list-style-type: none"> Нөхөрлөлийн хүлээсэн үүргийг гишүүд нь нөхөрлөлд оруулсан эд хөрөнгө болон хувийн өмчийн эд хөрөнгөөрөө хамтран хариуцдаг нөхөрлөлийг бүх гишүүд нь бүрэн хариуцлагатай нөхөрлөл гэнэ. <p>Нөхөрлөлийн тухай хуулийн 27 дугаар зүйл:</p> <ul style="list-style-type: none"> Нөхөрлөлийн хүлээсэн үүргийг наад зах нь нэг гишүүн нөхөрлөлд оруулсан хөрөнгө болон хувийн өмчийн эд хөрөнгөөрөө бүрэн хариуцдаг, бусад гишүүд нь гагцхүү нөхөрлөлд оруулсан хөрөнгийнхөө хэмжээгээр хариуцдаг нөхөрлөлийг зарим гишүүд нь бүрэн хариуцлагатай нөхөрлөл гэнэ. <p>Нөхөрлөлийн тухай хуулийн 29 дүгээр зүйл</p> <ul style="list-style-type: none"> Хязгаарлагдмал хариуцлагатай нөхөрлөлийг мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл бүхий хоёр ба түүнээс дээш иргэн хамтран байгуулах бөгөөд нөхөрлөлийн үүргийг гишүүд нь нөхөрлөлд оруулсан хөрөнгийн хэмжээгээр, нөхөх хариуцлагыг буруутай үйл ажиллагаа явуулсан гишүүн нөхөрлөлд оруулсан хөрөнгө болон хувийн өмчийн хөрөнгийн хэмжээгээр бүрэн хариуцна.
30	Хоршоо	<p>Иргэний хуулийн хоёрдугаар дэд бүлгийн 33 дугаар зүйл: 33.2. Ашгийн төлөө бус хуулийн этгээдийг холбоо, сан, хоршооны хэлбэрээр байгуулна.</p> <p>36.4.Эдийн засгийн болон нийгэм, соёлын нийтлэг хэрэгцээгээ хангах зорилгоор хэд хэдэн этгээд сайн дураараа нэгдсэн, хамтын удирдлага, хяналт бүхий дундын эд хөрөнгө дээр үндэслэн үйл ажиллагаа явуулахаар байгуулсан хуулийн этгээдийг хоршоо гэнэ.</p> <p>Хоршооны тухай МУ-ын хуулийн 3 дугаар зүйл: 3.1.Эдийн засгийн болон нийгэм, соёлын нийтлэг хэрэгцээгээ хангах зорилгоор хэд хэдэн этгээд сайн дураараа нэгдсэн, ардчилсан хамтын, хамтын удирдлага, хяналт бүхий, дундын эд хөрөнгө дээр үндэслэн үйл ажиллагаа явуулахаар хамтран байгуулсан хуулийн этгээдийг хоршоо гэнэ.</p>
40	Төрийн өмчит үйлдвэрийн газар	<p>Төрийн болон орон нутгийн өмчийн тухай МУ-ын хуулийн 4-р бүлэг 15-р зүйл:</p> <ul style="list-style-type: none"> Төрийн өмчит үйлдвэрийн газар гэдэгт дан ганц төрийн өмчид үндэслэсэн болон улсын төсвөөс санхүүждэг үйлдвэрийн газар орох бөгөөд тэдгээрийг эд хөрөнгийн эрхийн байдлаар нь аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар, улсын төсөвт үйлдвэрийн газар гэж ангилна.

		<ul style="list-style-type: none"> • Өөрт олгогдсон эд хөрөнгийн үндсэн дээр өөрийгөө санхүүжүүлэх зарчмаар ажиллаж бие даан иргэний гүйлгээнд ордог хуулийн этгээдийг аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар гэнэ. • Өөрт олгогдсон эд хөрөнгийн үндсэн дээр төсвийн хөрөнгөөр санхүүждэг, зөвхөн төрийн хэрэгцээнд зориулсан үйлдвэрлэл, ажил, үйлчилгээ эрхэлдэг хуулийн этгээдийг улсын төсөвт үйлдвэрийн газар гэнэ.
41	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар	Орон нутгийн өмчит үйлдвэрийн газар гэдэгт орон нутгийн төрийн өмчид үндэслэсэн болон орон нутгийн төсвөөс санхүүждэг үйлдвэрийн газар орно.
60	Төсвийн байгууллага	<p>Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай МУ-ын хуулийн 4-р зүйл:</p> <p>4.1.4. «Төсвийн байгууллага» гэж төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг улсын буюу орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлдэг байгууллагыг ойлгоно.</p> <p>Төрийн болон орон нутгийн өмчийн тухай МУ-ын хуулийн 4-р бүлэг 13-р зүйл:</p> <ul style="list-style-type: none"> • Төр чиг үүргээ хэрэгжүүлэх болон нийгмийн хэрэгцээг хангах зорилгоор төр өөрийн өмчөөр дангаараа байгуулсан хуулийн этгээдийг төрийн өмчит хуулийн этгээд гэнэ. Төрийн өмчит хуулийн этгээдийг эд хөрөнгийн эрхийн байдлаар нь дор дурдсанаар ангилна: <ul style="list-style-type: none"> 1/ төрийн байгууллага, албан газар; 2/ төрийн өмчит үйлдвэрийн газар. <p>Төрийн болон орон нутгийн өмчийн тухай МУ-ын хуулийн 4-р бүлэг 14-р зүйл:</p> <ul style="list-style-type: none"> • Төрийн өмчит үйлдвэрийн газраас бусад улсын төсвөөс санхүүждэг хуулийн этгээдийг төрийн байгууллага, албан газар гэнэ.
70	Төрийн бус байгууллага	<p>Иргэний хуулийн хоёрдугаар дэд бүлгийн 33 дугаар зүйл:</p> <p>33.2. Ашгийн төлөө бус хуулийн этгээдийг холбоо, сан, хоршооны хэлбэрээр байгуулна.</p> <p>36.1. Нэгдмэл, тодорхой зорилго тавьсан хэд хэдэн этгээд сайн дурын үндсэн дээр нэгдэж байгуулсан, гишүүнчлэл бүхий хуулийн этгээдийг холбоо гэнэ.</p> <p>Төрийн бус байгууллагын тухай хуулийн 1-р бүлэг 4-р зүйл:</p> <p>1/ "төрийн бус байгууллага" гэж иргэд, төрийн байгууллага / хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэх байгууллага/-аас бусад хуулийн этгээдээс нийгмийн болон өөрсдийн ашиг сонирхол, үзэл бодлын үүднээс сайн дурын</p>

		үндсэн дээр байгуулагдан үйл ажиллагаагаа төрөөс хараат бус, өөрийгөө удирдах зарчмаар явуулдаг ашгийн төлөө бус байгууллагыг;
71	Сан	Иргэний хуулийн хоёрдугаар дэд бүлгийн 33 дугаар зүйл 33.2.Ашгийн төлөө бус хуулийн этгээдийг холбоо, сан, хоршооны хэлбэрээр байгуулна. 36.2.Нэг буюу хэд хэдэн үүсгэн байгуулагч нийгэмд ашиг тустай, нэгдмэл зорилгод хүрэхийн тулд эд хөрөнгө төвлөрүүлэх замаар байгуулсан гишүүнчлэлгүй хуулийн этгээдийг сан гэнэ.
80	Бусад	Дээрхээс бусад байгууллага

Өмчийн хэлбэр. Аж ахуйн нэгж, байгууллагын өмчийн хэлбэрийг нөхөхдөө төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд үндэслэсэн ангиллын дагуу холбогдох кодыг дугуйлна.

Код	Өмчийн хэлбэр	Тайлбар
21	Хувийн	<ul style="list-style-type: none"> Төр чиг үүргээ хэрэгжүүлэх болон нийгмийн хэрэгцээг хангах зорилгоор өөрийн өмчөөр дангаараа байгуулсан хуулийн этгээдийг төрийн, өмчит хуулийн этгээд гэнэ. <i>/"Төрийн болон орон нутгийн өмчийн тухай" Монгол Улсын хуулийн 13 дугаар зүйлд зааснаар/</i> Төрийн өмчийн хувьцаатай буюу төр хувь хөрөнгөө оруулсан хуулийн этгээдийг төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд гэнэ. <i>/"Төрийн болон орон нутгийн өмчийн тухай" Монгол Улсын хуулийн 21 дугаар зүйлийн 1-р хэсэгт зааснаар/</i> Төрийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийг бүхэлд нь эсхүл зарим хэсгийг нь хувь нийлүүлж гадаад, дотоодын хөрөнгө оруулагчийн хөрөнгөтэй нийлүүлж хамтарсан үйлдвэр байгуулна. <i>/"Төрийн болон орон нутгийн өмчийн тухай" Монгол Улсын хуулийн 57 дугаар зүйлийн 1-р хэсэгт зааснаар/</i> Хувийн-Иргэн өөрийн хөрөнгөөр байгууллага дангаараа байгуулж үйл ажиллагаа явуулж байгаа бол, гадаадын хөрөнгө оруулалтаар байгуулагдсан байгууллага бол, гадаад улсын иргэн дангаараа байгуулсан байгууллага бол хувийн байгууллага гэсэн ангилалд оруулж ойлгоно. Орон нутгийн-Орон нутгийн өмч нийтийн зориулалттай өмч, орон нутгийн өөрийн өмчөөс бүрдэх ба орон нутгийн өмчийн байгууллага бол, орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн орон нутгийн өмчид ногдох ашгаар олж авсан байгууллага бол, хамтарсан өмчийн хэлбэртэй орон нутгийн байгууллага бол тус тус энэ ангилалд хамааруулан ойлгоно. <p>Шашны өмчийн хэлбэр нь Сангийн сайд, ҮСХ-ны даргын 2018 оны 12-р сарын 31-ний өдрийн 319/ А/160 тоот тушаалаар батлагдсан "Эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангилал"-ын дагуу 9491 буюу Шашны байгууллагын</p>
22	Хувийн /хамтарсан/	
23	Гадаад улсын	
11	Төрийн өмчийн	
12	Төрийн өмчийн оролцоотой	
13	Төрийн өмчтэй хамтарсан	
31	Орон нутгийн өмчийн	
32	Орон нутгийн өмчийн оролцоотой	
33	Орон нутгийн өмчтэй хамтарсан	

		үйл ажиллагаа"-аар тодорхойлогдох боломжтой тул тусгайлан өмчийн хэлбэр үүсгэдэггүй.
--	--	--

Үйл ажиллагааны чиглэл. Улсын бүртгэлийн гэрчилгээн дээрх үндсэн эрхлэх үйл ажиллагааны чиглэлийг кодын хамт бичнэ. Сангийн сайд, Үндэсний статистикийн хорооны дарга нарын хамтарсан 2018 оны 12-р сарын 31-ний өдрийн 319 / А/160 тоот тушаалын нэгдүгээр хавсралтаас Эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангилал, хоёрдугаар хавсралтаас Эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангиллын тодорхойлолтыг үндэслэн нөхөж бичнэ. Тухайн байгууллагын үйлдвэрлэл, үйлчилгээний орлогын дийлэнх хувийг бүрдүүлэгч үйл ажиллагааг үндсэн үйл ажиллагаа гэж тодорхойлно.

Эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангилал (шинэчилсэн хувилбар)-ыг Үндэсний статистикийн хорооны веб хуудас эсвэл эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем /хуулийн веб сайт: <https://www.legalinfo.mn/> / -ээс авч нөхнө.

Байгууллагын ангилал: Судалгаа хөгжүүлэлтийн ажил эрхэлдэг байгууллагын ангиллаас холбогдох ангиллын кодыг дугуйлна.

ЭШБ-ын удирдлагын талаарх мэдээлэл. Энэ хэсэгт тухайн аж ахуйн нэгж, байгууллагын удирдлагын овог нэр, албан тушаал, суурин болон гар утасны дугаар, факс, цахим хаяг зэрэг үзүүлэлтүүдийг товчлохгүйгээр бүтнээр, гаргацтай бичнэ.

Асуулга бөглөсөн албан тушаалтны талаарх мэдээлэл. Энэ хэсэгт тухайн аж ахуйн нэгж, байгууллагын асуулга бөглөсөн албан тушаалтны овог нэр, албан тушаал, суурин болон гар утасны дугаар, факс, цахим хаяг зэрэг үзүүлэлтүүдийг товчлохгүйгээр бүтнээр, гаргацтай бичнэ.

II. СХА-ын санхүүжилтийн эх үүсвэр

СХА-ын санхүүжилтийн эх үүсвэр. СХА-ыг гүйцэтгэхэд зориулж санхүүжилт олгож буй дотоод болон гадаадын нэгжийг ойлгоно. Санхүүжилтийн эх үүсвэрийг төрийн байгууллагын сектор, хувийн хэвшлийн сектор, дээд боловсролын сектор, төрийн бус байгууллагын сектор, гадаад сектор гэсэн 5 секторын ангиллаар бүртгэнэ.

Нийт санхүүжүүлсэн байгууллагын тоо. Энд хэдэн байгууллагаас СХА-д санхүүжилт авсан тоог бөглөнө. Баганын дагуу санхүүжүүлсэн байгууллагын тоог СХА-ын төрөл (суурь судалгаа, хэрэглээний судалгаа, туршилт, зохион бүтээх ажил, СХА-д ордоггүй бусад ШУТ-ийн үйл ажиллагаа)-өөр бүртгэнэ.

Нийт төслийн тоо. Санхүүжилт авсан нийт төслийн тоог бүртгэнэ. Баганын дагуу санхүүжилт авсан нийт төслийн тоог СХА-ын төрөл (суурь судалгаа, хэрэглээний судалгаа, туршилт, зохион бүтээх ажил, СХА-д ордоггүй бусад ШУТ-ийн үйл ажиллагаа)-өөр бүртгэнэ.

Нийт санхүүжилтийн дүн. Санхүүжилт авсан нийт мөнгөн дүнг бөглөнө. Баганын дагуу нийт санхүүжилтийн мөнгөн дүнг СХА-ын төрөл (суурь судалгаа, хэрэглээний судалгаа, туршилт, зохион бүтээх ажил, СХА-д ордоггүй бусад ШУТ-ийн үйл ажиллагаа)-өөр бүртгэнэ.

Суурь судалгааны чиглэлээр авсан санхүүжилт: Суурь судалгааны хүрээнд авсан санхүүжилтийн мөнгөн дүн, төслийн тоо, санхүүжилт авсан байгууллагын тоог тус бүр бүртгэнэ.

Хэрэглээний судалгааны чиглэлээр авсан санхүүжилт: Хэрэглээний судалгааны хүрээнд авсан санхүүжилтийн мөнгөн дүн, төслийн тоо, санхүүжилт авсан байгууллагын тоог тус бүр бүртгэнэ.

Туршилт, зохион бүтээх ажлын чиглэлээр авсан санхүүжилт: Туршилт, зохион бүтээх ажлын хүрээнд авсан санхүүжилтийн мөнгөн дүн, төслийн тоо, санхүүжилт авсан байгууллагын тоог тус бүр бүртгэнэ.

СХА-д ордоггүй бусад ШУТ-ийн үйл ажиллагаа: СХА-д ордоггүй буюу шинжлэх ухаан технологийн үйлчилгээ, боловсрол сургалтын үйл ажиллагаануудын хүрээнд авсан санхүүжилтийн мөнгөн дүн, төслийн тоо, санхүүжилт авсан байгууллагын тоог тус бүр бүртгэнэ.

Төрийн байгууллагын сектор. Төрийн өмчийн улсын болон орон нутгийн төсөвт байгууллага, их дээд сургууль, коллеж, төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгжүүдийг хамруулан ойлгоно.

Улсын төсөвт байгууллагаас. Төрийн өмчийн их сургуулийн ерөнхий санхүүжилтээс бусад улсын төсвийн байгууллагуудаас олгосон санхүүжилтийг ойлгоно. Үүнээс ШУТ сангаас олгож буй санхүүжилтийг бүртгэнэ.

Орон нутгийн төсөвт байгууллагаас. Энд төрийн өмчийн их сургуулийн ерөнхий санхүүжилтээс бусад орон нутгийн төсвийн байгууллагаас олгосон санхүүжилтийг ойлгоно.

Төрийн өмчийн их, дээд сургууль, коллежоос. Төрийн өмчийн их, дээд сургууль, коллежоос авсан санхүүжилтийг ойлгоно. Тус ангиллын санхүүжилтийн эх үүсвэрийг их сургууль, дээд сургууль, коллежоор бүртгэнэ.

Их сургуулиас. Бакалавр, магистр, докторын зэрэг олгох сургалт эрхлэхээс гадна судалгааны ажил зонхилсон лаборатори бүхий эрдэм шинжилгээ-сургалт-үйлдвэрлэлийн нэгдэл хэлбэртэй дээд боловсролын сургалтын байгууллага байх бөгөөд их сургууль нь магистр, докторын сургалт дагнан эрхэлдэг боловсролын байгууллагыг ойлгоно. Энд төрийн өмчийн их сургуулиас авсан санхүүжилтийг бүртгэнэ.

Дээд сургуулиас. Шинжлэх ухааны тодорхой чиглэлээр судалгаа, шинжилгээний ажил явуулж бакалавр болон магистрын сургалт эрхлэх эрх бүхий сургалт-эрдэм шинжилгээний байгууллагыг ойлгоно. Энд төрийн өмчийн дээд сургуулиас авсан санхүүжилтийг бүртгэнэ.

Коллежоос. Дипломын болон бакалаврын сургалт эрхэлдэг сургалтын буюу сургалт-үйлдвэрлэлийн байгууллагыг ойлгоно. Энд төрийн өмчийн коллежоос авсан санхүүжилтийг бүртгэнэ.

Төрийн болон орон нутгийн өмчийн (ТБОНӨ)-ийн аж ахуйн нэгжээс. Энд төрийн болон орон нутгийн өмчийн аж ахуйн нэгж, үйлдвэрийн газруудаас хүлээн авсан санхүүжилтийн хэмжээг ойлгоно.

Хувийн хэвшлийн сектор. Бүх төрлийн бараа, үйлчилгээг үйлдвэрлэж зах зээлд нийлүүлэх, эдийн засгийн хувьд ач холбогдолтой үнээр олон нийтэд борлуулах үндсэн үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллага, компани, корпорац (дээд боловсролоос бусад) зэрэг бүх өмчийн хувийн хэвшлийн байгууллагыг ойлгоно. Хувийн хэвшлийн сектороос олгосон санхүүжилтийн эх үүсвэрийг хувьцаат компани, хязгаарлагдмал хариуцлагатай компани, нөхөрлөл, хоршоо гэсэн ангиллаар бүртгэнэ.

Хувьцаат компани. Нээлттэй болон хаалттай буюу хувьцаа эзэмшигчийн оруулсан хөрөнгө нь хувьцаанд хуваагдаж, хувьцаа нь үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагад бүртгэгдэж, нийтэд чөлөөтэй арилжаалагддаг болон үнэт цаасны хадгаламжийн үйл ажиллагаа эрхлэх байгууллагад бүртгэгдэж, үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагаас гадуур зах зээлд хаалттай хүрээнд арилжаалагддаг компанийг ойлгоно.

Хязгаарлагдмал хариуцлагатай компани. Хувьцаа, түүнийг худалдан авах эрхийн бичиг болон тэдгээрт хөрвөх үнэт цаасыг зөвхөн хаалттай захиалгын үндсэн дээр гаргах бөгөөд бусад үнэт цаасыг нээлттэй болон хаалттай аль ч хэлбэрээр гаргах боломж бүхий байгууллагыг ойлгоно.

Нөхөрлөл, хоршоо. Гишүүдийн оруулсан хувь хөрөнгөнөөс бүрдэх хөрөнгөтэй, хүлээсэн үүргээ энэхүү эд хөрөнгө болон гишүүдийн хувийн өмчийн эд хөрөнгөөр хуульд заасны дагуу хариуцдаг хуулийн этгээдийг нөхөрлөл, эдийн засгийн болон нийгэм, соёлын нийтлэг хэрэгцээгээ хангах зорилгоор хэд хэдэн этгээд сайн дураараа нэгдсэн, ардчилсан хамтын, хамтын удирдлага, хяналт бүхий, дундын эд хөрөнгө дээр үндэслэн үйл ажиллагаа явуулахаар хамтран байгуулсан хуулийн этгээдийг хоршоо гэнэ.

Дээд боловсролын сектор. Энд хувийн өмчийн их, дээд сургууль, коллежийг хамруулан ойлгоно.

Их сургуулиас. Бакалавр, магистр, докторын зэрэг олгох сургалт эрхлэхээс гадна судалгааны ажил зонхилсон лаборатори бүхий эрдэм шинжилгээ-сургалт-үйлдвэрлэлийн нэгдэл хэлбэртэй дээд боловсролын сургалтын байгууллага байх бөгөөд их сургууль нь магистр, докторын сургалт дагнан эрхэлдэг боловсролын байгууллагыг ойлгоно. Энд хувийн өмчийн их сургуулиас авсан санхүүжилтийг бүртгэнэ.

Дээд сургуулиас. Шинжлэх ухааны тодорхой чиглэлээр судалгаа, шинжилгээний ажил явуулж бакалавр болон магистрын сургалт эрхлэх эрх бүхий сургалт-эрдэм шинжилгээний байгууллагыг ойлгоно. Энд хувийн өмчийн дээд сургуулиас авсан санхүүжилтийг бүртгэнэ.

Коллежоос. Дипломын болон бакалаврын сургалт эрхэлдэг сургалтын буюу сургалт-үйлдвэрлэлийн байгууллагыг ойлгоно. Энд хувийн өмчийн коллежоос авсан санхүүжилтийг бүртгэнэ.

Төрийн бус байгууллагын сектор. Төрийн бус байгууллагуудаас санхүүжүүлсэн санхүүжилтийг ойлгоно. Төрийн байгууллагаас олгосон санхүүжилтийг монгол улсын иргэний болон гадаад улсын хамтарсан ТББ-ын ангиллаар бүртгэнэ.

Монгол Улсын иргэний ТББ-аас: Монгол Улсын иргэний өмчийн ТББ-аас олгосон санхүүжилтийн хэмжээг бүртгэнэ.

Гадаад улсын хамтарсан ТББ-аас. Гадаад улсын иргэн, аж ахуйн нэгжийн хамтарсан ТББ-аас олгосон санхүүжилтийн хэмжээг бүртгэнэ.

Гадаад сектор. Гадаад улсад бүртгэлтэй бүх өмчийн аж ахуйн нэгж, хувь хүн, байгууллагуудыг авч үзнэ.

Гадаад улсын Засгийн газар: Монгол Улсаас бусад бүх улсын Засгийн газраас Монгол Улсад гүйцэтгэж буй СХА-д олгосон санхүүжилтийн хэмжээг ойлгоно.

Гадаадын ААН: Монгол Улсаас бусад бүх улсын хувийн өмчийн ААН-үүдийн Монгол Улсад гүйцэтгэж буй СХА-д олгосон санхүүжилтийн хэмжээг ойлгоно.

Гадаадын их, дээд сургуулиуд: Монгол Улсаас бусад бүх улсын их, дээд сургууль, коллежуудын Монгол Улсад гүйцэтгэж буй СХА-д олгосон санхүүжилтийн хэмжээг ойлгоно.

Гадаадын төрийн бус байгууллага: Монгол Улсаас бусад бүх улсын төрийн бус байгууллагуудын Монгол Улсад гүйцэтгэж буй СХА-д олгосон санхүүжилтийн хэмжээг ойлгоно.

Гадаадын ОУБ, төсөл хөтөлбөр: Монгол Улсаас бусад бүх улсын төсөл хөтөлбөрүүд, олон улсын байгууллагуудын Монгол Улсад гүйцэтгэж буй СХА-д олгосон санхүүжилтийн хэмжээг ойлгоно.

Бусад: Дээрхээс бусад ангиллын байгууллага болон хувь хүнийг хамруулж авч үзнэ.

Шинжлэх ухааны салбараар:

Байгалийн ухаан. Математикийн шинжлэх ухаан, Компьютер, мэдээллийн шинжлэх ухаан, Физикийн шинжлэх ухаан, Химийн шинжлэх ухаан, Газар, хүрээлэн буй орчны шинжлэх ухаан, Биологийн шинжлэх ухаан болон бусад дэд байгалийн шинжлэх ухааны салбаруудад гүйцэтгэгдсэн СХА-ын төслийн тоо болон санхүүжилтийн мөнгөн дүнг бүртгэнэ.

Инженер технологи. Иргэний инженерчлэл, Цахилгааны инженерчлэл, Электроникийн инженерчлэл, Мэдээллийн инженерчлэл, Механик инженерчлэл, Химийн инженерчлэл, Материал (түүхий эд) судлал, Анагаах ухааны инженерчлэл, Хүрээлэн буй орчны инженерчлэл, Хүрээлэн буй орчны биотехнологи, Үйлдвэрлэлийн биотехнологи, нано-технологи, бусад инженерчлэл болон технологийн дэд салбаруудад гүйцэтгэгдсэн СХА-ын төслийн тоо болон санхүүжилтийн мөнгөн дүнг бүртгэнэ.

Анагаах ухаан. Анагаах ухааны суурь судалгаа, эмнэл зүйн анагаах ухаан, эрүүл мэндийн шинжлэх ухаан, эрүүл мэндийн биотехнологи болон бусад анагаах ухааны дэд салбаруудад гүйцэтгэгдсэн СХА-ын төслийн тоо болон санхүүжилтийн мөнгөн дүнг бүртгэнэ.

Хөдөө аж ахуй. Газар тариалан, Ой, загас, агнуур, Амьтан, сүү судлал, Мал эмнэлэг судлал, ХАА биотехнологи болон бусад ХАА-н шинжлэх ухааны дэд салбаруудад гүйцэтгэгдсэн СХА-ын төслийн тоо болон санхүүжилтийн мөнгөн дүнг бүртгэнэ.

Нийгмийн шинжлэх ухааны салбар. Сэтгэл судлал, эдийн засаг, бизнес, Боловсрол судлал, Социологи, Хууль, Улс төр судлал, Нийгэм, эдийн засгийн газар зүй, Хэвлэл мэдээлэл, харилцаа холбоо, бусад нийгмийн шинжлэх ухааны салбаруудад гүйцэтгэгдсэн СХА-ын төслийн тоо болон санхүүжилтийн мөнгөн дүнг бүртгэнэ.

Хүмүүнлэгийн шинжлэх ухааны салбар. Түүх, археологи, Хэл, уран зохиол, Философи, ёс зүй, шашин, Урлаг болон бусад хүмүүнлэгийн шинжлэх ухааны дэд салбаруудад гүйцэтгэгдсэн СХА-ын төслийн тоо болон санхүүжилтийн мөнгөн дүнг бүртгэнэ.

Баталгаажуулалтын хэсэг:

Мэдээ гаргасан. Тухайн байгууллагын мэдээг гаргасан албан хаагчийн албан тушаал, нэр, гарын үсэг байна.

Мэдээ хянасан. Тухайн байгууллагын мэдээг хянасан албан хаагч албан тушаал, нэр, гарын үсгээ зурж, байгууллагын тамга тэмдгийг дарна.

Огноо. Мэдээ гаргасан он, сар, өдөр байна.

СХА-ЫН 20... ОНЫ ҮР ДҮНГИЙН МЭДЭЭ /МАЯГТ ШУТ-4/-НИЙ

МАЯГТЫГ НӨХӨХ ЗААВАР

I. Ерөнхий мэдээллийн хэсэг

Аж ахуйн нэгж, байгууллагын мэдээлэл. Тухайн аж ахуйн нэгж, байгууллагын нэр, регистрийн дугаарыг улсын бүртгэлийн гэрчилгээнд тусгагдсанаар товчлохгүйгээр нөхнө.

Регистрийн дугаар. Улсын бүртгэлийн газраас олгосон 7 оронтой регистрийн дугаарыг бичнэ. Өөрөөр хэлбэл, тухайн мэдээллийг хариуцаж буй байгууллагын улсын бүртгэлийн дугаарыг бичнэ.

Байгууллагын нэр. Тухайн байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээн дээрх нэрийг товчлохгүйгээр бичнэ.

Аймаг/нийслэл/сум/дүүргийн нэр, код. Аж ахуйн нэгж, байгууллагын аймаг, нийслэл, сум, дүүргийн нэрийг бичиж, кодыг “Монгол улсын засаг, захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн код”-оос харж бөглөнө.

Хариуцлагын хэлбэр. Хариуцлагын хэлбэр нь дараах дэд бүлгээс бүрдэх ба тодорхойлолтын дагуу ойлгоно. Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээнээс хариуцлагын хэлбэрийг нөхөж бичнэ. ХК, ХХК, НҮТББ, ӨҮТББ, төсөвт байгууллага, сан, нөхөрлөл, хоршоо гэх мэт. Тухайн аж ахуйн нэгж, байгууллага нь өөрийн байгууллагын хариуцлагын болон өмчийн хэлбэрийг нөхөхдөө холбогдох кодыг дугуйлна.

Код	Байгууллагын хариуцлагын хэлбэр	Тодорхойлолт
10	Хувьцаат компани	Иргэний хуулийн хоёрдугаар дэд бүлгийн 33 дүгээр зүйл:
11	Хязгаарлагдмал хариуцлагатай компани	<ul style="list-style-type: none">34.1.Хувьцаа эзэмшигчийн оруулсан хөрөнгө нь тодорхой тооны хувьцаанд хуваагддаг, өөрийн тусгайлсан хөрөнгөтэй, ашгийн төлөө үндсэн зорилготой хуулийн этгээдийг компани гэнэ. Компанийн тухай хуулийн 2 дугаар бүлэг 3 дугаар зүйл: <ul style="list-style-type: none">3.1.Хувьцаа эзэмшигчийн оруулсан хөрөнгө нь тодорхой тооны хувьцаанд хуваагддаг, өөрийн тусгайлсан эд хөрөнгөтэй,

		<p>үндсэн зорилго нь ашгийн төлөө хуулийн этгээдийг компани гэнэ.</p> <ul style="list-style-type: none"> • 3.4.Компани нь хязгаарлагдмал хариуцлагатай болон хувьцаат компани гэсэн хэлбэртэй байна. • 3.5.Хязгаарлагдмал хариуцлагатай компани гэж хувьцаа эзэмшигчийн оруулсан хөрөнгө нь хувьцаанд хуваагдаж, түүнийг захиран зарцуулах эрх нь хууль болон компанийн дүрмээр хязгаарлагддаг компанийг хэлнэ. • 3.7."Нээлттэй хувьцаат компани" гэж хувьцаа эзэмшигчийн оруулсан хөрөнгө нь хувьцаанд хуваагдаж, хувьцаа нь үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагад бүртгэгдэж, нийтэд чөлөөтэй арилжаалагддаг компанийг хэлнэ. • 3.8."Хаалттай хувьцаат компани" гэж хувьцаа эзэмшигчийн оруулсан хөрөнгө нь хувьцаанд хуваагдаж, хувьцаа нь үнэт цаасны хадгаламжийн үйл ажиллагаа эрхлэх байгууллагад бүртгэгдэж, үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагаас гадуур зах зээлд хаалттай хүрээнд арилжаалагддаг компанийг хэлнэ.
20	Бүх гишүүн нь бүрэн хариуцлагатай нөхөрлөл	Иргэний хуулийн хоёрдугаар дэд бүлгийн 33 дугаар зүйлийн 33.1.Ашгийн төлөө хуулийн этгээдийг нөхөрлөл, компанийн хэлбэрээр байгуулна.
21	Зарим гишүүн нь бүрэн хариуцлагатай нөхөрлөл	35.1.Гишүүдийн оруулсан хувь хөрөнгөөс бүрдэх эд хөрөнгөтэй, хүлээсэн үүргээ уг эд хөрөнгө болон гишүүдийн хувийн өмчийн эд хөрөнгөөр хуульд заасны дагуу хариуцдаг хуулийн этгээдийг нөхөрлөл гэнэ.
22	Хязгаарлагдмал хариуцлагатай нөхөрлөл	<p>Нөхөрлөлийн тухай хуулийн 3 дугаар зүйл:</p> <ul style="list-style-type: none"> • Нөхөрлөл дор дурдсан хэлбэрээр зохион байгуулагдаж болно: <p>1/ бүх гишүүд нь бүрэн хариуцлагатай;</p> <p>2/ зарим гишүүд нь бүрэн хариуцлагатай.</p> <p>3/ хязгаарлагдмал хариуцлагатай.</p> <p>Нөхөрлөлийн тухай хуулийн 19 дүгээр зүйл:</p> <ul style="list-style-type: none"> • Нөхөрлөлийн хүлээсэн үүргийг гишүүд нь нөхөрлөлд оруулсан эд хөрөнгө болон хувийн өмчийн эд хөрөнгөөрөө хамтран хариуцдаг нөхөрлөлийг бүх гишүүд нь бүрэн хариуцлагатай нөхөрлөл гэнэ. <p>Нөхөрлөлийн тухай хуулийн 27 дугаар зүйл:</p> <ul style="list-style-type: none"> • Нөхөрлөлийн хүлээсэн үүргийг наад зах нь нэг гишүүн нөхөрлөлд оруулсан хөрөнгө болон хувийн өмчийн эд хөрөнгөөрөө бүрэн хариуцдаг, бусад гишүүд нь гагцхүү нөхөрлөлд оруулсан хөрөнгийнхөө хэмжээгээр хариуцдаг нөхөрлөлийг зарим гишүүд нь бүрэн хариуцлагатай нөхөрлөл гэнэ. <p>Нөхөрлөлийн тухай хуулийн 29 дүгээр зүйл</p> <ul style="list-style-type: none"> • Хязгаарлагдмал хариуцлагатай нөхөрлөлийг мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл бүхий хоёр ба түүнээс дээш иргэн хамтран байгуулах бөгөөд нөхөрлөлийн үүргийг гишүүд нь нөхөрлөлд оруулсан хөрөнгийн хэмжээгээр, нөхөх хариуцлагыг буруутай үйл ажиллагаа явуулсан гишүүн нөхөрлөлд оруулсан хөрөнгө болон хувийн өмчийн хөрөнгийн хэмжээгээр бүрэн хариуцна.
30	Хоршоо	Иргэний хуулийн хоёрдугаар дэд бүлгийн 33 дугаар зүйл:

		<p>33.2. Ашгийн төлөө бус хуулийн этгээдийг холбоо, сан, хоршооны хэлбэрээр байгуулна.</p> <p>36.4.Эдийн засгийн болон нийгэм, соёлын нийтлэг хэрэгцээгээ хангах зорилгоор хэд хэдэн этгээд сайн дураараа нэгдсэн, хамтын удирдлага, хяналт бүхий дундын эд хөрөнгө дээр үндэслэн үйл ажиллагаа явуулахаар байгуулсан хуулийн этгээдийг хоршоо гэнэ.</p> <p>Хоршооны тухай МУ-ын хуулийн 3 дугаар зүйл:</p> <p>3.1.Эдийн засгийн болон нийгэм, соёлын нийтлэг хэрэгцээгээ хангах зорилгоор хэд хэдэн этгээд сайн дураараа нэгдсэн, ардчилсан хамтын, хамтын удирдлага, хяналт бүхий, дундын эд хөрөнгө дээр үндэслэн үйл ажиллагаа явуулахаар хамтран байгуулсан хуулийн этгээдийг хоршоо гэнэ.</p>
40	Төрийн өмчит үйлдвэрийн газар	<p>Төрийн болон орон нутгийн өмчийн тухай МУ-ын хуулийн 4-р бүлэг 15-р зүйл:</p> <ul style="list-style-type: none"> • Төрийн өмчит үйлдвэрийн газар гэдэгт дан ганц төрийн өмчид үндэслэсэн болон улсын төсвөөс санхүүждэг үйлдвэрийн газар орох бөгөөд тэдгээрийг эд хөрөнгийн эрхийн байдлаар нь аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар, улсын төсөвт үйлдвэрийн газар гэж ангилна. • Өөрт олгогдсон эд хөрөнгийн үндсэн дээр өөрийгөө санхүүжүүлэх зарчмаар ажиллаж бие даан иргэний гүйлгээнд ордог хуулийн этгээдийг аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар гэнэ. • Өөрт олгогдсон эд хөрөнгийн үндсэн дээр төсвийн хөрөнгөөр санхүүждэг, зөвхөн төрийн хэрэгцээнд зориулсан үйлдвэрлэл, ажил, үйлчилгээ эрхэлдэг хуулийн этгээдийг улсын төсөвт үйлдвэрийн газар гэнэ.
41	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар	<p>Орон нутгийн өмчит үйлдвэрийн газар гэдэгт орон нутгийн төрийн өмчид үндэслэсэн болон орон нутгийн төсвөөс санхүүждэг үйлдвэрийн газар орно.</p>
60	Төсвийн байгууллага	<p>Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай МУ-ын хуулийн 4-р зүйл:</p> <p>4.1.4. «Төсвийн байгууллага» гэж төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг улсын буюу орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлдэг байгууллагыг ойлгоно.</p> <p>Төрийн болон орон нутгийн өмчийн тухай МУ-ын хуулийн 4-р бүлэг 13-р зүйл:</p> <ul style="list-style-type: none"> • Төр чиг үүргээ хэрэгжүүлэх болон нийгмийн хэрэгцээг хангах зорилгоор төр өөрийн өмчөөр дангаараа байгуулсан хуулийн этгээдийг төрийн өмчит хуулийн этгээд гэнэ. Төрийн өмчит хуулийн этгээдийг эд хөрөнгийн эрхийн байдлаар нь дор дурдсанаар ангилна: <ul style="list-style-type: none"> 1/ төрийн байгууллага, албан газар; 2/ төрийн өмчит үйлдвэрийн газар. <p>Төрийн болон орон нутгийн өмчийн тухай МУ-ын хуулийн 4-р бүлэг 14-р зүйл:</p>

		<ul style="list-style-type: none"> Төрийн өмчит үйлдвэрийн газраас бусад улсын төсвөөс санхүүждэг хуулийн этгээдийг төрийн байгууллага, албан газар гэнэ.
70	Төрийн бус байгууллага	<p>Иргэний хуулийн хоёрдугаар дэд бүлгийн 33 дугаар зүйл:</p> <p>33.2. Ашгийн төлөө бус хуулийн этгээдийг холбоо, сан, хоршооны хэлбэрээр байгуулна.</p> <p>36.1. Нэгдмэл, тодорхой зорилго тавьсан хэд хэдэн этгээд сайн дурын үндсэн дээр нэгдэж байгуулсан, гишүүнчлэл бүхий хуулийн этгээдийг холбоо гэнэ.</p> <p>Төрийн бус байгууллагын тухай хуулийн 1-р бүлэг 4-р зүйл:</p> <p>1/“төрийн бус байгууллага” гэж иргэд, төрийн байгууллага / хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэх байгууллага/-аас бусад хуулийн этгээдээс нийгмийн болон өөрсдийн ашиг сонирхол, үзэл бодлын үүднээс сайн дурын үндсэн дээр байгуулагдан үйл ажиллагаагаа төрөөс хараат бус, өөрийгөө удирдах зарчмаар явуулдаг ашгийн төлөө бус байгууллагыг;</p>
71	Сан	<p>Иргэний хуулийн хоёрдугаар дэд бүлгийн 33 дугаар зүйл</p> <p>33.2. Ашгийн төлөө бус хуулийн этгээдийг холбоо, сан, хоршооны хэлбэрээр байгуулна.</p> <p>36.2. Нэг буюу хэд хэдэн үүсгэн байгуулагч нийгэмд ашиг тустай, нэгдмэл зорилгод хүрэхийн тулд эд хөрөнгө төвлөрүүлэх замаар байгуулсан гишүүнчлэлгүй хуулийн этгээдийг сан гэнэ.</p>
80	Бусад	Дээрхээс бусад байгууллага

Өмчийн хэлбэр. Аж ахуйн нэгж, байгууллагын өмчийн хэлбэрийг нөхөхдөө төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд үндэслэсэн ангиллын дагуу холбогдох кодыг дугуйлна.

Код	Өмчийн хэлбэр	Тайлбар
21	Хувийн	<ul style="list-style-type: none"> Төр чиг үүргээ хэрэгжүүлэх болон нийгмийн хэрэгцээг хангах зорилгоор өөрийн өмчөөр дангаараа байгуулсан хуулийн этгээдийг төрийн, өмчит хуулийн этгээд гэнэ. /“Төрийн болон орон нутгийн өмчийн тухай” Монгол Улсын хуулийн 13 дугаар зүйлд зааснаар/ Төрийн өмчийн хувьцаатай буюу төр хувь хөрөнгөө оруулсан хуулийн этгээдийг төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд гэнэ. /“Төрийн болон орон нутгийн өмчийн тухай” Монгол Улсын хуулийн 21 дугаар зүйлийн 1-р хэсэгт зааснаар/ Төрийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийг бүхэлд нь эсхүл зарим хэсгийг нь хувь нийлүүлж гадаад, дотоодын хөрөнгө оруулагчийн хөрөнгөтэй нийлүүлж хамтарсан үйлдвэр байгуулна. /“Төрийн болон орон нутгийн өмчийн тухай” Монгол Улсын хуулийн 57 дугаар зүйлийн 1-р хэсэгт зааснаар/ Хувийн-Иргэн өөрийн хөрөнгөөр байгууллага дангаараа байгуулж үйл ажиллагаа явуулж байгаа бол, гадаадын хөрөнгө оруулалтаар байгуулагдсан байгууллага бол, гадаад улсын иргэн дангаараа байгуулсан байгууллага бол хувийн байгууллага гэсэн ангилалд оруулж ойлгоно. Орон нутгийн-Орон нутгийн өмч нийтийн зориулалттай өмч, орон нутгийн өөрийн өмчөөс бүрдэх ба орон нутгийн өмчийн
22	Хувийн /хамтарсан/	
23	Гадаад улсын	
11	Төрийн өмчийн	
12	Төрийн өмчийн оролцоотой	
13	Төрийн өмчтэй хамтарсан	
31	Орон нутгийн өмчийн	
32	Орон нутгийн өмчийн оролцоотой	
33	Орон нутгийн өмчтэй хамтарсан	

